

Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

ХОТ СУУРИНЫ ТӨЛӨВЛӨЛТ,
БАРИЛГАЖИЛТЫН НОРМ БА
ДҮРЭМ
БНБД 30-01-24

Албан ёсны хэвлэл

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ЯАМ

Улаанбаатар хот
2024 он

ТӨСӨЛ

Агуулга

1. Хэрэглэх хүрээ.....	2
2. Ишлэл	2
3. Хөгжлийн үзэл баримтлал, нутаг дэвсгэрийн ерөнхий зохион байгуулалт.....	3-6
4. Эдийн засгийн үндэслэл.....	6-10
- Хүн амын төлөвлөлт	
- Төлөвлөлтийн бүтэц, эдийн засгийн зарчим	
5. Суурьшлын бүс. Орон сууц, олон нийтийн үйлчилгээ.....	10-19
6. Барилгажилтын өгөгдөлүүд ба зай хэмжээ	19-22
7. Үйлдвэр, аж ахуйн бүс	23-30
8. Нөхөн сэргээх бүс. Онцгой хамгаалалттай нутаг дэвсгэр.....	30-35
9. Хүрээлэн буй орчин	35-43
10. Тээвэр, гудамж замын сүлжээ	43-58
11. Аюулгүй байдал.....	58-60
12. Инженерийн хангамж	60-74
13. Хавсралтууд.....	75-103
Хавсралт А	(Заавал мөрдөх) Эрх зүйн баримт бичгүүд
Хавсралт Б	(Заавал мөрдөх) Нэр томъёоны тодорхойлолт
Хавсралт Г	(Зөвлөмжийн) Агуулахын эдэлбэр газрын хэмжээ
Хавсралт Д	(Зөвлөмжийн) Олон нийтийн үйлчилгээний ¹ тооцооны норм, эдэлбэр газрын хэмжээ
Хавсралт Е	(Заавал мөрдөх) Авто замын зэрэглэл ба өгөгдлүүд
Хавсралт Ж	(Зөвлөмжийн) Авто бааз, гараашийн эдэлбэр газрын хэмжээ
Хавсралт И	(Зөвлөмжийн) Автомашины зогсоолын тооцооны норматив
Хавсралт К	(Заавал мөрдөх) Галын аюулаас хамгаалах шаардлага
Хавсралт Л	(Заавал мөрдөх) Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан төлөвлөлтийн шаардлагууд
Хавсралт М	(Заавал мөрдөх) Хөдөө аж ахуйн үйлдвэрийн эрүүл ахуйн норм
Хавсралт Н	(Заавал мөрдөх) Монгол орны барилга байгууламж, зураг төслийн төлөвлөлтөнд хэрэглэх уур амьсгалын муж
Хавсралт П	(Заавал мөрдөх) Ахуйн хаягдлын тооцооны норм
Хавсралт Р	(Зөвлөмжийн) Нутаг дэвсгэрийн талбайн баланс
Хавсралт С	(Зөвлөмжийн) Хүн амын хэтийн төлөвийг тооцох аргачлал

¹ Олон нийт, иргэний барилга БНБД 31-03-03/*11; Хавсралт 1

А. Сургалт хүмүүжил

Б. Шинжлэх ухаан, олон нийт, аж ахуйн барилга

В. Эмнэлэг, амралт сувилал, спортын барилга

Г. Худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний барилга

Д. Тээвэр, холбооны барилга

Е. Олон зориулалттай барилга, өрөө тасалгаа

1. Хэрэглэх хүрээ

1.1 Энэхүү норм, дүрмээр Монгол улсын нутаг дэвсгэрийн болон хот, хөдөөгийн суурины төлөвлөлт, барилгажилтын үе шатны зураг төсөл боловсруулахад мөрдөх техникийн шаардлага, нийтлэг хэм хэмжээг тогтооно. Эдгээр шаардлага нь бүс нутаг ба орон нутгийн онцлогийг харгалзан баталсан хот төлөвлөлтийн тогтоосон журмын заалтыг нэмэлтээр мөрдлөг болгон тодорхойлж болно.

1.2 Энэхүү норм, дүрэм нь Монгол улсын хот байгуулалтын үндэс болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах; байгалийн баялгийг зохистой ашиглах; байгаль орчныг хамгаалах, түүх, соёлын дурсгалт зүйлсийг сэргээн хадгалах; хот, суурины нутаг дэвсгэрийг байгалийн ба хүний хүчин зүйлээр үүсч болох сөрөг нөлөөллөөс хамгаалах; хүн амын амьдрах орчин, нийгмийн баталгааг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хэрэгцээт үйлчилгээг бий болгох бүхий л нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3 Монгол улсын хот, хөдөөгийн сууринг төлөвлөх, шинээр байгуулах хот сууринг хөгжүүлж, барилгажуулах үндсэн шаардлагыг агуулсан бөгөөд хүчин төгөлдөр болон мөрдөгдөх хугацаанаас эхлэн хот, хөдөөгийн суурины нутаг дэвсгэрийн өнөөгийн байдал, үл хөдлөх хөрөнгө, амьдрах орчны өөрчлөлтийг харгалзан дахин төлөвлөж, барилгажуулахад мөн адил мөрдөнө.

Хоторхуу суурин (уул уурхай, тээвэр, амралт сувиллын, аялал жуулчлалын), хот маягийн сууринг (хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дагасан) энэхүү нормын жишгээр хүн амын тооцооны дагуу төлөвлөнө.

1.4 Энэхүү норм, дүрэмд хот төлөвлөлтөнд хүн амын хэтийн төлөвийг тооцоолдог үндсэн аргууд, тэдгээрийн тайлбар, тооцооллын томъёо, тооцоонд ашиглах үндсэн үзүүлэлтүүдийн шинж чанар, ямар тохиолдолд тооцооллын аль нэгийг, эсвэл нөгөө аргыг хэрэглэх тэдгээрийн харилцан хамаарлыг тусгасан.

Хот, хөдөөгийн суурины тэг гортигийн гадна байрлах хөдөөгийн суурины статусгүй боловч суурин үүсгэсэн томоохон цогцолбор барилга, байгууламж бүхий нутаг дэвсгэрийн төлөвлөлтийг тухайн орон нутгийн норм дүрмийн дагуу хэрэв норм, дүрэмгүй бол хүн амын тооцооллын тохирох аргачлалыг харгалзан хөдөөгийн суурины төлөвлөлтийн норм, дүрмийг мөрдөнө.

Тайлбар: 1. Хот, хөдөөгийн суурины төлөвлөлтийн зураг төсөл боловсруулахад иргэний хамгаалалтын холбогдох норм, нормативын шаардлагыг тусгана. 2. Шинээр хот байгуулах техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан тухайн хот, суурины төлөвлөлтийг боловсруулна.

1.5 Энэхүү норм, дүрмийг Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар /БД 30-103-21/-ын хамт хэрэглэнэ.

2. Ишлэл

Энэхүү норм, дүрмийн хавсралт А-д ишлэл татсан Монгол Улсын хууль эрх зүйн болон норм, норматив /хэм хэмжээний/-ын баримт бичиг, стандартыг ишлэл болгосон.

Тайлбар: Энэхүү эмхэтгэлийг ашиглахдаа иш татах баримт бичгийг Монгол Улсын албан ёсны сайт, жил бүрийн нэгдүгээр сарын 1-нд хэвлэгддэг “Үндэсний стандарт” мэдээллийн лавлагаас нягтлан үзэж болно. Хэрэв ишлэл баримт өөрчлөгдсөн бол энэхүү эмхэтгэлийг ашиглахад шинэчлэгдсэн хувийг баримтална. Хэрэв ямар нэг шинэчлэн найруулсан найруулгагүйгээр хүчингүй болсон бол иш татаж байгаа тохиолдол нь энэ ишлэлд үл хамаарах нөхцөлд ашиглана.

3. Хөгжлийн үзэл баримтлал /концепци/, нутаг дэвсгэрийн ерөнхий зохион байгуулалт.

3.1 Хот, хөдөөгийн сууринг Монгол Улсын нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн баримт бичгүүд (Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүс нутгийн хөгжлийн төсөл, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөлт)-ийг үндэслэн төлөвлөнө.


3.2 Хот, хөдөөгийн суурины төлөвлөлт, барилгажилтанд Монгол Улсын хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагын баталсан норм, нормативын баримт бичгийг мөрдлөг болгоно.

3.3 Нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн зураг төслийг газарзүйн мужлал, байгалийн нөөцийн зохистой хэрэглээ, хүрээлэн буй орчны хамгаалал, дэд бүтцийн хөгжлийн судалгаа; Монгол Улсын эдийн засгийн бие даасан салбаруудын хөгжлийн бодлого, хөдөөгийн хөгжил, үндэсний тэргүүлэх чиглэлийн төслүүд, улс хоорондын хөгжлийн хөтөлбөрүүд зэргийг үндэслэн байрзүйн зураглал дээр схем, текст хэлбэрээр /тэдгээрийн үндэслэл бүхий материалыг хавсаргана/ боловсруулна.


3.4 Нутаг дэвсгэрийн төлөвлөлтөөр /хот байгуулалтын баримт бичиг²/ Монгол улсын нутаг дэвсгэрийн болон хот, суурины тэнцвэртэй хөгжил, хүн амын тогтвортой суурьшлын орон зай, бүс нутгийн **хөгжлийн концепци** тодорхойлогдоно.

Хөгжлийн концепци нь тухайн нутаг дэвсгэрийг хамарсан эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны болон бусад салбаруудын урт, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн шийдлүүдийг баталгаажуулна.

3.5 Нутаг дэвсгэрийн хөгжлийг тэнцвэржүүлэх зорилгоор төлөвлөлтийг бүсүүдийн нутаг дэвсгэрийн тодорхой орон зайн хүрээнд дараахи жишиг загвар, арга зүйг баримтлан боловсруулж болно.



Загвар 3.1
Орон зайн төлөвлөлтийн хамрах хүрээ /шүхэр ойлголт/



Загвар 3.2
Орон зайн төлөвлөлтийн хамрах хүрээ /шинэ парадигм³/

² Хот байгуулалтын тухай хууль

3.1.4. "хот байгуулалтын баримт бичиг" гэж нутаг дэвсгэр, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, түүний суурь судалгааг;

3.1.6. "хот байгуулалтын норм ба дүрэм, журам" гэж хот байгуулалт, хот төлөвлөлтөд мөрдөх нийтлэг шаардлагын хэм хэмжээг тусгасан техникийн норматив баримт бичгийг;

³ Парадигм- Чөлөөт нэвтэрхий толь Википедия

К общепринятым парадигмам относятся **образцовый метод принятия решений**, модели мира или его частей (отраслей, областей знаний, сфер жизни и деятельности), принимаемые большим количеством людей.

3.6 Нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийн орон зайн төлөвлөлтөд дараахи асуудлуудыг харгазан үзнэ. Үүнд:

- Улс, нийслэл, аймаг /бүс нутаг/, хот, суурины эдийн засгийн хөгжлийг хүчирхэгжүүлэх;
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн ялгааг тодорхойлж тэнцвэржүүлэх, сул хөгжилтэй, орхигдсон шинэ орон зайг хөгжүүлэх, дэмжих;
- Хот, суурины нутаг дэвсгэрийн хөгжлийн таталцал, хөдөөгийн орон зайн хүн амын тогтвортой суурьшлыг татах чадавхийг нэмэгдүүлэх, харилцан уялдаатэй хөгжих эдийн засгийн нөхцөл боломжийг тодорхойлох;
- Үзэсгэлэнт байгаль, үнэ цэнэтэй орон зайн хөгжил, урт хугацаанд хөгжих хөдөлгөөнт байдлыг хангах;
- Хөгжил нь хязгаарлагдмал, байгаль, газарзүйн хүндрэлтэй нөхцөл бүхий хот, суурины далд хэлбэрээр хадгалагдаж буй хөгжлийн нөөц боломжуудыг нээж тэргүүлэх чиглэл, төсөл болгон хөгжлийн гарцыг тодорхойлох

3.7 Хот, суурины хөгжлийн концепци нь төрийн эрх баригчид, нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн хот, суурины төлөвлөлтийг ухамсартай, зөв, үр ашигтай удирдан чиглүүлэх, тууштай хэрэгжүүлэх хөтөлбөр болох ёстой.

3.8 Нийслэл хот, хотын хөгжлийн концепци ерөнхий төлөвлөгөөнөөс ангид бие даасан баримт бичиг байж болно. Хоторхуу суурин, хот маягийн суурины хөгжлийн концепцийг ерөнхий төлөвлөгөөний бүтцэд төлөвлөлтийн эхний үе шатны хэрэгжилтийг хамруулан боловсруулна.

3.9 Хөгжлийн концепцоор нэгдүгээрт, хот, хөдөөгийн суурины хүн ам таатай амьдрах, өрсөлдөх чадвартай бүтээлч эдийн засагтай байх сэтгэл татам ирээдүйн дүр төрхийг; хоёрдугаарт, хөгжлийн эдийн засгийн үндэслэл болох хамгийн чухал чиглэл, зарчим, давуу талуудын зорилтуудыг тодорхойлно.

3.10 Нийслэл хот болон хотын хөгжлийн концепци боловсруулахад бусад хот, суурин газруудтай харилцан уялдаатай хамтдаа хөгжих, эрчимтэй хөгжлийн туйлыг олох; тогтвортой хөгжлийн тулгуур, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хөгжил нь ижил, тэнцвэртэй байх; амьдрахад таатай бөгөөд боломжтой татах хүчтэй, тэнцвэртэй хөгжлийг хангах зарчим баримтлана.

3.11 Амьдрахад таатай бөгөөд боломжтой хотын төлөвлөлтөнд хүрээлэн буй /байгалийн болон хүний гараар бүтээсэн/ орчныг цогцоор төлөвлөх; ногоон орон зайг хамгаалах, нэмэгдүүлэх замаар байгалийн үзэсгэлэнт элементүүдийг хотын бүтцэд хамааруулах; зэргэлдээх хот, суурин газруудын хөгжлийн хуваарьлалт, үүрэг зорилтуудыг тодорхойлж хүчирхэгжүүлэх хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ.

3.12 Хот, хөдөөгийн сууринг Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын системийг бүрдүүлэгч үндсэн элемент гэж үзэн тухайн хот, суурины харьяагдах нэгж⁴ийн нутаг дэвсгэрийн хүрээнд, нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн баримт бичигт заасан ёсоор, орон нутгийн ашиг сонирхол, нийгэм, эдийн засаг, экологийн болон бусад хүчин зүйлсийг харгалзан нутаг дэвсгэрийн ашиглалтын зориулалтыг тодорхойлж төлөвлөнө.

3.13 Хөдөөгийн суурины хөгжлийн хэтийн төлөвийг орон нутгийн нутаг дэвсгэрийн төлөвлөлт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн болон амралтын цогцолбор түүнчлэн үйлдвэр

⁴ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2020 он 4.1.1."нэгж" гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог;

албан байгууллагын хөдөө аж ахуй, туслах аж ахуй байгуулах нөхцлийг бодолцсон тооцоонд үндэслэн тодорхойлсон байна.

3.14 Хот, суурины төлөвлөлтийн зураг төслийг суурь судалгаа, экологи хот байгуулалтын үнэлгээ; дүн шинжилгээ; төлөвлөлтийн үндсэн шийдэл; хэрэгжүүлэх арга зам, хөрөнгө оруулалтын томсогосон өртөг гэсэн бүрдэлтэй, ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн концепци; хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө; барилгажилтын төсөл; техник эдийн засгийн үндэслэл; барилга, байгууламжийн тохижилтын зураг төслийн үе шатуудтай боловсруулна.

3.15 Нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн баримт бичигт орон нутгийн өргөжин хөгжих үр ашигтай дарааллыг зайлшгүй харгалзан үзнэ. Үүнд тухайн суурины төлөвлөлтийн хугацаанаас цааших хөгжлийн төсөөллийг нутаг дэвсгэрийг хөгжүүлэх зарчмын шийдэл, төлөвлөлтийн бүтэц, газар ашиглалтын зориулалт /бүсчлэл/; инженерийн болон тээврийн дэд бүтэц, хүрээлэн буй орчны хамгаалал, байгалийн нөөцийн зохистой ашиглалт зэргийг хамруулан зайлшгүй тодорхойлно.

Хот, хөдөөгийн суурины хөгжлийн тооцоот хугацаа 20 хүртэл жил харин хот байгуулалтын төсөөллийг 30-40 жилээр төлөвлөж болно.

3.16 Төлөвлөлтийн хугацаан дахь хүн амын тооноос хамааруулан хот, хөдөөгийн сууринг хүснэгт 3.1-ийн дагуу ангилана.

Хүснэгт 3.1

Хот, суурины ангилал	Хүн ам, мянган хүн	Тайлбар
Хот		
Их хот	500.0 дээш	Нийслэл хот
Том хот	100.0-500.0	Бүсийн хөгжлийн тулгуур төв хот /улсын зэрэглэлтэй/
Дунд хот	50.0-100.0	Орон нутгийн төв хот /аймгийн зэрэглэлтэй/
Бага хот	15.0-50.0 хүртэл	Бүлэг суурингийн төв, хилийн боомт
Суурин		
Хоторхуу суурин	0.5-15.0	/Уул уурхай, тээвэр, амралт, сувилал, аялал жуулчлал, чөлөөт бүс, тосгон/
Хот маягийн суурин	0.5-10.0	/Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл/
-Байнгын суурин		/сум, багийн төв/
-Байнгын бус суурин		/өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа/

3.17 Хот, хөдөөгийн суурины хөгжлийн нутаг дэвсгэрийг техник-эдийн засгийн болон эрүүл ахуйн үзүүлэлтүүд, түлш-эрчим хүч, усны нөөц, хүрээлэн буй орчны тогтоц болон бусад хүчин зүйлүүдийн хувьсал өөрчлөлт тэдгээрийг зохистой ашиглах боломжийг тооцсон архитектур төлөвлөлтийн харьцуулсан хувилбаруудад үндэслэн сонгоно. Үүнд, оршин суугчдын таатай амьдрах нөхцөлийг хангахын тулд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, байгалийн зүй тогтолыг алдагдуулахгүй байх нөхцөлийг тооцож төлөвлөнө.

3.18 Төлөвлөлтөд эдийн засаг-газар зүйн, нийгэмийн, үйлдвэрлэлийн, түүх-архитектурын болон байгалийн нөхцөл, нөөцийн иж бүрэн үнэлгээг үндэслэл болгоно. Ингэхдээ:

- Засаг захиргааны байдал, хүн ам, эдийн засгийн үндэс, нутагшилтын системд /агломераци/ гүйцэтгэх үүрэг түүнчлэн байгаль цаг уурын, нийгэм-хүн амын өсөлтийн, нийгэм ахуйн /оршин суугчдын амьдрах нөхцөл, амьдралын хэв маягт үзүүлэх нөлөө/, орон нутгийн бусад онцлогийг тооцох;

- Хотын болон хот орчмын нутаг дэвсгэрийн бүсчлэл түүний нөөц (усны, эрчим хүчний, хөдөлмөрийн, нөхөн сэргээх)-ийн зохистой ашиглалт, эдийн засгийн өсөлт, өөрчлөлтийн төлөв, хүрээлэн буй орчин түүний оршин суугчдын амьдрах нөхцөл, амьдралын хэв маягт

үзүүлэх нөлөө, бүс нутаг хоорондын шилжилт хөдөлгөөн, нийгэм-хүн амын өсөлтийг тооцсон цогц үнэлгээг үндэслэл болгох;

- Хүрээлэн буй орчны экологи- эрүүл ахуйн байдлыг сайжруулах, түүх соёлын өвийг хадгалах асуудлуудыг урьдчилан тооцох;

- Хот, суурины нийгэм, эдийн засаг, экологийн хөгжлийн хэтийн төлөв болон төлөвлөлтийн эхний ээлж, дарааллыг оновчтой тодорхойлох;

- Байгалийн нөхцөл нөөцийн үнэлгээний хүрээнд Монгол орны уур амьсгалын бүсчлэлд нийцсэн орон сууцны загварыг тодорхойлж нийгэм, соёлын үнэ цэнэ онцлогийг илэрхийлсэн орон нутгийн архитектурын үндэсний өвөрмөц дүр төрхийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох;

- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөгжлийн ирээдүйг тодорхойлон, төрийн бус хөрөнгө оруулалт татан замаар газар эзэмших боломж болон иргэд, хуулийн этгээдэд хот, хөдөөгийн суурины нутаг дэвсгэрт эдэлбэр газар худалдах эсвэл түрээслэх эрх олгох боломж зэргийг тооцох

3.19 Хот, хөдөөгийн суурины нутаг дэвсгэрийн төлөвлөлтөнд хүн амын нийгмийн нөхөн сэргээлтийн болон хүнсний хангамж, нийтийн аж ахуйн зориулалтын газрыг /нийтийн тээврийн хэрэгслээр нэг цагаас ихгүй хугацаанд хүрэх/ тооцсон байх ёстой. Хот, суурин орчмын нутаг дэвсгэрийн хязгаарыг дагуул, хаяа хот, суурин хоорондын таталцлын оновчтой хүрээг харгалзан тодорхойлно.

3.20 Хот, суурин орчмын нутаг дэвсгэрт нисэх буудал; тээвэрлэхэд эмзэг, түргэн гэмтдэг хүнсний үйлдвэр /ногоо, өндөг, жимс, жимсгэнэ/; дэд бүтэц, туслах аж ахуй, хөдөө аж ахуйн цогцолборууд, агуулах зоорийн байгууламж; хотын хүн амын түр хугацааны амралт зугаалгын газар; хүүхдийн зуслан; хотын бичил уур амьсгалыг сайжруулах усан сан, хамгаалалтын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн; морь барианы газар, хог хаягдал, оршуулгын газар төлөвлөхийг зөвшөөрнө. Мөн хуурай болон агаарын замын боомт, аэродромын аюулгүйн бүс болон ногоон бүсийн хязгаарлалтыг тооцсон байх ёстой.

3.21 Хот, суурин орчмын нутаг дэвсгэрийг, байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг хангах зарчмын хүрээнд ашиглалтын зориулалтаар ангилан зөвшөөрөгдөх болон хязгаарлах ашиглалтыг тодорхойлж төлөвлөнө. Үүнд:

- Хөдөө аж ахуй, хот нийтийн аж ахуйн зориулалтын газар, дагуул, хаяа хот, суурин;
- Ногоон бүсийн зориулалтын газар /зуслан, амралт, сувилал, тусгай хамгаалалттай газар нутаг- аялал жуулчлал/;
- Хот, суурины эдэлбэр газар, барилгажих нөөц талбай.

Тайлбар: 1. Төлөвлөлтөд Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар /БД 30-103-21/-ыг мөрдөнө. 2. Хот, суурин орчмын нутаг дэвсгэрт эдлэн газартай болон эдлэн газаргүй нам давхрын сууцны хороолол төлөвлөж болно. 3. Хот маягийн суурин (сумын төв)-ы төлөвлөлтөнд харилцан хамаарал бүхий байнгын бус суурин (баг, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа)-ы тогтолцоог нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгдмэл байдлаар төлөвлөнө.

4 Төлөвлөлтийн эдийн засгийн үндэслэл

Хүн амын төлөвлөлт

4.1 Хүн амын хэтийн төлөвийн тооцоо нь нутаг дэвсгэрийн төлөвлөлт болон хот, суурины ерөнхий төлөвлөгөөний хамгийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг болно.


Хүн амын хэтийн төлөвийг тооцоолсноор тухайн нутаг дэвсгэр; хот, суурин оршин тогтнох, хөгжих үндэс болох хүн амын суурьшил; хот, суурины барилга, байгууламж; гудамж замын сүлжээ; инженерийн дэд бүтцийн хүчин чадал зэрэг бүхий л үзүүлэлтийг тооцох тэдгээрт шаардагдах газар нутаг, талбайн хэрэгцээг тодорхойлох үндэс суурь бүрдэнэ.

4.2 Хүн амын хэтийн төлөвийг хүн амын өсөлтийн болон хөдөлмөрийн балансын арга гэсэн үндсэн хоёр аргаар тооцно.

Хүн амын өсөлтийн арга нь хүн амын тоо, хот, хөдөөгийн хүн ам, хүн амын ердийн өсөлт ба механик өсөлт (шилжилт хөдөлгөөн), хүн амын нас, хүйсийн бүтэц гэх мэт хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдэд, хөдөлмөрийн балансын арга нь хүн амын хөдөлмөрийн харилцааны үндсэн дээр тодорхойлогдсон үзүүлэлтүүд (хөдөлмөрийн нөөцийн тэнцэл) дээр суурилан тооцоологдоно.

Тайлбар: 1. Хүн амын хэтийн төлвийн тооцоонд тухайн нутаг дэвсгэрийн ирээдүйн хөгжлийн өгөгдөл ундны усны нөөц, газар нутгийн багтаамж, экологийн даац хамаарна. 2. Нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээний үр дүнд үндэслэн хүн амын багтаамжийг /Хавсралт П/ байгалийн нөөц, үйлдвэр болон иргэний барилга, байгууламжийн талбайд орших хүн ам, ус, рекрацийн нөөц, хот, суурин орчмын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийн асуудлуудтай харилцан уялдаатайгаар тооцно. 3. Мөн хот, хөдөөгийн суурины засаг захиргааны бүтэц, байршил болон нутагшилт суурьшлын системд гүйцэтгэх үүрэг түүнчлэн байгаль цаг уурын болон орон нутгийн бусад онцлогуудыг харгалзсан байна.

Схем 1. Хүн амын хэтийн төлөвийг тооцох арга, харилцан хамаарал



4.3 Улсын хэмжээний томоохон нутаг дэвсгэр /бүс нутаг/-ийн төлөвлөлтөд хүн амын хэтийн төлөвийг хүн амын өсөлтийн аргаар тооцоолох ба эдгээр тогтолцоонд хүн ам зүйн байдал тогтвортой байна. Ийм тохиолдолд хүн амын хэтийн төлвийг өсөлтийн аргаар тооцоноор бий болсон үр дүн нь эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход шийдвэрлэх ач холбогдолтой.

4.4 Хот, суурины нутаг дэвсгэрийн хөгжил, тогтвортой суурьшлыг бүрдүүлэх нөхцөл шаардлагаар хүн амын хэтийн төлөвийг нутагшилт, суурьшлын боломжид үндсэлсэн газар нутгийн даацад нийцсэн хүн амын багтаамжаар тооцоолон тодорхойлох аргыг хэрэглэнэ.

Энэ арга нь онцгой зохицуулалттай нутаг дэвсгэрийн нөөц бүхий хот, суурины хүн амын хэтийн төлөвийг тооцоолоход тохиромжтой. Өөрөөр хэлбэл онцгой зохицуулалт бүхий нутаг

дэвсгэрт хүн амын суурьшлыг хязгаарлах бодлогыг хүн амын хэтийн төлөвийг тооцох энэхүү аргаар тооцон тодорхойлно. Хот, суурины төлөвлөлтийн онцлогийг харгалзан тооцоолсон хүн амын тоо нь хот, сууринд төлөвлөгдсөн барилга, байгууламжид ажиллаж буй хүн амын тоотой тохирч байх ёстой.

Тайлбар: 1. Хот бүрдүүлэгч тогтвортой бус суурь бүхий нөөц бүс бий болгосон шинэ хот, сууринд хүн амын хэтийн төлөвийг тооцоход нөөцийн магадлалын зохицлын үндсэн дээр хот, суурины хөгжлийн ерөнхий үзэл баримтлалыг тодотгон, баримтлах нь зүйтэй. Үүний тулд хэд хэдэн тооцооллын аргыг нэгэн зэрэг ашиглах шаардлагатай. Энэ нь мэдэгдэж буй тогтвортой хүчин зүйлсийг үнэн зөв үнэлэх, ирээдүйд гарч болзошгүй хүчин зүйлсийг харгалзан үзэх боломжийг олгоно. 2. Хот, суурины төлөвлөлтийн үе шатаас хамааран хүн амын хэтийн төлөвийг тодорхойлоход "үйлдвэржилтийн мөчлөгийн эрчимжилтийн арга"; "нутаг дэвсгэрийн бүсчлэлийн босгыг харгалзан тооцоолох арга"; "хөгжлийн зорилт, бодлогын дайралтын арга"-уудыг хэрэглэнэ. Үйлдвэржилтийн мөчлөгийн эрчимжилтийн арга нь үйлдвэрлэлийн ямар салбар давамгайлж байгаагаас шалтгаалан тооцоолох арга болно. 3. Нутаг дэвсгэрийн бүсчлэлийн босгыг харгалзан тооцоолох арга нь хот, суурины газар нутгийн тэлэх нөөцийг тодорхойлох, хязгаарлах "босго" бодлогын үндсэн дээр тооцоолох арга болно. Бүтээн байгуулалтаас орхигдсон бүсүүд, янз бүрийн ангиллын орон сууц, үйлдвэрлэлийн аюултэй, эрсдэлтэй барилга, байгууламж бүхий бүс, амралт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүсүүдийг тодорхойлж, "босго" хэмжээнээс хэтэрсэн томоохон, үнэтэй арга хэмжээ авах шаардлагатай хязгаарыг тодорхойлно. 4. Хөгжлийн зорилт, бодлогын дайралтын аргаар зорилтот бүлэг, олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд хүн амын хэтийн төлөвийг тодорхойлно. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн үе шатны дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд тохиромжтой.

Хот, суурины төлөвлөлтийн бүтэц, эдийн засгийн зарчим

4.5 Хот, суурины нутаг дэвсгэрийг төлөвлөхдөө ашиглах зориулалтын дагуу зохион байгуулж бүсчлэх, барилгажилтанд тодорхой ангилал, хязгаарлалт тогтооход анхаарна.

Үүнд, гол төлөв орон сууц, нийтийн хэрэгцээний болон албан газар, оффисийн зориулалтын барилга холимог байрлах газар; үйлдвэрийн байгууламжууд, инженерийн болон тээврийн дэд бүтэц; нөхөн сэргээх нөөц газар; хөдөө аж ахуйн зориулалтын газар; батлан хамгаалах зэрэг тусгай горимын ашиглалт бүхий газар, оршуулгын газар зэрэг хамаарна.

4.6 Онцгой зохицуулалттай болон тусгай горим бүхий газар нутаг, Монгол улсын хууль тогтоомжид заасан соёлын өвийн бүс нь тухайн хот, суурины нутаг дэвсгэрийн бүсүүдийн хилтэй таарахгүй байж болно. Түүхэн хотуудад дурсгалт барилга, байгууламжийн хил хязгаарыг тогтоох ёстой.

4.7 Хот, суурины нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн бүтэц, онцгой зохицуулалт бүхий газрын хил хязгаарыг тогтоох, барилгажуулахад хот байгуулалт, барилгажилтын дүрэм, журам болон хот байгуулалтын, газрын, ойн, байгаль хамгаалалын, эрүүл ахуйн болон бусад хуулиуд энэхүү норм, дүрэмд заасан хориглох хязгаарлалтыг харгалзана. Нутаг дэвсгэрийн бүсийн бүтцэд гудамж талбай, зам гарц, цэцэрлэгт гудамж, усан сан гэх мэт оршин суугчидын нийтийн хэрэгцээний ашиглалтын зориулалтыг тооцсон байна. Нийтийн эзэмшлийн газрын ашиглалтыг орон нутгийн удирдах байгууллага тогтооно.

4.8 Нутаг дэвсгэрийн бүсүүд, тэдгээрийн ашиглалтын зориулалтыг тодорхойлоход хот байгуулалтын онцгой зохицуулалтын хязгаарлалтыг тооцох ёстой. Үүнд: Түүхэн барилгажилт бүхий газар нутаг; дархан цаазтай газар, түүх соёлын дурсгалын бүс; байгалийн онцгой тогтоц бүхий газар түүнчлэн эрүүл ахуйн болон уулын, усны, эрэг орчмын хамгаалалт; ашигт малтмал, байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөнд өртөх (тохиромжгүй) төлөв

бүхий /техногени/ газар; газар хөдлөлт, уулын нуралт, хөрсний гулгалт, суулт, шар усны болон үерийн аюултай газар олборлолт хийж буй газар нутаг хамаарна.

4.9 Үйлдвэр болон бусад объектын эрүүл ахуйн бүс нь тэдгээр объект байрлаж байгаа бүсэд хамаарна. Эрүүл ахуйн бүсийг Монгол улсын Эрүүл ахуйн тухай, Усны тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм журмыг үндэслэн тогтоох ба орон нутгийн эрүүл ахуй, халдвар хамгааллын байгууллагатай зөвшөөрөлцөнө. Цацраг туяаны бохирдол бүхий суурин газрын хөрс, үл хөдлөх хөрөнгийн цацрагийн хорыг арилгах ариутгал, халдваргүйжүүлэлтийг харгалзан тухайн нутаг дэвсгэрийн ашиглалтын зориулалтыг тогтооно.

4.10 Хот, суурины төлөвлөлтөд газар нутгийг үр ашигтай ашиглах, зохистой хуваарилах, нутаг дэвсгэрийн бүсүүдийн харилцан уялдаа; нийтийн үйлчилгээний төвүүд, инженерийн болон тээврийн дэд бүтцийн систем; хот байгуулалт, архитектурын түүх, уламжлал, байгаль цаг уурын болон үндэстний онцлог, хүрээлэн буй орчин, түүх соёлын дурсгалыг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах асуудлуудыг харгалзан үзнэ.

Түүхэн хотуудын архитектурын хэв маяг, төлөвлөлтийг хэвээр хадгалах нөхцлийг бүрдүүлэн түүхэн газруудыг сэргээн байгуулахаар төлөвлөхөд энэхүү норм, дүрмийн есдүгээр бүлгийн холбогдох заалтыг мөрдлөг болгоно. Хөдөөгийн суурины нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг тухайн орон нутгийн төлөвлөлт, зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаатай уялдуулна.

4.11 Нийслэл хот, хотод газар доорх орон зайн ашиглалтыг заавал төлөвлөн, тээвэр, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, үзвэр биеийн тамирын байгууламж, туслах нэмэлт байр, инженерийн байгууламж, үйлдвэрлэл, агуулахын зориулалтаар ашиглах боломжийг тооцох ёстой. Тухайн объект нь орчны эрүүл ахуйн болон галын аюулгүйн шаардлагыг хангасан тохиолдолд аль ч бүсийн газар доорх байгууламжид байршуулахыг зөвшөөрнө.

4.12 Байгалийн аюулт үзэгдэлд өртөх эрсдэлтэй (газар хөдлөлт, цунами, хөрсний гулгалт, суулт нуралт, үер) газар суурьшлын бүс төлөвлөхдөө хамгийн бага эрсдэл хүлээх, авран хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулах боломжтой газар сонгоно. Эрсдэлтэй бүсэд цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын задгай талбай төлөвлөхийг зөвшөөрнө.

Инженер геологийн хүндрэлтэй нөхцөлтэй нутаг дэвсгэрт инженерийн бэлтгэл ажил болон барилгажилт, барилга, байгууламжийн ашиглалтын хамгийн бага зардал шаардагдах нөхцлийг сонгоно.

Газар хөдлөлтийн идэвхтэй бүсийн төлөвлөлтөнд газар хөдлөлийн бичил мужлалыг үндэслэл болгох бөгөөд “Газар хөдлөлтийн идэвхитэй бүс нутагт барилга төлөвлөх” БНБД /22-01-21/-ийг мөрдөнө.

4.13 Хот, суурины эдэлбэр газрын бүтцийг түүний ашиглалтын үндсэн зориулалтаар ангилан бүсчилж хот байгуулалтын үйл ажиллагааны хязгаарлалтыг тодорхойлж төлөвлөнө.

4.14 Хот, суурины эдэлбэр газрын ашиглалтын зориулалтын үндсэн ангилалд суурьшлын; үйлдвэр аж ахуйн; инженерийн болон тээврийн дэд бүтцийн; нөхөн сэргээх амрах зориулалтын; тусгай зориулалтын буюу онцгой дэглэм бүхий тусгай ашиглалтын газар хамаарна.

4.15 Хот, суурины ангилал, онцлогоос шалтгаалан үндсэн ангилал дэд ангилалтай байж болно. Тухайлбал эрүүл ахуйн нормд нийцүүлэн “суурьшил-үйлдвэрлэл-үйлчилгээ”-ний холимог ашиглалтын зориулалт бүхий цогцолбор орон зай /бүс/ төлөвлөхийг зөвшөөрнө.

4.16 Холимог ашиглалтын бүсийг суурьшлын болон үйлдвэр, аж ахуйн зориулалтын газарт байгуулах бөгөөд орон сууц; үйлдвэрлэл; олон нийтийн барилга, байгууламж; боловсрол, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний; бизнесийн байгууллага болон бусад төрлийн барилга (талбайн хэмжээ 5.0 га-аас ихгүй) байгууламж төлөвлөнө.

Тайлбар: 1.Холимог ашиглалтын бүсэд орон сууц, үйлдвэр, аж ахуйн барилга, байгууламжийн төлөвлөлтийн нормын дагуу, галын болон дуу чимээ, цахилгаан соронзон долгион, цацраг туяа, орчны бохирдлын хэм хэмжээг хангасан эрүүл ахуйн 50.0м бүс шаардлагагүй объектууд төлөвлөнө. Энэхүү хэм хэмжээ зөрчигдөх тохиолодолд үйлдвэрийн хүчин чадлыг багасгах, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, үйлдвэрийн бүсэд шилжүүлэхээр төлөвлөнө. 2. Энэхүү цогцолборын талбай хотод 10.0 га, хөдөөгийн сууринд 3.0 га-аас ихгүй байна. Төмөр зам, автомашины хөдөлгөөн холимог ашиглалтын бүсийн талбайг дайран өнгөрөхгүй (нэг чиглэлд хоногт 50 хүртэл тээврийн хэрэгсэл) байх ёстой.

4.17 Хоторхуу суурин, хот маягийн суурины суурьшлын бүсэд хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах бага оврын үйлдвэр үйлчилгээний холимог ашиглалтын зориулалтын цогцолбор барилга, байгууламжаас гадна суурьшлын бүсэд зөвшөөрөгдөх бусад үйлдвэр төлөвлөж болно.

Хоторхуу сууринд эрүүл ахуйн хяналтын байгууллагатай зөвшилцсөний үндсэнд бичил ферм, бага оврын үйлдвэр зэрэг эрүүл ахуйн 50.0м бүс шаардлагагүй хөдөө аж ахуйн объектууд төлөвлөхийг зөвшөөрнө.

4.18 Нутаг дэвсгэрийн ашиглалтын зориулалтын бүсийн хязгаарыг тогтооход гудамж, замын сүлжээ; гудамж, замын улаан шугам; эдэлбэр газрын хил болон байгалийн унаган төрхийг алдагдуулахгүй байх нөхцлүүдийг анхаарна.

5. Суурьшлын бүс. Орон сууц, олон нийтийн үйлчилгээ

5.1 Хот, хөдөөгийн суурины хүн ам ажиллаж, амьдрах эрүүл ахуй, аюулгүйн нөхцөл шаардлагыг хангасан орон зайг суурьшлын зориулалтын газар буюу суурьшлын бүс гэнэ. Суурьшлын бүсэд энэхүү норм, дүрэм зөрчсөн үйлчилгээ, барилга, байгууламж төлөвлөхийг хориглоно.

Суурьшлын бүсэд тухайн хот, суурины онцлогт нийцсэн олон төрлийн орон сууц /олон өрөөтэй олон давхар сууц; эзэмшил газартай дунд болон нам давхар сууц; эдэлбэр газартай сууц, гэр сууц; блокчилсон сууц/ оршин суугчидад үйлчлэх соёл, олон нийтийн үйлчилгээ⁵ний барилга; ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн; гудамж, зам талбай, автомашины зогсоол, гарааш; сүм хийдийн зориулалтын барилга, байгууламж төлөвлөнө.

Тайлбар: 1. Нийтийн үйлчилгээний болон орон сууц ашиглалтын 0.5 га-аас ихгүй эдэлбэр газар бүхий барилга, байгууламжийг орон сууцны дунд төлөвлөхийг зөвшөөрнө. Хүрээлэн буй орчинд хор нөлөөгүй (чимээ шуугиан, чичирхийлэл, соронзон талбай, цацрагын нөлөө, хөрс агаар, ус бохирдуулах болон бусад хэлбэрийн хортой нөлөөлөл) эрүүл ахуйн 25.0 м бүс бүхий үйлдвэрийн барилга, байгууламж төлөвлөхийг зөвшөөрнө. 2. Суурьшлын бүтцэд хот, суурин орчмын бүс дэх эдэлбэр газартай зуслангийн байшин хамаарна.

⁵ **Олон нийт, иргэний барилга** БНБД 31-03-03/*11; Хавсралт 1

А. Сургалт хүмүүжил

Б. Шинжлэх ухаан, олон нийт, аж ахуйн барилга

В. Эмнэлэг, амралт сувилал, спортын барилга

Г. Худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний барилга

Д. Тээвэр, холбооны барилга

Е. Олон зориулалттай барилга, өрөө тасалгаа

5.2 Суурьшлын бүсийг шинээр буюу шинэчлэн төлөвлөхөд түүхэн хөгжлийн явцад бий болсон орон нутгийн архитектурын залгамж чанар, ногоон хөгжлийн зарчимд нийцсэн дэд бүтэц, үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээ, нийтийн амралт, нийгмийн нөхөн сэргээлтийн зориулалтын задгай орон зайн нэгдсэн систем бий болгох зэрэг оршин суугчдын ажиллах, амьдрах эрүүл, аюулгүй орчины асуудлыг иж бүрэн авч үзнэ.

5.3 Суурьшлын бүсийн төлөвлөлтийг тухайн хот, суурины нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн бүтэц, бүсчлэл; байгаль цаг уурын онцлогтой бүхэлд нь уялдуулна. Орон сууц, олон нийтийн үйлчилгээний барилга, байгууламжийн байршил, зам, тээврийн харилцаа, гудамж, замын сүлжээ; ногоон байгууламж болон бусад объектуудыг тооцсон, эрүүл ахуйн норм, галын аюулгүйн шаардлага хангасан байна. Суурьшлын бүсийг салхины зонхилох чиглэлийн дээд талд байрлуулж төлөвлөнө.

5.4 Хот, суурины хүн амын орон сууцны фонд нь улс, орон нутгийн орон сууцны хөтөлбөр, орон сууцны хангамжийн түвшин, оршин суугчдын гэр бүлийн байдал, орлогын түвшин, айл өрх бүрийн нийтийн болон хувийн орон сууцаар хангагдах одоогийн түвшин, ирээдүйн хэрэгцээний судалгаа, эдийн засгийн тооцоогоор тодорхойлогдоно. Орон сууцны фондыг Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн актуудад заасан орон сууцны талбайн норм, хот байгуулалтын баримт бичгийн дагуу тооцно.

5.5 Суурьшлын бүсийн төлөвлөлт зохион байгуулалтад барилгажилтын төрөл, хэв шинж, тэдгээрийн давхаржилт, нягтрал, түүх соёл, байгаль цаг уурын болон бусад онцлогуудыг харгалзан үзнэ. Сууцны барилгажилтын төрөл, давхаржилт нь нийгэм, хүн амын өсөлт үндэстэн ахуйн, архитектурын, эрүүл ахуйн болон бусад шаардлага түүнчлэн нийгмийн хөгжил, тээвэр болон инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх боломж, галын аюулгүй байдлын шаардлага зэргээр тодорхойлогдоно.

Үндэстний цөөнх оршин сууж буй газар нутагт суурьшлын бүсийн төлөвлөлт, барилгажилтанд оршин суугчдын түүхэн хөгжлийн онцлог, амьдралын хэв маягийг зайлшгүй харгалзсан байна.

5.6 Хотын хурдны хөдөлгөөний I, II зэрэглэлийн автозам⁶, ачаа, тээвэр, хөдөө аж ахуйн техник хэрэгсэл зорчих зам, мал тууврын зам суурьшлын бүсийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөхөөр төлөвлөхийг хориглоно.

Орон сууцны хороолол

5.7 Хот, хөдөөгийн суурины суурьшлын бүсийг орон сууцны хороолол, бичил хорооллын зохион байгуулалттай төлөвлөнө.

Нийслэл хот, хотын суурьшлын бүс 250 га-аас ихгүй эдэлбэр газар бүхий орон сууцны хэд хэдэн хороололтой; хоторхуу суурин, хот маягийн суурины суурьшлын бүс нэгдсэн орон сууцны хороололтой байхаар тус тус төлөвлөнө.

Орон сууцны хорооллыг 60.0 га-аас ихгүй эдэлбэр газар бүхий бичил хорооллын; бичил хорооллыг 5.0 га-аас ихгүй эдэлбэр газар бүхий орон сууцны бүлэглэлийн зохион байгуулалттай төлөвлөнө. Шинээр барих орон сууцны иж бүрэн хорооллын эдэлбэр газар 80 га-аас ихгүй байх хэрэгтэй.

Тайлбар: 1.Орон сууцны хороолол, бичил хороолол нь суурьшлын бүсийн төлөвлөлтийн үндсэн бүтэц бөгөөд төлөвлөлтөнд дараах зарчим баримтална. а) орон

Автозам төсөллөх. ЗЗБНБД 22-004-2016

⁶ 9.3. Хотын гол гудамж, замуудыг үндсэн болон туслах гол гудамж, зам гэж хоёр ангилна. Хотын төв замын систем нь гол гудамж, зам болон хурдны замаас бүрдэх бөгөөд том хотуудын төвийн тээврийн үйл ажиллагаа нь хамгийн их хөдөлгөөний эрчимтэй коридорууд буюу хамгийн урт аялалын чиглэл бүхий замын үйлчилгээгээр хангагдана.

сууцны хорооллын эдэлбэр газар гудамж, замын улаан шугамаар хязгаарлагдана; б) орон сууцны хорооллын түүхэн барилгажилт, архитектур - орон зайн зохиомжийн уламжлалт дүр төрхийг аль болох хадгалан орчинтой нь уялдуулах; в) эдэлбэр газрын зориулалт, ашиглалтыг сайжруулах; г) гудамж, замын сүлжээний ангилал, гудамж, замын улаан шугам, барилгажилтын улаан шугамын норматив болон нийгмийн дэд бүтэц, олон нийтийн үйлчилгээний үйлчлэх хүрээг хангах; д. Орон сууцны хороолол нь гол гудамж, замтай шууд холбогдох бөгөөд бичил хорооллын эдэлбэр газрын дундуур нэвт гарах гудамж, зам төлөвлөхийг хориглоно. 2. Орон сууцны барилгын ашиглалт чанар, аюулгүй байдал, төлөвлөлтөнд үлдээх, буулгах асуудлыг тухайн барилга, байгууламжийн техникийн болон эдийн засгийн үзүүлэлт, түүхэн хөгжлийн үнэлэмжийн судалгаа, тооцоог үндэслэн тодорхойлно. 3. Суурьшлын бүсийн цахилгаан соронзон туяаны нөлөөлөл эрүүл ахуйн нормативыг хангасан байна.

5.8 Орон сууцны хорооллын төлөвлөлтийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний үе шатаар; бичил хорооллын төлөвлөлтийг барилгажилтын төслийн үе шатаар тус тус боловсруулна. Түүхэн барилга байгууламж бүхий газрыг иж бүрэн өргөтгөж шинэчлэх дахин төлөвлөлтийн зураг төслийг барилгажилтын төслийн үе шатаар боловсруулж холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай зөвшөөрөлцөнө.

5.9 Орон сууцны хорооллын барилгажилтын давхрын тоо⁷, хэв шинжийг тухайн хот, суурины хүн амын амьдралын хэв маяг, хэрэгцээ, байгаль газарзүйн онцлог, барилгын материалын нөөц, орон нутгийн архитектур, орон зайн зохиомж, инженерийн хангамжийн түвшин зэргийг харгалзан тооцсон техник, эдийн засгийн тооцоог үндэслэн тодорхойлно.

Орон сууцны хорооллын барилгажилт дараахи бүтэцтэй байна.

- Өндөр барилга арвандолоо ба түүнээс дээш давхар;
- Олон давхар барилга долоогоос арван долоон давхар хүртэлх буюу 16 давхар;
- Нам давхар барилга 1-3 давхар;
- Цөөн давхар⁸ барилга 4-6 давхар;
- Эдэлбэр газартай нам давхар сууц, гэр сууц

5.10 Орон сууцны хангамжийн бүтэц, сууцны талбайн доод хэмжээг⁹ хүн амын өсөлт, оршин суугчдын орлогын урьдчилан таамаглаж буй тооцоог үндэслэн тодорхойлно. Ингэхдээ орон сууцны олон төрөл, хэв маягийг тооцож тав тухын түвшингээр нь хүснэгт 5.1-ийн дагуу ангилна¹⁰. Орон сууцны хангамжийн дундаж үзүүлэлт нь тав тухын өөр өөр түвшиний орон сууцны харьцаанаас хамаарах тооцоогоор тодорхойлогдоно.

⁷ Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт /БНБД 31-01-10/

4.2 Орон сууцны барилгын байрлал, түүний эзэмшил газрын хэмжээг БНБД 30-01-04, БНБД 23-04-07-ийн дагуу тогтооно. Барилгын нийт эзэлхүүн давхрын тоо ба урт нь барилгажилтын төслөөр тогтоогдоно. Газар хөдлөлтийн бүс нутаг дахь орон сууцны барилгын давхрын тоо ба нийт уртыг БНБД 22-01-01-ийн дагуу тодорхойлно. Орон сууцны барилгын өндрийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- 1-3 давхар барилгыг нам давхар;
- 4-6 давхар барилгыг цөөн давхар;
- Долоогоос арван долоон давхар хүртэлх буюу 16 давхар барилгыг олон давхар барилга;
- Арван долоо ба түүнээс дээш давхар барилгыг өндөр барилга

⁸ 4.1.1. Цөөн давхар орон сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт /БД 30-101-05 /Цөөн давхар сууцны барилгажилт нь гурав хүртэл давхартай барилгаас бүрдэнэ.

4.1.2. Цөөн давхар сууцны барилгажилт нь ихэвчлэн эдэлбэр газартай нэг айлын ба блокчилсон сууцны барилгаас бүрдэнэ. Заавал мөрдөх хавсралт 1:

Цөөн давхар сууцны барилгажилт - орон сууцны барилгажилтын давхаржилт нь 4 давхар хүртэлх, сууц нь эдэлбэр газартай шууд холбогдсон байх;

⁹ Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10, 5.1 дүгээр хүснэгт

¹⁰ Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10, 2 дугаар хавсралт. Нэр томъёо, түүний тодорхойлолт. 1. Орон сууцны барилга, эдэлбэр газар.

1.2 Нийтийн орон сууц –Өрөө тасалгаа нь хонгилынхоо хоёр талаар жигд байрласан дөрөв ба түүнээс дээш давхар олон хүн нэг дор амьдрах орон сууцны барилга;

Хүснэгт 5.1 Орон сууцны хангамжийн бүтэц

Орон сууцны тав тухын түвшин	Нэг хүнд оногдох талбайн тооцооны норм, м ² /хүн	Орон сууцны нэг байшин ба нэг сууцанд оршин суух хүний тоог тооцох томъёо	Орон сууцны нийт барилгажилтанд эзлэх хувийн жин, %
Тансаг зэрэглэл	40	$k=n+1$ $k=n+2$	$\frac{10}{15}$
Бизнес зэрэглэл	30	$k=n$ $k=n+1$	$\frac{25}{50}$
Ердийн зэрэглэл	20	$k=n-1$ $k=n$	$\frac{60}{30}$
Тусгай зориулалтын	–	$k=n-2$ $k=n-1$	$\frac{7}{5}$

Тайлбар:

- k – орон сууцны нэг байшин, нэг сууцан дахь өрөө, тасалгааны тоо; n – орон сууцны нэг байшин, нэг сууцанд оршин суух хүний тоо.
- Хүртвэрт эхний ээлжин дэх үзүүлэлт; хуваарьт төлөвлөлтийн хугацааны үзүүлэлт
- Энэхүү номатив үзүүлэлтүүд нь ашиглалтын бодит түвшинг тогтоох үндэслэл болохгүй.

Тайлбар: Орон сууцны төрөл, хийц, хот, суурины онцлог, хүн амын өсөлтийг харгалзан эдэлбэр газрын хэмээг Газрын тухай хууль болон энэхүү нормын хүснэгт 5.2-ын дагуу тооцож төлөвлөх ба Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм /БНБД 31-01-10/ болон Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт, зохион байгуулалт, барилгажуулалт /БД 30-101-05/-ын хүснэгт 1-ийг мөрдөнө.

5.11 Үндэсний орон сууц-гэр сууцыг эдэлбэр газартай нам давхар орон сууцны адилаар эрүүл ахуй, аюулгүйн болон нийгмийн үйлчилгээний иж бүрэн хангамжтай байхаар тооцож суурьшлын бүсийн бүтцэд орон сууцны хорооллын зохион байгуулалттайгаар бусад хорооллуудтай нэгдмэл цогц байдлаар төлөвлөнө.

Хүснэгт 5.2 Нам болон дундаж давхрын орон сууцны эдэлбэр газрын зөвшөөрөгдөх хэмжээ

	Эдэлбэр газрын хэмжээ /м ² /	Хот, суурины ангилал	Тав тухын түвшин	Тайлбар
1.	600-700	Хот, хөдөөгийн суурин болон хот, суурин орчмын бүсэд	-Тансаг зэрэглэл (дээд)	Инженерийн хэсэгчилсэн хангамжтай, таун хаус, твин хаус загварын орон сууц
2.	300-600		-Тансаг зэрэглэл (дээд) -Бизнес зэрэглэл (дунд)	Инженерийн хэсэгчилсэн хангамжтай, коттедж загварын орон сууц
3.	100-300	Нийслэл хот, хотод	-Ердийн зэрэглэл (нийтийн орон сууц)	Инженерийн төвлөрсөн хангамжтай, коттеж, блокчилсон болон террас загварын орон сууц
4.	60-100			
5.	30-60			

5.12 Нийтийн зориулалтын олон давхар орон сууцны барилгын эдэлбэр газар буюу нийтийн хэрэгцээний газрын хэмжээг орон сууц, олон нийтийн барилгын эрүүл ахуйн болон галын аюулгүй шаардлага, нарны ээвэрлэлтийн шаардлага барилга хоорондын зай хэмжээ,

1.3 Тусгай зориулалтын – Өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдрах асрамж, сувилалын/ зориулалттай нийтийн орон сууцны барилга;

1.10 **Дээд** -Тухайн өрхийн гишүүн бүрийн амьдралын орчны бүхий л хэрэгцээг тус бүрд нь бүрэн хангах зохион байгуулалттай, иж бүрэн цогц шийдэл бүхий орон сууцны тухайлсан барилга;

1.11 **Дунд** - Өрхийн гишүүн бүрийн орлого нь дунд зэргийн үзүүлэлттэй иргэд амьдрах орон сууцны барилга;

1.12 **Энгийн** – **Ердийн иргэдийн амьдрах жирийн орон сууцны барилга**

авто замын орц, гарц, зогсоол, явган хүний зам, амрах, тоглох талбай, ногоон байгууламжийн төлөвлөлтийн нормын дагуу тодорхойлох ба ашиглалтын горим, хил хязгаарыг тогтоох асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэнэ.

Тайлбар: 1. Орон сууцны барилгын эдэлбэр газарт хот, суурины архитектурын шаардлага хангасан хашаа хайс төлөвлөхийг зөвшөөрөх ба өндөр барилгын нийтийн эзэмшлийн газрын төлөвлөлтөнд хашаа, хаалт байрлуулахыг хориглоно. 2. Орон сууцны хорооллын оршин суугчдын гэрийн тэжээвэр амьтад мал, шувууны байгууламжийг орон сууцны бүсээс гадна байршуулан төлөвлөж болно.

5.13 Орон сууцны барилгыг сэргээн засварлахад нийтийн эдэлбэрийн газрын¹¹ хэмжээ нь хэвээр үлдэх ёстой. Шинээр барилга байгууламж барих, орон сууцны доод давхрын хувийн болон нийтийн хэрэгцээний талбайн зориулалтыг өөрчлөх, барилгын давхар нэмэх, мансард барих, газар дээрх, доорх талбайг ашиглахад энэхүү норм, дүрмийн эрүүл ахуйн болон галын аюулгүйн шаардлагыг хангасан байх ёстой.

5.14 Нам давхрын орон сууцны хорооллын эдэлбэр газрын төлөвлөлтөд ногоон байгууламж болон гудамж, зам, талбай /зогсоол/, олон нийтийн барилга, байгууламж зэрэг хот төлөвлөлтийн норм, дүрмээр шаардагдах нийтийн эзэмшлийн төрөл бүрийн зориулалтын газрын харьцааг хүснэгт 5.3-ын дагуу тооцож төлөвлөнө.

Хүснэгт 5.3 Нам давхрын орон сууцны барилгажилтын эдэлбэр газрын норматив /хувь/

Орон сууцны зэрэглэл	Орон сууцны барилгажилтын эдэлбэр газар	Олон нийтийн барилга, байгууламжийн эзэмшил газар	Ногоон байгууламжийн зориулалтын талбай / нийтийн эзэмшлийн/	Гудамж, зам, зогсоол
Тансаг зэрэглэлийн хувийн орон сууц	75-аас ихгүй	3.0-8.0	3.0-аас багагүй	14.0-16.0
Тансаг зэрэглэлийн цогцолбор барилга	85-аас ихгүй	3.0-5.0		5.0-7.0

Тайлбар: 1. Орон сууцны хорооллын болон нийгмийн үйлчилгээний цогцолбор төвийн барилга байгууламжид хот, суурины гол ба туслах гудамж, замаар бусад барилга байгууламжид нутаг дэвсгэрийн гудамж, замаар үйлчлэхээр төлөвлөнө.

5.15 Хот, суурины газар нутгийн онцлог, барилгын материалын нөөцөд түшиглэн, орон сууцны төрөл, давхрын тоог оновчтой сонгох, түүний дотор “гэр сууц”-ны хорооллын байршил, зохион байгуулалтыг бүх төрлийн үйлчилгээний хүртээмжийг орчин үеийн орон сууцны хорооллын жишигт хүргэн ногоон хот, ухаалаг хотын шаардлагад нийцүүлэн төлөвлөнө.

5.16 Хот, суурины гэр сууцны хорооллыг дахин төлөвлөх¹² замаар эрүүл, аюулгүйн шаардлагын хэм хэмжээг ханган, ухаалаг дэд бүтцийн хангамжийн шийдлийг тодорхойлж байгаль газарзүйн болон хүрээлэн буй орчны нөхцөл шаардлагад нийцүүлэн төлөвлөнө.

¹¹ Хот, суурины газрыг дахин хөгжүүлэх тухай хууль

4.1.5.“нийтийн эдэлбэрийн газар” гэж Газрын тухай хуулийн 12.2-т заасан газрыг;

¹² 4.1.10.“хот, суурин газрыг дахин хөгжүүлэх” гэж архитектур, хот байгуулалт, төлөвлөлт, барилга байгууламжид тавигдах шаардлагад нийцүүлэн хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах цогцолбор үйл ажиллагааг;

5.17 Орон сууцны хороолол, гэр сууцны хорооллыг дахин төлөвлөн барилгажуулахад дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- Газар ашиглалтын зориулалтыг хот, суурины эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэх;
- Хорооллын архитектур-орон зайн зохиомж, уламжлалт төрхийг аль болох хадгалан байгаль газарзүйн онцлогт нийцүүлж, орчинтой нь уялдуулах;
- Хот, суурины барилгажилтын нягтралын үзүүлэлтийг хангах;
- Гудамж, замын ангилалыг хот, суурины ерөнхий төлөвлөгөөний дагуу тогтоох;
- Нийгмийн дэд бүтцийн хангамжийн нормативыг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээг ойртуулах

5.18 Эдэлбэр газартай орон сууц, гэр сууцны хорооллын гудамж, замын улаан шугам 35.0м; хорооллын доторхи доторх гудамж, замын улаан шугам 12.0м-15.0 м; барилгажилтын нягтрал 35.0 гэр/га¹³ байхаар тус тус тооцож төлөвлөнө.

Олон нийтийн үйлчилгээний нормчлол, байршлын үндэс

5.19 Суурьшлын бүсэд эрүүл мэнд, соёл, худалдаа, нийтийн хоол нийгмийн болон орон сууц үйлчилгээний, бизнесийн, тусгай дунд болон дээд боловсролын, засаг захиргааны, судалгаа-шинжилгээний, шашин номлолын, авто зогсоол, ажил хэргийн санхүү болон иргэд оршин суугчдын амьдралын хэрэгцээг хангах бусад зориулалтын олон нийтийн үйлчилгээний барилга, байгууламж төлөвлөнө.

5.20 Хот, суурины хүн амын амьдралын хэрэгцээг хангах олон нийтийн үйлчилгээний хэрэгцээ, хангамжийг барилга, байгууламжийн зориулалт, нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллөөр нь үндсэн хоёр бүлэгт ангилж, төлөвлөнө:

- Нийгмийн дэд бүтцийн хангамж /ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн барилга, байгууламж/;

- Соёл, ахуйн үйлчилгээний хэрэгцээ, хангамж /биеийн тамир, спортын барилга байгууламж; соёл, урлагийн барилга байгууламж; худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, ресторан, ахуйн үйлчилгээ, бизнес төвүүд; засаг захиргаа, оффис, хурал, конференцийн заал бүхий барилга байгууламж, зочид буудал; олон нийтийн түр хугацааны амралт зугаалгын зориулалттай барилга байгууламж /

5.21 Олон нийт үйлчилгээний барилга, байгууламжийг хотын төв болон төв гудамж, талбайд, нийтийн тээврийн үйлчилгээний зам дагуу хүний урсгал хөдөлгөөн ихтэй үйлдвэрийн болон бусад олон нийтэд үйлчлэх байгууллагын ойролцоо байршуулвал зохино. Олон нийтийн үйлчилгээг барилга, байгууламжийн бүтцээр нь олон талын зориулалтын (хотын болон хорооллын) тусгай зориулалтын, нийтийн зориулалтын гэж ангилж болно.

5.22 Барилгажилтын нягтрал ихтэй, орон зай багатай нутаг дэвсгэрт олон талын зориулалтын эрүүл ахуйн хамгаалалт тусгаарлалт нь 50.0 м-ээс багагүй байвал зохих худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, захиргааны байгууллага, бизнес худалдаа, шинжлэх ухаан, соёлын болон бусад төрлийн (ихэвчлэн 1.0 га-аас ихгүй) үйлчилгээг нэгтгэн төлөвлөхийг зөвшөөрнө.

Түүхэн хотын төвийг хөгжлийн явцад бий болсон түүхэн байгууламжийг хэсэгчлэн болон бүхэлд нь сэргээн засварлаж, хадгалж хамгаалахын зэрэгцээ барилгажуулахдаа түүхэн барилга байгууламжийн хийц маягтай харилцан уялдаатай нэгдмэл орчныг бүрдүүлж төлөвлөнө. Ингэхдээ орон сууцны хэв загвар, давхрыг түүхэн-хот байгуулах судалгаанд тулгуурлан төлөвлөх ба энэхүү судалгаа нь тухайн хотын түүхэн хөгжлийн болон архитектур-орон зайн онцлог, түүх-соёлын уламжлал болно.

¹³ /БНБД II-6-79 хуудас 28/

5.23 Тусгай зориулалтын үйлчилгээнд засаг захиргааны, эмнэлгийн, эрдэм шинжилгээний, сургалтын, худалдааны (тэр дундаа үзэсгэлэн худалдаа, барааны зах), үзэсгэлэн, биеийн тамирын цогцолбор төв зэрэг хотын тусгай зориулалтын төвүүд хамаарах ба хотын нутаг дэвсгэрээс гадна, хотын гадна хот орчимд байрлуулан төлөвлөж болно.

Эдгээр үйлчилгээний барилга, байгууламжийг байршуулахад тэдгээрийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэх ёстой. Мөн талбайн хэрэгцээ, багтаамж ихтэй авто зогсоол, зам харилцаа, инженерийн дэд бүтэц түүнчлэн хүрээлэн буй орчин зэргэлдээх барилга, байгууламжид үзүүлэх нөлөө зэргийг тооцсон байна.

5.24 Хот, хөдөөгийн суурины хүн амын үйлчилгээний барилга, байгууламжийн хүчин чадал, эдэлбэр газрын хэмжээг энэхүү нормын хавсралт Д-ын дагуу эрүүл ахуйн хэм хэмжээг баримтлан төлөвлөнө. Үйлчилгээний суурин-барилга, байгууламжаас гадна улирлын чанартай хөдөлгөөнт үйлчилгээнд зориулсан зогсоол, талбайг тооцсон байх ёстой.

5.25 Соёл, ахуйн бүх үйлчилгээний хүчин чадлын нормыг төлөвлөлтийн үе шат (төлөвлөлтийн бүсүүд, суурьшлын бүс, сууцны хороолол, хотын төв), ээлж дарааллаар (эхний ээлж ба төлөвлөлтийн хугацаа) тооцон тодорхойлсон байх ёстой.

5.26 Үйлчилгээний барилга, байгууламжийн хүчин чадлыг төрөл бүрээр нь биет хэмжигдэхүүнээр (тухайлбал: суудал, ажлын байр, худалдагч, хүүхэд, суралцагч, сурагч, ор, үзлэг/өдөр гэх мэт), эсвэл үүрэг зориулалтынх нь барилга, байгууламжид эзлэх талбайн хэмжигдэхүүнээр (жишээлбэл, м² худалдааны талбай, м² усан толь, м² тоглолтын талбай, м² гулгалтын талбай гэх мэт) тооцон төлөвлөлтийн үе шат (орон төлөвлөлтийн бүс, суурьшлын бүс, сууцны хороолол, хотын төв) ээлж дарааллаар (эхний ээлж ба төлөвлөлтийн хугацаа) тодорхойлно.

Зарим тохиолдолд хүчин чадлыг төлөвлөлтийн үе шат, эсвэл тодорхой тооны хүн амд оногдох барилга, байгууламжийн тоогоор (жишээлбэл, орон сууцны хороололд нэг эмийн сан, 5000 оршин суугч тутамд нэг гал командын машин гэх мэт) илэрхийлнэ.

5.27 Хот, суурины төлөвлөлтөнд үйлчилгээний барилга, байгууламжийн хүчин чадлын тоон утгыг хотын ангилал, байгалийн нөхцөл, хүн ам зүйн бүтцийн онцлог, нийгмийн дэд бүтцийн байдал, хотуудын үйлдвэрлэлийн чиглэл, төлөвлөлтийн үе шат болон бусад хүчин зүйлээс хамааруулан тооцоолно.

5.28 Соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн хүчин чадлын норматив хэмжээг хоёр үе шатаар тооцно:

I үе шат - хотын хэмжээний соёл, ахуйн үйлчилгээний норматив хүчин чадлыг нийтэд нь тодорхойлох;

II шат - тодорхойлсон норматив хүчин чадлыг хотын нутаг дэвсгэрийн ашиглалтын зориулалт /бүсчлэл/ -ын дагуу тооцож байршуулах

5.29 Шаардлагатай тохиолдолд хотын хэмжээний соёл, ахуйн үйлчилгээний нормыг хавсралтын Д-ын дагуу тооцож төлөвлөнө.

5.30 Олон нийт, соёл, ахуйн үйлчилгээний барилга, байгууламжийг өдөр тутмын хэрэгцээний буюу хорооллын үйлчилгээ; тухайн хэрэгцээний буюу хотын үйлчилгээ (долоо хоногт хоёроос гурван удаа); тохиолдлын (сард хоёроос гурван удаа) буюу улсын үйлчилгээ гэж ангилан үйлчлэх хүрээг хүснэгт 5.4-ийн дагуу тооцно.

Хүснэгт 5.4 Үйлчилгээний хамрах хүрээ¹⁴

Д.д	Үйлчилгээний төрөл	Үйлчлэх хүрээ, м	
		Хот	Хөдөөгийн суурин
1.	Соёл олон нийтийн үйлчилгээ	500	1000
2.	Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага*	300	500
3.	Ерөнхий боловсролын сургууль	500	1000
4.	Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, тэдгээрийн салбар**	500-750	750
5.	Өрхийн эмнэлэг, амбулатори, эмийн сан	300-500	500-1000
6.	Орон сууцны хорооллын биеийн тамир спортын төв	750	1000
7.	Чийрэгжүүлэлтийн төв	500	1000
8.	Худалдаа, нийтийн хоол, зочид буудал, ахуйн үйлчилгээ	500	800
9.	Хүнсний зах	800	1200
10.	Холбооны салбар, банк	750	1000

*Энэ нь тусгай зориулалтын болон сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдар эрүүлжүүлэх байгууллага түүнчлэн хүүхдийн тусгай сургалттай цэцэрлэг, ясли болон ерөнхий боловсролын сургуульд (хэлний, тооны, биеийн тамирын гэх мэт) хамаарахгүй.

** Орон нутаг дахь эмнэлэг, эмнэлгийн үзлэг оношлогоо, эх барих-төрөх төвүүд болон эмийн сан нь тээврийн хэрэгсэлээр 30 минутад хүрэх зайд байрлана.

- Ерөнхий боловсролын сургуулийн явганаар хүрэх боломж 0.5 км-ээс хэтрэхгүй байна.
- Бага сургуульд хүрэх замыг хөдөлгөөн ихтэй гудамж хөндлөн гарахаар төлөвлөхийг хориглоно.
- Тээврийн хэрэгсэл хүрэхэд хүндрэлтэй нөхцөлтэй тохиолдолд алслагдмал зайд оршин суудаг сурагчдад сургуулийн дэргэд тухайн сургуулийн нийт багтаамжийн 10%-тай тэнцэх хүчин чадалтай дотуур байр төлөвлөнө.

Тайлбар: Уур амьсгалын бүсчлэлийн IA, IB, IG, ID, IIА дэд хэсгийн болон элсэн цөл, говийн бүсийн байгалийн өвөрмөц үзэлдэл бүхий нөхцөлд хүснэгтэнд заасан хэмжээг 30%-иас их багасгаж болохгүй.

Тайлбар: 1. Өдөр тутмын хэрэгцээний соёл, ахуйн үйлчилгээний барилга, байгууламж 300-500 м үйлчлэх хүрээтэй, явганаар 5-7 минут зарцуулахаар байршуулж төлөвлөнө.

2. Улирлын буюу тухайн хэрэгцээний соёл, ахуйн үйлчилгээний барилга, байгууламжийг 1500 м хүртэлх үйлчлэх хүрээнд, явганаар болон нийтийн тээврээр 15 минутаас илүүгүй хугацаанд зорчихоор (нийтийн тээврийн буудал хүрэх замыг оруулаад) байршуулж төлөвлөнө. 3. Соёл, ахуйн тохиолдлын үйлчилгээгээр хүн ам нийтийн тээврээр зорчиж үйлчлүүлэх бөгөөд зорчих хугацааг нормчлохгүй ч барилга, байгууламжийг 20-30 минут зарцуулах зам, тээврийн хүртээмжтэй байх зайд байршуулж төлөвлөнө.

5.31 Соёл, ахуйн үйлчилгээний барилга, байгууламжийн ихэнхи төрлийн үйлчилгээ нь бүх ангилалд; зарим төрлийг нь зөвхөн нэг эсвэл хоёр ангилалд байршуулан төлөвлөж болно. Өөр өөр ангилалын барилга, байгууламжийг шаардлагатай тохиолдолд бүтэц, үйлчилгээний шинж чанараар нь нэгтгэн дараахи байдлаар төлөвлөж болно:

- өдөр тутмын үйлчилгээний соёл, ахуйн үйлчилгээний нэг төрөл болох соёл урлагийн анхан шатны нэгж-клуб (улаан булан, явуулын номын сан, хүүхдийн өрөө гэх мэт) –ийг нэг дор;
- улирлын үйлчилгээний ангилалд багтах-клуб, номын сан, кинотеатр, хүүхдийн ордонг хамтад нь;
- тохиолдлын үйлчилгээний ангилалд хамаарах-соёлын ордон, нийтийн ба төрөлжсөн номын сан, театр, концертын танхим, цирк, бүх нийтийн үзвэр спортын цогцолбор, хүүхэд-залуучуудын чөлөөт цагийн соёл урлагийн барилгуудыг нэгдмэл байдлаар төлөвлөж болно.

¹⁴ БД 30-101-05 Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт Хүснэгт 2. Үйлчилгээний объектуудад явганаар хүрэх радиус,м

Олон нийтийн төв

5.32 Соёл, ахуйн үйлчилгээг олон нийтийн төв хэлбэрээр төлөвлөж болно. Олон нийтийн төв нь хүн амд үзүүлэх үйлчилгээний нэгдмэл байдлыг хангах, соёл, ахуйн үйлчилгээний барилга барих зардлыг багасгах зэргээр архитектурын оновчтой шийдэл бүхий цогцолбор байгууламжийг төлөвлөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүснэгт 5.5 Хот, суурины олон нийтийн төв

Олон нийтийн төвүүдийн ангилал	Үйлчлэх хүрээ, м	Байршил
Хотын төв	Хязгаарлахгүй	Хотын төв; зам, тээврийн гол зангилаа бүхий газарт
Хорооллын төв: - Суурьшлын бүс ➢ орон сууцны хороолол ➢ бичил хороолол - үйлдвэр, аж ахуйн бүсүүд - амралтын бүс	Хязгаарлахгүй 1500 хүртэл >>500 Хязгаарлахгүй Хязгаарлахгүй	Хотын нутаг дэвсгэрийн хэмжээ, төлөвлөлтийн бүтэц, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, онцлог, зам, тээврийн уялдаа, байгалийн нөхцөл, архитектур, төлөвлөлтийн зохиомж, уран сайхны шинж чанараас хамаарна.
Хотын олон нийтийн тусгай үйлчилгээний төв: - эмнэлэг - эрдэм шинжилгээ, зураг төсөл - боловсрол - музей-үзэсгэлэн - спорт	Хязгаарлахгүй	Байгалийн таатай орчинд тусгай хэрэгцээний газарт Хотын тусгай хэсгүүдэд

5.33 Хот, суурины олон нийтийн үйлчилгээний цогцолбор барилга, байгууламжийг хотын төв буюу хот, суурины гол гудамж, нийтийн тээврийн хэрэгсэлийн зам дагуу байрлуулан барилгажилтын төрх, архитектурын өвөрмөц илэрхийлэл болгон төлөвлөнө. Нийслэл хот, хотууд “арилжаа бизнесийн төв гудамж”-тай байхаар төлөвлөх шаардлагатай.

5.34 Хот, суурин газрын сургуулийн барилга хүүхдийн дотуур байртай тохиолдолд дотуур байрны нэг хүүхдэд ногдох эдэлбэр газрын хэмжээгээр сургуулийн талбайг 0.2 га – аас ихгүйгээр нэмэгдүүлж төлөвлөнө. Сургуулийн спорт, биеийн тамирын цогцолборыг орон сууцны хорооллын биеийн тамир, спортын цогцолбортой нэгтгэн төлөвлөж болно.

5.35 Нийслэл хот, хотод хүүхдийн ордон, залуу техникчдын ордон, хүүхдийн урлаг, уран сайхны сургууль, биеийн тамир спорт, бялдаржуулан, эрүүлжүүлэх төв зэрэг байгууллагуудад нийт сурагчдын 10–аас доошгүй хувь хамрагдахаар тооцож зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу төлөвлөх ба хоторхуу суурин, хот маягийн сууринд сургуулийн барилгын цогцолбор байдлаар нэгтгэн төлөвлөхийг зөвшөөрнө.

5.36 Нийслэл хот, хотод соёлын төв, театр, кинотеатр, музей, үзэсгэлэнгийн танхим, хурлын танхимуудыг нийтийн үйлчилгээний байгууллагуудтай нэг дор байрлуулж, цогцолбор байдлаар төлөвлөхийг зөвшөөрнө.

Хот, суурин газарт орон сууцны хороолол дотор орон сууцны барилгын нэг давхарт чөлөөт цагийн клуб, автомат тоглоомын газруудыг жижиг үйлчилгээний газартай хамт төлөвлөж болно.

5.37 Хот, суурин газруудад холбооны салбар, банкны салбар, төрийн бус байгууллагын ажлын байр, хууль хүчний байгууллага зэрэг захиргаа, удирдлагын ажлын байруудыг зураг төсөл боловсруулах даалгаврыг үндэслэн төлөвлөнө.

5.38 Нисэх буудлын хилийн хяналт шалгалтын байгууллагууд болон иргэний нисэхийн аюулгүй байдал хангах зорилгоор зорчигч үйлчилгээний цогцолбор барилгын хүчин чадлаас хамаарч нэг хүнд, орон нутгийнх 12.0м²-15.0м², олон улсынх 20.0м²-30.0м² талбай ногдохоор тооцож төлөвлөнө.

5.39 Эмнэлгийн яаралтай тусламж, онцгой байдлын чиг үүргийн барилга байгууламжид Аэродром. Хэлипортод тавигдах шаардлага /MNS6784:2019/" стандартын дагуу хэлипорт/хэлипат төлөвлөлтийг тооцох шаардлагатай.

6. Барилгажилтын өгөгдөлүүд ба зай хэмжээ

6.1 Орон сууцны барилга хоорондын, орон сууц олон нийтийн барилга хоорондын зайг барилгын материалын галд тэсвэршилтийн зэрэг, нарны тусгалын үргэлжлэх хугацаа, бусад барилга, байгууламжийн зориулалт зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт /БНБД 31-01-10/¹⁵ болон Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж” БНБД -23-04-07-ийг тус тус үндэслэн төлөвлөнө.

Тайлбар: 1.Барилгажилт, төлөвлөлтөнд “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” БНБД 23-01-09 –ийг мөрдөнө. /Хавсралт Н/ Уур амьсгалын I болон IIA бүсэд “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” БНБД 23-01-09–ийн /16 дугаар зураг/ үзүүлэлтийг 30% -иас хэтрүүлэхгүйгээр бууруулж төлөвлөхийг зөвшөөрнө. 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм (БД 31-101-04) –ийн дагуу төлөвлөнө.

6.2 Орон сууцны 7-17 хүртэл давхар барилга бол 1.2-2.0 Н/¹⁶ буюу барилгын зоорийн давхрын газраас дээш гарсан түвшингөөс техникийн давхрын дээврийн хашлага ханын дээд ирмэг хүртэлх 1.2-2.0 хэмжээнээс багагүй байна. Газар хөдлөлтийн 8 баллын бүсэд өндөр барилга барих тохиолдолд орон сууцны барилгын тууш талуудын хоорондын зай нь хамгийн өндөр барилгын өндрөөс хоёр дахин их зайтай тэнцүү байна.

Орон сууцны барилгын тууш талуудын хоорондын зай 2-3 давхар барилгад 15.0 м хүртэл; 4 давхар бол 20.0 м хүртэл харин орон сууцны барилгын тууш болон хөндлөн талын /сууцны өрөөний цонхтой тал/ хоорондын зай 10.0м-ээс багагүй байх ёстой. **7.1**

6.3 Дахин төлөвлөлт буюу барилгажилтад хүндрэлтэй нөхцөлтэй тохиолдолд дээрх зай хэмжээг багасгаж болох ч нарны гэрлийн тусгал, өрөө тасалгааны гэрэлтүүлэг, галын аюулгүйн нормыг баримтлана. Түүнчлэн нэг цонхноос нөгөө цонх хооронд харагдах орчны хязгаарлагдмал (өрөө, гал тогоо) байдлыг харгалзан үзнэ.

6.4 Хэрэв зэрэгцээ 2 барилга, хөндлөн талаараа цонхгүй байрласан, мөн барилгын сууцны болон гал тогооны өрөө хооронд цонхоор нэвт харагдах нөхцөл хангагдсан тохиолдолд Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж /БНБД 23-04-07/-ийн шаардлагад нийцүүлэн барилга хоорондын зай хэмжээг багасгаж төлөвлөхийг зөвшөөрөнө.

Тайлбар: Нам давхар барилгын сууцны өрөө, гал тогоо болон *шиллэсэн тавцангийн* цонхноос туслах аж ахуй, гарааж, халуун усны барилгын хана хүртэлх зай хэмжээ эрүүл ахуйн шаардлагын дагуу 6.0 м-ээс багагүй байх ёстой.

6.5 Эдэлбэр газартай нэг айл, өрхөд зориулсан сууц, зуслангийн барилга хоорондын зай нь цонхноос (өрөө, гал тогоо, үүдний өрөөний) хөршийн эдэлбэр газар дахь байшингийн хана, ахуйн барилга (саравч, гарааш, халуун ус)-ын хана хүртэл 6.0м-ээс ихгүй харин гэрийн

¹⁵ 12, 13 дугаар хүснэгт

¹⁶ Хуучин нмын төсөл 3.9.4

тэжээвэр амьтан, шувууны саравч, туслах аж ахуйн зариулалттай барилгуудыг Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт /БД 30-101-05/-ыг үндэслэн төлөвлөнө.

Тайлбар: 1. Гэр сууцны хорооллын гэр хоорондын зай 12.0 м-ээс багагүй, гудамж, хашааны урт 150-200м-ээс ихгүй байх ба гудамжилсан хоёр хашааг 45м-ээс их өргөнтэй зэрэгцүүлэн төлөвлөхийг хязгаарлана. 2. Ус хангамж, ариутгах татуургын нэгдсэн байгууламжгүй тохиолдолд ариун цэврийн байгууламжаас зэргэлдээх айлын барилгын хана хүртэл 12.0 м-ээс багагүй, ус хангамжийн эх үүсвэр (худаг) хүртэл 25.0-50.0 м зайтай байна. 3. Зуслангийн байшинд гарааш, халуун ус, хүлэмж гэрийн тэжээвэр амьтны саравч зэрэг ахуйн зориулалтын байгууламжийг галын аюулгүйн болон эрүүл ахуйн норм, дүрмийн дагуу байрлуулж болно.

6.6 Малын саравч, гэрийн тэжээвэр амьтдын байрыг блокчлон /30 хүртэл/ төлөвлөхийг зөвшөөрөх бөгөөд 1-2 саравчтай бол 10.0 м-ээс ихгүй, 8 хүртэл блок саравч 25.0 м, 8–30 хүртэл блок саравч 50.0м зайтай байна. Блокчлон барих малын саравчны талбай 800 м² – аас ихгүй байна.

6.7 Холимог ашиглалтын зориулалт бүхий цогцолбор орон зай /бүс/-д байрлах үйлдвэрийн барилга, байгууламжаас орон сууц, олон нийтийн барилга, байгууламж болон цэцэрлэг, сургууль, эрүүл мэнд /эмнэлэг/, амралт сувилалын байгууллага хүртэл 50.0 хүртэл метр байна.

6.8 Хот суурины нутаг дэвсгэрийн бүсчлэлийн барилгажилтын нягтралыг Хүснэгт 6.1-д заасан хэмжээнээс ихгүй байхаар тооцож төлөвлөнө. Нутаг дэвсгэрийн бүсчлэлийн барилгажилтын нягтралыг эдэлбэр газар, барилгын талбайн харьцаа (FAR, BCR)-аар хүснэгт 6.1-т заасан норматив үзүүлэлтээс багагүй байхаар тооцож төлөвлөнө.

Хүснэгт 6.1 Барилгажилтын нягтралын норматив үзүүлэлт

Нутаг дэвсгэрийн бүсчлэл	Барилгажилтын илтгэлцүүр коэффициент ²¹ /BCR/	Барилгажилтын нягтралын илтгэлцүүр коэффициент ¹⁷ /PAR/
Суурьшлын /Орон сууц, олон нийтийн/		
Олон давхар олон айлын орон сууцны барилгажилт (7-16 давхар)	0,4	1,2
Олон давхар олон айлын орон сууцны барилгажилт, дахин төлөвлөлт (7-16 давхар)	0,6	1,6
Дундаж давхар олон айлын орон сууцны барилгажилт -Цөөн давхар орон сууцтай (4-6 давхар); -Нам давхар орон сууцтай (3 хүртэл давхар);	0,4	0,8
Эзэмшил газартай блокчилсон орон сууцны барилгажилт (таунхаус; твин хаус)	0,3	0,6
Эзэмшил газартай 1-2 айлын орон сууц болон эдэлбэр газартай нэг айл өрхөд зориулсан орон сууц, гэр сууцны барилгажилт	0,2	0,4
Олон төрлийн (нийгэм, олон нийтийн) зориулалттай	1,0	3,0

¹⁷ Барилгуудын суурийн талбайн нийлбэр, хорооллын /орон сууц, үйлдвэрийн/ эдэлбэр газрын харьцаа; BCR

барилгажилт		
Нийгэм, олон нийтийн төрөлжсөн барилгажилт	0,8	2,4
Үйлдвэр, аж ахуйн		
Үйлдвэрийн	0,8	2,4
Шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн*	0,6	1,0
Агуулах, нийтийн аж ахуйн	0,6	1,8

• Туршилтын талбай, полигон, нөөц нутаг дэвсгэр, эрүүл ахуйн бүсийг тооцоогүй.

Тайлбар:

- Суурьшлын бүсийн барилгажилтын коэффициент болон барилгажилтын нягтралын коэффициентийг орон сууцны хорооллын эдэлбэр газрын хэмжээнд тооцоогоор шаардагдах олон нийт, үйлчилгээний барилга, байгууламж, авто зогсоол, гарааш, ногоон байгууламж, тоглоомын талбай зэрэг барилгажилт, тохижилтын талбайг оруулж тооцно. Үйлдвэрийн бүсийн хувьд нэг болон хэд хэдэн үйлдвэрлэлийн бүсийг хамруулан тооцно.
- Барилгажилтын нягтралын коэффициентийг тооцоход барилгын давхрын талбайг тухайн барилгын гадна хэмжээгээр тодорхойлох бөгөөд барилгын газраас дээш давхар болон мансардыг оруулан тооцно. Харин газар доорх байгууламж тооцоонд хамаарахгүй. Тухайлбал газар дээрх зүлэгжүүлсэн талбай, хүүхдийн тоглоомын талбай, машины зогсоолын болон бусад тохижилтын зориулалтын талбай доорх байгууламжийг тооцохгүй.
- Хорооллын эдэлбэр газар гудамж, замын улаан шугамаар хязгаарлагдана.
- Суурьшлын бүс (давхрын нэмэлт барилга, мансардыг оруулан)-ийн шинэчлэн барилгажуулах төлөвлөлтөнд тухайн хорооллын оршин суугчдад шаардагдах үйлчилгээний барилга, байгууламжийн хүчин чадлын тооцоог үндэслэл болгох шаардлагатай. Мөн зэргэлдээх хорооллын оршин суугчдад үйлчлэх үйлчилгээний хүртээмж, үйлчлэх хүрээ (үүнд, сургуулийн өмнөх насны болон бага сургууль, ерөнхий боловсролын байгууллагаас бусад)-г мөн тооцох ёстой.
- Одоо байгаа барилгыг шинэчлэх тохиолдолд барилгажилтын нягтралын үзүүлэлтийг эрүүл ахуйн болон галын аюулаас хамгаалах нормативыг дагаж мөрдсөн тохиолдолд нэмэгдүүлж болох ч 30%-иас хэтрүүлж болохгүй.


Барилгажилтын нягтралын үндсэн үзүүлэлтүүд /Зураг 6.1/:

- барилгажилтын итгэлцүүр – барилга, байгууламж /инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж/-ийн доорхи талбайг тухайн бүсийн төлөвлөлтөд хамрагдах талбай (хорооллын эдэлбэр газар)-д харьцуулсан харьцаа;

- барилгажилтын нягтралын итгэлцүүр – барилга, байгууламж /инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж/-ийн бүх давхрын талбайг тухайн бүсийн төлөвлөлтөд хамрагдах талбай (хорооллын эдэлбэр газар)-д харьцуулсан харьцаа.

Зураг 6.1

FAR(%) = $\frac{\text{Барилгуудын бүх давхрын шалны талбайн нийлбэр (B+C) м}^2}{\text{Төлөвлөлтөнд хамрагдах талбай /хорооллын эдэлбэр газар/ (A) га}} \times 100$



BCR(%) = $\frac{\text{Барилгуудын суурийн талбайн нийлбэр (B) м}^2}{\text{Төлөвлөлтөнд хамрагдах талбай /хорооллын эдэлбэр газар/ (A) га}} \times 100$

6.9 Дунд болон олон давхар барилгатай (4-16 давхар хүртэлх) орон сууцны хорооллын нэг хүнд ногдох сууцны талбай **20м²/хүн** байх тохиолдолд хүн амын нягтрал **300-450 хүн/га**-аас ихгүй байна.

6.10 Орон сууцны хорооллын хүн амын нягтрал, байгаль, цаг уурын болон тухайн нутаг дэвсгэрийн онцлог, 1000 хүнд ногдох норматив хэрэгцээг үндэслэн нийтийн хэрэгцээний задгай талбайг хүснэгт 6.2-ын дагуу төлөвлөнө. Ингэхдээ хүүхдийн тоглоомын талбай, амрах талбай, биеийн тамирын талбайн хэмжээ нь орон сууцны хорооллын эдэлбэр газрын 10%-иас ихгүй байна.

Биеийн тамирын талбай хүртэлх зай хэмжээнд тухайн орчинд нөлөөлөх дуу, чимээг тооцох ёстой.

*хөл бөмбөгийн болон хоккейн талбай дуу чимээ ихтэй, хамгийн бага дуу чимээтэй нь ширээний теннисний талбай болно.

Хүснэгт 6.2 Нийтийн хэрэгцээний задгай талбайн норматив

д/д	Талбай	Талбай м ² /хүн	Орон сууц, олон нийтийн барилга хүртэлх зай, м
1	Сургуулийн өмнөх насны болон бага ангийн хүүхэд тоглох	0.7	12.0
2	Насанд хүрэгчдийн амрах	0.1	10.0
3	Биеийн тамирын талбай	2.0	10.0 – 40.0*
4	Аж ахуйн ашиглалтын	0.3	20.0
5	Нохой салхилуулах талбай	-	40.0
6	Автомашинь зогсоол	0.8	15.0
7	Тээврийн хэрэгслийн зогсоол	Хүснэгтийн дагуу	

Ахуйн хог хаягдлын төвлөрсөн цэгээс биеийн тамирын болон хүүхдийн тоглоомын талбай насанд хүрэгчдийн амрах талбай хүртэлх зай 20.0м-ээс багагүй, аж ахуйн зориулалттай талбайгаас орон сууцны хамгийн алслагдсан орц хүртэлх зай 100.0м-ээс (хогийн бункертэй байр) ихгүй байна. Дээр дурьдсан талбайн эзлэх хувийг холбогдох тооцоог үндэслэн 50%-иас ихгүйгээр багасгахыг зөвшөөрнө.

Тайлбар: Уур амьсгалын I, IIА бүсэд хүүхдийн тоглоомын талбай, насанд хүрсэн хүмүүсийн амрах талбай болон биеийн тамирын талбайг 50% хүртэлх хувиас хэтрүүлэхгүй багасгаж болно. Хүчтэй салхи шуургатай бүсэд ахуйн зориулалттай, 9 болон түүнээс дээш давхар барилгажилт бүхий хороололд оршин суугчид, сургуулийн биеийн тамирын болон биеийн тамир-бялдаржуулалтын нэгдсэн битүү цогцолбор байгууламж төлөвлөнө.

6.11 Нэгдүгээр давхартаа үйлчилгээтэй орон сууцны барилгыг барилгажилтын улаан шугамаас 15.0-20.0 м зайд төлөвлөх бөгөөд эдэлбэр газартай орон сууцны хорооллын орчны барилгажилтыг харгалзан гудамж, зам дагуу байрлуулж төлөвлөхийг зөвшөөрнө.

6.12 Барилга байгууламжийг сэргээн засварлах болон хот байгуулалтын бусад хүндрэлтэй тохиолдолд зохих үндэслэлийн дагуу одоо мөрдөгдөж байгаа норм, нормативт тодотгол хийхийг зөвшөөрдөг ба өгөгдсөн даалгаврыг орон нутгийн архитектур хот байгуулалтын алба, улсын эрүүл ахуй халдвар судлалын болон байгаль хамгаалах, галын аюулаас хамгаалах албатай зөвшилцсөн байна. Ингэхдээ хүн амын эрүүл ахуйн болон галын аюулгүй байдлыг сайжруулах нөхцөлийг хангах шаардлагатай.

Орон сууц, олон нийтийн барилгыг засварлаж мансард болон давхар нэмэх тохиолдолд Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж” БНБД -23-04-07-ийг мөрдөнө.

6.13 Барилгажилтын нягтрал ихтэй газарт таван давхар барилгад засвар өөрчлөлт хийхэд нарны тусгал, гэрэлтүүлгийн нормативт шаардлагын дагуу мансардын давхрыг үл тооцон хоёр давхар нэмж барихыг зөвшөөрөх ба ингэхдээ орон сууцны барилга хоорондын тууш талуудын зай нь 30.0 м (өргөрөг, уртраг) болон орон сууцны уртааш сунасан талаар, өмнө зүг харсан тэгш өнцөгтэй байшингийн өнцөг хоорондын зай зэргийг тооцно.

6.14 Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний, байгаль орчны үнэлгээний хот байгуулалтанд тохиромгүй нөхцөлтэй нутаг дэвсгэрийн бүсэд хүрээлэн буй орчныг хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээ авахгүйгээр орон сууц нэмж барилгажуулахыг хориглоно.

7. Үйлдвэр, аж ахуйн аж ахуйн бүс

7.1 Хот, суурины үйлдвэрийн газруудыг өргөтгөх, шинэчлэх, шинээр барьж байгуулах төлөвлөлтөнд Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө /БНБД 30-02-07/; Үйлдвэрийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн норм /БНБД 2.09.12-87/; Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал /БНБД 21-01-02/ болон үйлдвэр технологийн паркийн тухай, инновацийн тухай, эрүүл ахуйн тухай хууль, норм, дүрмийг мөрдөнө.

7.2 Үйлдвэрийн бүсэд олон нийтийн, үйлдвэрийн болон бусад зориулалтын дараахи барилга, байгууламж төлөвлөнө. Үүнд:

- Нийтийн зориулалтын: нийтийн орон сууц болон агуулахын, орон сууц нийтийн аж ахуйн, тээвэр логистикийн, бөөний худалдааны барилга, байгууламж;

- Аж үйлдвэрийн зориулалтын: үйлдвэрийн барилга байгууламжууд, тэдгээрийн 50.0 м эрүүл ахуйн бүс шаардагдах байгууламж, төмөр замын салаа;

- Бусад зориулалтын: шинжлэх ухаан, техник технологийн, инженерийн болон тээврийн барилга, онцгой байдлын барилга, байгууламж.

Мөн тухайн бүсэд байрлаж буй үйлдвэрийн болон бусад объектод үйлчлэх зориулалттай ослын аврах албаны байгууламж төлөвлөхийг зөвшөөрнө.

Тайлбар: 1. Үйлдвэрийн бүсэд үйлдвэрлэлийн шинэтгэл инноваци, дэд бүтцийн цогц шийдэл бүхий кластрийн зохион байгуулалттай аж үйлдвэрийн парк төлөвлөхийг зөвшөөрнө. 2. Аж үйлдвэрийн бүсэд бусад объект байрлуулах болон засвар хийх тохиолдолд тэдгээр объектын ашиглалтын явц дахь аюулгүй ажиллагааг хангах, аваар осол гарах тохиолдолд ойр орчмын оршин суугчдыг эрсдлээс хамгаалах болон бусад үйл ажиллагааг бүрэн зохицуулахаар тооцно. Аж үйлдвэрийн болон бусад объектын аюулгүй байдлын зэргийг холбогдох хууль тогтоомжид заасан техникийн үзүүлэлтийн дагуу тогтооно. 3. Аж үйлдвэрийн түүхэн объектын сэргээн засварлалтанд түүхэн дүр төрхийг нь хэвээр хадгалах арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлнэ.

7.3 Хотын үйлдвэрийн бүсийн бүтцэд үйлдвэрлэлийн эрүүл ахуйн ангиллаас хамааран эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн, аж ахуй агуулахын зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн зориулалттай байгууламж байршуулж болно.

Хүнсний, анагаах ухааны, эмийн зэрэг үйлдвэр болон бусад салбарын үйлдвэрүүд 100.0 м хүртэл эрүүл ахуйн хамгаалалтын бүстэй байна. Үйлдвэрийн бүсэд болон түүний эрүүл ахуй хамгаалалтын бүсийн хязгаарт төмөрлөгийн, химийн, нефт-химийн болон бусад хортой нөхцөлтэй үйлдвэрүүд байрлуулахыг хориглоно.

7.4 Үйлдвэрийн бүсийн төлөвлөлт хороололын (улаан шугам дотор)—зохион байгуулалттай байх ба үйлдвэрийн үндсэн ба туслах барилга, байгууламжийг байрлуулахдаа эрүүл ахуйн болон галын аюулгүйн шаардлагын дагуу ачаа эргэлт, тээвэрлэлтийг тооцож барилгажих дарааллыг тогтооно. Үйлдвэрийн болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээний барилга, байгууламжийн газар нь үйлдвэрийн бүсийн нийт талбайн 60%-иас хэтрэхгүй байна.

Тайлбар: 1. Үйлдвэрийн зориулалтын газрын /бүс/ ашиглалт нь ашиглагдаж буй нийт талбайг (үйлдвэрийн талбай болон түүнтэй холбоотой барилга, байгууламжийн эдэлбэр газар, үйлчилгээний байгууллагуудын эдэлбэр газар, төмөр замын өртөөний талбайн нийлбэр) хот, суурины ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон үйлдвэрийн бүсийн нийт талбайд харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно. 2. Ашиглагдаж буй нийт талбайд барилга, байгууламж барихаар төлөвлөсөн бусад барилга байгууламжийн нөөц талбайг тооцно. 3. Үйлдвэр, аж ахуйн бүсийн барилгажилтын үзүүлэлтийг тооцоход Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө /БНБД 30-02-07/-ын хавсралт 1 болон энэхүү норм, дүрмийн хүснэгт 6.1-ийг мөрдөнө.

7.5 Эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байгууламжид шинжлэх ухааны болон шинэлэх ухааны үйлчилгээний барилга, байгууламж түүнтэй холбоотой туршилтын үйлдвэрлэлийн барилга, дунд болон дээд боловсролын сургууль, зочид буудал, үйлчилгээний байгууллага түүнчлэн инженерийн, зам тээврийн байгууламж багтана. Эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн болон бие даасан эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, туршилтын үйлдвэрлэл байгуулах зэргийг хүрээлэн буй орчинд нөлөөлөх хүчин зүйлийг тооцсоны үндсэн дээр байгуулна. Эрүүл ахуйн 50.0м хүртэл бүс шаардлагагүй тохиолдолд эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборт орон сууц төлөвлөж болох ба холимог ашиглалтын цогцолборт баримталвал зохих шаардлагыг хангасан байна.

7.6 Үйлдвэр болон бусад объектыг байршуулахад хөрсний бохирдол, хөрсний болон гүний ус, хөрсний усны хуримтлал, гол мөрөн, агаар бохирдуулахаас урьдчилан хамгаалах арга хэмжээнд холбогдох хууль, норм, дүрмийг мөрдөнө.

7.7 Хотын нийтийн аж ахуйн зориулалтын өдөр тутмын үйлчилгээний хүнсний (хүнсний амталгааны, махны болон сүүний) үйлдвэр, өргөн хэрэглээний бараа (хүнсний болон барааны)-ны төрөлжсөн агуулах, төмс, хүнсний ногоо, жимсний агуулахын хүчин чадал, эдэлбэр газрын хэмжээг Агуулахын барилга /БНБД 31-19-10/ болон энэхүү норм, дүрмийн хавсралт Г-ын дагуу тооцож төлөвлөнө.

Хотын өдөр тутмын үйлчилгээтэй холбоогүй агуулахын цогцолборыг нийслэл хот болон хотын гадна төмөр зам, авто зам дагуу тээвэр ложистикийн төвд байрлуулахаар төлөвлөнө.

Хотын гаднах эрүүл ахуй, галын аюулгүйн болон бусад онцгой нөхцөлийг хангасан агуулахын бүсэд улсын нөөцийн, нэгдүгээр бүлгийн нефтийн, нефт болон нефтийн бүтээгдэхүүний дамжин өнгөрөх бааз, өтгөрүүлсэн хий, тэсэрч дэлбэрэх бодисын агуулах, хүчтэй нөлөөлөх хортой бодис, хүнсний нөөцийн агуулах, малын тэжээл болон үйлдвэрийн түүхий эд, мод бэлтгэл, барилгын модон бэлдэц, гуалин зэргийг хадгалах үндсэн байгууламжуудыг төмөр зам, авто замын сүлжээтэй уялдуулан ачаа тээврийн нэгдсэн логистикийн¹⁸ зохион байгуулалттайгаар төлөвлөж болно.

Бүх төрлийн агуулах байрлуулахад газар доорх орон зайг илүү ашиглана. Хөрсөн доорх баялгийг нь авсанаар үүссэн хонгил хөндий зайг ашиглан хүнс болон ахуйн бараа, үнэт баримт бичиг хадгалах, хөргүүр зэрэг гадны нөлөөнд тэсвэртэй, бат бэх найдвартай үйл ажиллагаатай барилга, байгууламж байрлуулж болно.

Энэ төрлийн барилга, байгууламжийг байгуулах тохиолдолд /ашигт малтмал олборлохтой холбоогүй/ газар доорх орон зайг ашиглах норм, дүрмийн дагуу төлөвлөнө.

7.8 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зохион байгуулахад холимог ашиглалтын буюу орон сууцны болон олон нийтийн цогцолбор барилга, байгууламжийг үйлдвэр болон үйлдвэрлэлийн таагүй нөлөөллөөс тусгаарлан хамгаалах арга хэмжээ авна.

7.9 Хот, суурины үйлдвэрийн бүсийн эдэлбэр газрын хэмжээг үйлдвэрийн бүтэц, хүчин чадал, хэтийн төлөв, үйлдвэрийн барилга, байгууламжийн техник технологийн болон галын аюулгүйн шаардлага, барилгажилтын давхрын хэмжээ зэргийг үндэслэн дунджаар 1000 хүнд 4.0-6.0 га байхаар тооцож төлөвлөнө. Мөн ажиллах хүчний шалгуур үзүүлэлтийг хэрэглэж болно. Үүнд:

- 30-60 ажилчин /га (цемент, тоосго, элсэн чихэр, сүлжмэлийн үйлдвэр г.м);
- 150 ажилчин /га (төмөрлөг, зүсмэл, цаас, хүнсний үйлдвэрүүд г.м);
- 500 ажилчин /га (машин, цахилгаан хэрэгсэл, шилний үйлдвэр г.м);
- 1000-1500 ажилчин /га (гутал, бэлэн хувцас, радиогийн үйлдвэр г.м);

¹⁸ “Логистик гэдэг нь хэрэгцээт барааг аль болох бага зардлаар бий болгон хэрэглэгчдэд хүргэх бүх үйл ажиллагааны нийлбэр юм. Өөрөөр хэлбэл түүхий эд нийлүүлэлт, хадгалалтаас эхлээд үйлдвэрлэлийн технологийн үйлдлүүдийн хооронд явагдах хагас бэлэн бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, баглах боох, бэлэн бүтээгдэхүүн хадгалах, хэрэглэгчдэд хүргэх цогц үйл ажиллагаа”

- Технологийн хувьд хорших, үйлдвэрийн нэгжүүд;
- Хаягдал материал ашиглах хорших үйлдвэр;
- Технологийн хувьд сөрөг нөлөө бүхий үйлдвэрийн нэгжүүд

Эрүүл ахуй¹⁹, аюулгүй байдал

7.10 Үйлдвэр аж ахуйн бүсийн төлөвлөлтөнд үйлдвэрийн болон бусад барилга, байгууламжийг байршуулахдаа хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин нөхцөлийг хангах агаар, хөрсний бохирдол, хөрсний болон гүний ус, гол мөрний бохирдолтоос хамгаалахад Агаарын тухай, Усны тухай, Эрүүл ахуйн тухай хууль, норм дүрмийг мөрдөнө

7.11 Аж үйлдвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс²⁰ийн хязгаарт орон сууц, нөхөн сэргээх болон амралт сувилалын бүс, зочид буудал, нийтийн байр, цэцэрлэг, сургууль, эрүүл мэнд, биеийн тамирын байгууллага болон бусад төрлийн аж үйлдвэрийн үйлчилгээтэй холбоогүй олон нийтийн барилга байгууламж барихыг хориглоно. Эрүүл ахуйн бүсийг нөхөн сэргээх болон хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.

Тайлбар: Эрүүл ахуйн бүс нь тухайн үйлдвэрийн зориулалтад хамаарахгүй бөгөөд энэхүү бүсэд зөвшөөрөгдөх объектыг байршуулж болно. Үйлдвэрийн бохирдсон талбайг нөхөн сэргээх, эрүүлжүүлэх, эрүүл ахуйн бүсийн тохижилт, хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбоотой зардлыг хортой хаягдал бүхий үйлдвэр хариуцна.

7.12 Эрүүл ахуйн бүсийн хэмжээг Үйлдвэрийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн норм БНБД 2.09.12-87 болон энэхүү норм, дүрмийн Хавсралт М-ын дагуу тогтооно.

7.13 Үйлдвэрийн бүсийг суурьшлын бүсээс 50.0м-ээс багагүй өргөн мод, бут бүхий хамгаалалтын ногоон зурвасаар зааглаж төлөвлөнө. Эрүүл ахуйн бүсийн өргөн 100.0 м байх тохиолдолд ногоон зурвасын өргөн 20 м-ээс багагүй байна.

7.14 Эрүүл ахуйн бүсийн нормативын хангалттай эсэх үйлдвэрээс гарч буй хортой бодисын замхралтын үзүүлэлтэд Эрүүл ахуйн тухай хуульд заасан эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ²¹г баримтлана. Эрүүл ахуйн бүсийн цэцэрлэгжүүлэлтийг эрүүл ахуйн бүсийн хэмжээнээс хамааран экологийн болон архитектур төлөвлөлтийн нөхцлийг харгалзан тогтооно. Үүнд:

300 м хүртэлх	60%
300-аас 1000 м	50%
» 1000 » 3000 м	40%
» 3000 м	20%

¹⁹ Эрүүл ахуйн тухай хууль:

3.1.1.“эрүүл ахуй” гэж хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчноос шалтгаалан эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг тандах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөхцөл, шаардлагыг;

²⁰ 3.1.11.“эрүүл ахуйн хамгаалалтын бүс” гэж хүн, мал, амьтан, байгаль орчинд эрүүл мэндийн эрсдэл үзүүлэхгүй байхаар тогтоосон зурвас газрыг. ²⁰3.1.9.“эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ” /цаашид “үнэлгээ” гэх/ гэж үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга замыг тодорхойлох, эерэг нөлөөллийг дэмжих ажиллагааг;

²⁰3.1.9.“эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ” /цаашид “үнэлгээ” гэх/ гэж үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга замыг тодорхойлох, эерэг нөлөөллийг дэмжих ажиллагааг;

²¹3.1.9.“эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ” /цаашид “үнэлгээ” гэх/ гэж үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга замыг тодорхойлох, эерэг нөлөөллийг дэмжих ажиллагааг;

7.15 Хөдөөгийн суурины үйлдвэрийн бүсийн төлөвлөлтөнд хөдөө аж ахуйн барилга, байгууламж хоорондын зай үйлдвэрлэлийн технологийн төлөвлөлт, эрүүл ахуйн, мал эмнэлгийн, галын аюулгүйн шаардлагыг мөрдөнө. Мал үржүүлгийн цогцолбор, фермийн нутаг дэвсгэр болон тэдгээрийн эрүүл ахуйн бүсэд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дахин боловсруулах үйлдвэрлэл хоолны газар болон түүнтэй ижил үйлчилгээ байрлуулахыг хориглоно. 300.0 м-ээс их эрүүл ахуйн бүс бүхий объектуудыг хөдөөгийн суурины гадна, тусгай талбайд байршуулж төлөвлөнө.

7.16 Үйлдвэрийн дуу шуугиан, доргио чичиргээ, цацраг туяа, цахилгаан долгион, ионжуулалтын нөлөөлөл, орчиндоо хортой болон тааламжгүй үнэр гаргах нөхцөл зэргийг харгалзан эрүүл ахуйн бүс тогтооно. Дуу шуугиан ихтэй, бохирдол үзүүлэх нөлөө бүхий үйлдвэрийн барилга, байгууламжийг зонхилох салхины дээр байрлуулахыг хориглоно.

Хүснэгт 7.1 Эрүүл ахуйн бүсийн норматив

Ангилал	Орчны нөлөөлөл	Хамгаалалтын бүсийн хэмжээ, м
I	Аэродромоос хөөрөх агаарын хөлгийн техникийн үзүүлэлтээс хамаарч дуу чимээний нөлөөлөл /120дб-с их/	2500.0м дээш
II	Алслагдсан орчин хүртэл хүчтэй бохирдол үзүүлэх нөлөөтэй, дуу чимээ /120 дб–с их /	1000.0м
III	Ойр орчиндоо ихээхэн бохирдол үзүүлэх нөлөөтэй, дуу чимээ нь 100-120 дб	500.0м
IV	Зөвхөн орчин тойрондоо бохирдол үзүүлэх нөлөөтэй, дуу чимээ нь 80-100 дб	300.0м
V	Орчноо бага бохирдуулах нөлөөтэй, дуу чимээ нь 80 дб хүртэл	200.0м
VI	Орчиндоо бохирдолгүй	100.0м

Тайлбар: Дуу чимээний нөлөөлөл нь барилга, байгууламжийн гадна орчинд 60 –100 дб-ээс бага тохиолдолд эрүүл ахуйн бүсийн хэмжээг 50% бууруулж төлөвлөхийг зөвшөөрнө.

7.17 Тэсэрч дэлбэрэх материал үйлдвэрлэх, хадгалах барилга, байгууламж бүхий газрыг аюултай бүс гэж үзнэ. Эдгээр бүсийн хэмжээ нь техникийн хяналт (тэсэлгээний ажил гүйцэтгэх)-ын тусгай нормативаар тодорхойлогдоно.

7.18 Аюултай бүсэд орон сууц олон нийтийн болон үйлдвэрийн барилга, байгууламж барихыг хориглох бөгөөд онцгой тохиолдолд орон нутгийн захиргаа тухайн барилга, байгууламжийг эзэмших эрх бүхий байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүй норм БНБД 21-03-04 болон бусад холбогдох хууль, тогтоомжийг баримтлана.

7.19 Тээвэрлэлт болон хадгалалтын явцад тэсрэх, гал авалцах, байшин барилга, тоног төхөөрөмж, агуулах, сав, тээврийн хэрэгслийг эвдлэх, хүн, мал, амьтныг гэмтээх, хордуулах, түлэх, хорт туяаны цацраг зэрэг нөлөө үзүүлэх бодис, биет материал хадгалах байгууламж нь Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS 4978:2017-ыг хангасан байна.

7.20 Аж ахуй, агуулахын цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам, орон нутгийн зориулалттай бусад шугам, сүлжээг төвийн сүлжээнд холбогдох байдлыг харгалзан тариалангийн талбай, ойн зурвасын хил дагуу, хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг дайрахгүйгээр төлөвлөнө.

7.21 Тээвэр, харилцаа холбоо, инженерийн шугам сүлжээний ашиглалтын үед гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс хамгаалах оршин суугчдад шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх зорилгоор суурьшлын болон нөхөн сэргээх бүс хүртэл эрүүл ахуйн бүс тогтооно. Шаардлагатай тохиолдолд суурьшлын бүсийн гадна байгуулж төлөвлөнө. Тээвэр, харилцаа холбоо, инженерийн сүлжээ зэрэг объектын эзэмшлийн болон эрүүл ахуй хамгаалалтын бүсийг техник ашиглалтын онцлогийг харгалзан зүлэгжүүлж тохижуулна.

Төмөр замын ерөнхий сүлжээний шинэ ангилах станцыг хотын гадна байгуулна. Ангилах станц болон орон сууц, олон нийтийн байгууллага хоорондын зай ачаа эргэлт, тээвэрлэж байгаа барааны галын болон тэсэрч дэлбэрэх аюул түүнчлэн дуу чимээ, доргилтын зөвшөөрөгдөх хэмжээ зэргийг тооцоолсны үндсэн дээр ойролцоогоор 150.0 м байна.

7.22 Төмөр замын сүлжээ өөр хоорондоо болон бусад /суурины гол гудамж, хотын зам, трамвайн болон троллейбусны шугам/ тээврийн замын огтлолцолын өөр өөр түвшинг дараахь зэрэглэлээр авч үзнэ. Үүнд: I, II –суурин газрын гадна; III, IV- суурьшлын бүсийн гадна тус тус байгуулна.


7.23 Орон сууцны барилга төмөр замаас зайлшгүй тусгаарлагдсан байх ба энэ нь эрүүл ахуйн шаардлага, тооцоогоор тодорхойлогдоно.

7.24 Нисэх онгоц болон вертолетны буудал суурьшлын бүс, холимог ашиглалтын болон нөхөн сэргээх бүсийн хилээс нислэгийн аюулгүй байдал болон агаарын нислэгийн зөвшөөрөгдөх дуу чимээ; агаар дахь бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, цахилгаан соронзон долгион, цацраг туяаны энэхүү нутаг дэвсгэрт тогтоосон эрүүл ахуйн зайд алслагдсан байна.

Норм, дүрмийн энэхүү шаардлага нь одоо ажиллаж буй онгоцны буудлын бүсэд байгаа болон шинээр барих, дахин төлөвлөх суурьшлын бүс, нөхөн сэргээх бүсэд мөн адил мөрдөгдөнө. Нисэх буудлын байршил, эдэлбэр газрын төлөвлөлтийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн хүрээнд холбогдох эрх бүхий байгууллага орон нутгийн захиргаатай зөвшөөрөлцөнө.

7.25 Хот, суурины агаарын тээврийн нислэгийн эрүүл ахуй, аюулгүй байдлын төлөвлөлтөнд Аэродром БНБД 3.0.05-89-ийг мөрдөнө. Иргэний нисэхийн навигацийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал, аюулгүйн ажиллагааг хангах үүднээс 3000м радиуст аюулгүйн бүс төлөвлөнө.

7.26 Аэродром, хэлипорт/хэлипат²² нь “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичгийн 7.5 болон “Аэродром. Хэлипортод тавигдах шаардлага” MNS6784:2019 стандарт, Иргэний нисэхийн дүрэм /ИНД-77;ИНД-139; ИНД157/-ийн дагуу тогтоосон аюулгүйн бүсээс алслагдсан байна. *Тайлбар:* Хот, сууринд хэлипорт/хэлипат төлөвлөх бол агаарын зайгаар хоорондоо 1600м-ээс ихгүй байхаар тооцоно



Зураг 8.1 Аэродромын бүс

²² Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/131 дүгээр тушаалаар батлагдсан “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичиг

7.27 Аэродромын тусгай бүсийг агаарын хөлгийн буулт хөөрөлтийн чиглэлийн дагууд хөөрч буух зурвасны босго /НЗ/-ноос 4300м урт, хөөрч буух зурвасны тэнхлэгээс хоёр тийш тус бүр 1000 м буюу нийт 2000 м өргөнтэй тэгш өнцөг хэлбэрээр тогтооно. Аэродром орчмын "Тусгай бүс"-д Иргэний нисэхийн зориулалттай барилга, байгууламжаас бусад барилга, байгууламж барихыг хориглоно.

7.28 Аэродромын ойртолын бүсийг агаарын хөлгийн буулт хөөрөлтийн чиглэлийн дагууд хөөрч буух зурвасын 3 км радиустай **аюулгүйн бүсийн** хязгаараас 3600м /аэродромын бүсчлэлийн дугаар 2.1/; 8400м /аэродромын бүсчлэлийн дугаар 2.2/-т тус тус тогтооно. Шинээр барилга байгууламж барих бол нисэх буудалтай зөвшөөрөлцөнө. Аэродром орчмын аюулгүйн бүс /аэродромын бүсчлэлийн дугаар 3/-ийн төлөвлөлтөнд "Аэродромын төлөвлөлт ба ашиглалт" техникийн баримт бичгийг мөрдөнө.

7.29 Аэродромын бүсэд агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдал, жолоодлогод нөлөөлж болохуйц барилга, өндөр хүчдэлийн шугам, радиотехникийн байгууламж барих асуудлыг тухайн байгууллагын үйл ажиллагаатай нягт уялдуулсан байна. Барилга, байгууламж барих үйл ажиллагааны уялдааг холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон иргэний нисэхийн удирдах байгууллага хариуцан зохицуулна.

7.30 Аэродромын үйл ажиллагааны уялдаа зохицуулалтанд дараахь барилга, байгууламжийн байршил хамаарна.

Байршил сонгоход анхаарах асуудал:

1/ Нисэх онгоцны буудалд ойртох агаарын замын зурвас буюу онгоцны буудлын /онгоц буух, хөөрөх/ хяналтын цэг (БХЦ)-ээс 10км-ийн радиус дотор онгоцны буудлын бүх объектуудыг байршуулна;

2/ Аэродромын хяналтын цэгээс 30 **/15/** км-ийн радиуст 50м **/45/** болон түүнээс өндөр барилга, байгууламж;

Байршил хамаарахгүй:

3/ газрын түвшинээс 50м **/45/** болон түүнээс өндөр объект;

4/ радиотехникийн хэвийн ажиллагаанд нөлөөлөхүйц холбоо мэдээллийн болон цахилгааны шугам сүлжээ, электомагнитын бусад байгууламж;

5/ тэсрэх аюултай объект;

6/ ослын үед шаардагдах бамбарын төхөөрмж;

7/ нисэх онгоцны буудлын үзэгдэх орчинд саад учруулах аж үйлдвэрийн болон бусад төрлийн үйлдвэрийн барилга, байгууламж;

3 болон 7-д заасан барилга, байгууламжийн байршил, аюулгүйн шаардлага нь 2-т заасан нөхцлийг зөрчиж байгаа тохиолдолд зохицуулалт хийнэ.

БХЦ (буудлын хяналтын цэг)-ээс 15 км дотор жигүүртэн шувууд олноор цугларах, амьтан үржүүлгийн газар, малын нядалгааны газар, хүнсний болон бусад хаягдал ялгаруулах бүхий газар байршуулахыг хориглоно.

Тайлбар: 1. Онцолсон зохицуулалтууд нь тухайн газарт гурван жилийн хугацаанд ямар нэг барилгын ажил хийгдээгүй бол; 2. БХЦ нь онгоцны буудлын геометр төвийн орчинд байрлах ёстой:

- Буух-хөөрөх нэг зурвас (БХЗ)-тай тохиолдолд геометр төвд нь;
- Зэрэгцсэн хоёр БХЗ-тай тохиолдолд төвүүдийг холбосон шулуун шугамын төвд;
- Зэрэгцсэн бус БХЗ-тай тохиолдолд БХЦ-ээс босгосон тэгш өнцөгтийн /перпендикуляр хоёр шугамын/ огтлолцолын цэг дээр;

3) Өндөр барилга барих тохиолдолд барилгын зураг төсөлд тухайн барилгын солбилцлыг /координат/ заасан байна. 4. Бамбарын төхөөрөмжийн өндрийг тодорхойлохдоо галын дөл хамгийн өндөрт хаях цэгийг тооцох ёстой.

7.31 Усан замын²³ жолоодлогын төхөөрөмжийн бүсэд шинээр барилга барих болон засварлах төлөвлөлтөнд Монгол улсын Усан замын тээврийн тухай хууль, дүрэм, журмыг мөрдөнө.

7.32 Усан замын зогсоол буюу усан замын төв буудлыг орон сууцны барилгаас 100м хүртэлх зайд байрлуулна. Усан боомтын тусгай зориулалтын хил дэх байгууламжуудаас орон сууцны барилга хүртэлх эрүүл ахуйн бүсийн норматив /метр/:

- Шатах болон шатамхай шингэний (агуулахыг голын урсгалаас доош байрлуулах тохиолдолд)* агуулахын хилээс.....500.0
- Тоосжилттой ачаа хадгалах агуулахын ачиж буулгах хилээс.....300.0
- Шатамхай шингэн юүлэх, савлах төхөөрөмж бүхий агуулахаас:
 - I.200.0
 - II ба III100.0
- Боомт (загас боловсруулалт хийдэггүй)-оос100.0
- Голын урсгалын дээд талд байрлах агуулах, зэрэглэлээр /метр/:
 - I5000.0
 - II ба III3000.0

* тогтоосон зайг эргийн амралтын бүс, усан зогсоол, усан онгоцны зогсоол, усан цахилгаан станц, аж үйлдвэрийн барилга болон гүүрэн байгууламжид мөн баримтлана.

Тайлбар: 1. Далайн болон усан боомтын нутаг дэвсгэрт гал унтраах машин явах зам, ус соруулж авах талбай төлөвлөнө. 2. Ачаа эргэлт багатай боомтод ачааны болон зорчигч тээврийн нэгдсэн төв төлөвлөнө.

7.33 Усан замын зогсоол буюу усан замын төв буудлыг хот, суурины гадна байрлуулж төлөвлөх ба хот дотор байрлах тохиолдолд суурьшлын болон нөхөн сэргээх бүсийн гадна байрлуулна.

Салхи болон давалгаа, хаялга, голын урсцын хүчийг сааруулах зориулалт бүхий далан (хаалт, хашлага)-г тооцож төлөвлөсөн байх шаардлагатай. Эвхэгддэг далбаатай онгоц хадгалах талбайн хэмжээ 27.0 м² байна

Тайлбар: 1. Дурдсан хэмжээ нь амралтын бүсэд оршин суугчдад үйлчлэх үйлчилгээний болон усан спортын байгууламжид үл хамаарна.

7.34 Усан замын тээврийн хяналтын байр, харуулын цамхаг, завины өвлийн битүү зогсоол, ариун цэврийн байгууламжийн барилга, нуурын эрэгт хяналтын зориулалттай завины зогсоол зэрэг барилга, байгууламж бүхий хяналтын постыг нуурын эргээс 50.0 метрт төлөвлөх шаардлагатай. Усан замын тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийн /хяналтын бүс/ талбайг гол, мөрөн, нуурын эргээс 500 м-ээс дотогш байгуулахыг хориглоно.

7.35 Хот, суурины эрүүл ахуйн цэвэрлэгээнд хүрээлэн буй орчин, байгалийн нөөц баялгийг хамгаалах шаардлагатай уялдан, нийтийн аж ахуй ба үйлдвэрийн газраас гарах хаягдлыг цуглуулах, зайлуулах, хоргүйжүүлэх ажиллагаа, бохир ус зайлуулах, ариутгах систем хамаарна.

7.36 Ахуйн хог хаягдлын хэмжээг хавсралт П-ын дагуу тооцож төлөвлөнө. Үйлдвэрийн хог хаягдлыг хоргүйжүүлэх, тээвэрлэх, дахин боловсруулах үйлдвэр, байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг хүснэгт 7.2-ыг үндэслэн тодорхойлно.

²³ Усан замын тээврийн тухай хууль

3.1.1. "усан зам" гэж усан замын тээврийн хэрэгслийг аюулгүйгээр зорчиход тогтоосон хөвөлтийн болон бусад дохио, тэмдэг бүхий байгалийн болон хиймлээр барьж байгуулсан усан зурвасыг;

Тайлбар: *Гадаргын урсац усны ил цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн бүс суурьшлийн бүсээс 100.0 м, битүү байгууламжтай бол 50.0 м зайд тус тус байрлана.

Хүснэгт 7.2

Үйлдвэрийн газар ба байгууламж	1000 тн ахуйн хаягдалд ногдох эдэлбэр газрын хэмжээ, га	Эрүүл ахуйн бүсийн хэмжээ, м
Хог боловсруулах ба шатаах үйлдвэр, хүч чадал мян.тонн/жил:		
• 100 хүртэл	0.05	300.0
• 100-аас дээш	0.05	500.0
Органик бордооны агуулах	0.04	300.0
Полигон	0.02	500.0
Органик бордооны талбай	0.5-1.0	500.0
Хог ачиж, буулгах станцууд	0.04	100.0
Юүлэх станц	0.02	300.0
Халдваргүйжүүлсэн лаг, тунадас (хуурай бодисын агууламжаар) агуулах, “булшлах” талбай	0.3	1000.0
<i>Тайлбар:</i>		
1. Полигоны хамгийн бага эдэлбэр газрын хэмжээ нь элсэрхэг хөрсөн дээр барих байгууламжийн ангилалд хамаарна.		
2. Хог боловсруулах ба шатаах байгууламжаас агаарт хортой бодис цацах тохиолдолд ариун цэвэр - хамгаалалтын бүсийг бохирдлыг саармагжуулах шаардлагатай уялдуулан тогтооно.		

8. Нөхөн сэргээх бүс. Онцгой хамгаалалтын нутаг²⁴ дэвсгэр

8.1 Хот, суурины нөхөн сэргээх бүсэд ойжуулсан газар, цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамж, нуур, цөөрөм, усан сан, голын эрэг дагуух наран шарлагын газар болон аялал жуулчлал, биеийн тамир спортоор хичээллэх зэрэг оршин суугчдын амрах, алжаал тайлах зориулалтын барилга, байгууламж төлөвлөнө. Хот, орон нутгийн онцгой хамгаалалтын нутаг дэвсгэрт байгаль хамгаалах, эрдэм шинжилгээний, түүх-соёлын, гоо зүйн, нөхөн сэргээх, бие бялдар эрүүлжүүлэх болон бусад онцгой зориулалттай газрууд багтана.

8.2 Нөхөн сэргээх бүс болон онцгой хамгаалалтын нутаг дэвсгэрт эрүүл мэндийн болон байгаль хамгаалах үйл ажиллагаатай хамааралгүй ашиглагдаж байгаа үйлдвэр, аж ахуй, агуулахын болон бусад барилга, байгууламжийг өргөтгөх, шинээр барихыг хориглоно. Онцгой хамгаалалттай газар нутаг, рашаан сувиллын газрын ашиглалтын горимыг тогтооход Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг үндэслэл болгоно.

8.3 Хот, орон нутгийн байгалийн тогтоцтой уялдуулан нутаг дэвсгэрийн нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн нэг хүнд ногдох хэмжээг дараахи байдлаар тооцож тасралтгүй хөгжүүлэхээр төлөвлөнө. Хотын ногоон байгууламжийг нийтийн хэрэгцээний зүлэгжүүлсэн талбайн нэмэгдүүлэх зорилгоор бий болсон ландшафт, экосистемтэй харилцах харилцаа зэргийг хэвээр хадгалан ойн бүс болгон сайжруулж болно.

Тайлбар: Байгаль цаг уурын нөхцөлөөс шалтгаалан дээр дурдсан үзүүлэлтүүдийг 20%-с хэртүүлэхгүйгээр ихэсгэх, багасгахыг зөвшөөрнө.

²⁴ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараахь байдлаар ангилна:

- 1/ дархан цаазат газар;
- 2/ байгалийн цогцолборт газар;
- 3/ байгалийн нөөц газар;
- 4/ дурсгалт газар.

8.4 Хотын болон хорооллын цэцэрлэгт хүрээлэнд нийтийн тээврээр зорчих хугацаа ойролцоогоор хотын цэцэрлэгт 30, хорооллын цэцэрлэгт 20 минутаас ихгүй байвал зохино.

Амьтны хүрээлэнг нөхөн сэргээлтийн бүсэд төлөвлөхийг зөвшөөрнө. Амьтны хүрээлэнгийн эзэмшил газрын хилээс орон сууц, олон нийтийн барилга хүртэлх зай 50.0м-ээс багагүй байх ба орон нутгийн эрүүл ахуйн байгууллагатай зөвшөөрөлцөнө.

8.5 Цэцэрлэгт гудамж байгуулахад явган хөдөлгөөний чиглэлийг тооцоолж явган хүний зам, түр амрах талбай байрлуулж төлөвлөнө.

Нэг чигийн хөдөлгөөнтэй явган замтай цэцэрлэгт гудамжны өргөн /м-ээс багагүй/:

- Гудамжны тэнхлэгээр.....18.0
- Гудамны нэг талаас зорчих хэсэг ба барилгажилт хооронд..... 10.0

Явган хүний зам, амралтын талбай бүхий цэцэрлэгт гудамжны байршил, хэмжээ, хөндлөн огтлолыг гудамжны барилгажилтын архитектур төлөвлөлтийн шийдэлтэй уялдуулан тодорхойлно.

Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамжыг сэргээн засварлах тохиолдолд дээрхи эдэлбэр газрын хэмжээг багасгаж төлөвлөхийг зөвшөөрнө.

8.6 Барилга, инженерийн болон тохижилтын байгууламжаас мод, бут хүртэлх зай хэмжээг хүснэгт 8.1-ийн дагуу тооцож төлөвлөнө.

Хүснэгт 8.1

д/д	Барилга, байгууламж	Барилга, байгууламжаас мод, бутны тэнхлэг хүртэлх зай (м)	
		Мод	Бут
1	Барилга байгууламжийн гадна хана	5,0	1,5
2	Явган хүний зам	0,7	0,5
3	Гудамжны зорчих хэсгийн замын хашлага, суваг шуудууны зах	2,0	1,0
4	Гэрэлтүүлгийн шугамын шон, цамхаг, гүүрийн тулгуур тавцан	4,0	-
5	Налуу газар, террасны ирмэг	1,0	0,5
6	Тулгуур ханын дотоод ирмэг	3,0	1,0
7	Газар доорх сүлжээ: - Хий дамжуулах хоолой, бохир ус дамжуулах хоолой - Дулааны шугам сүлжээ /сувгийн хана, суваггүй тавьсан эсвэл хонгилд тавьсан хоолойн гадаргуу хана/ - Ус дамжуулах болон ус зайлуулах хоолой - Өндөр хүчдэлийн кабель, холбооны кабель	1,5 2,0 2,0 2,0	- 1,0 - -

Тайлбар:

1. Энэхүү үзүүлэлт нь модны голч нь 5.0м хүртэл болон түүнээс том тойрог бүхий модонд хамаарна.
2. Цахилгаан дамжуулах агаарын шугамаас мод хүртэлх зайг цахилгаан төхөөрөмж суурилуулах дүрмийн дагуу гүйцэтгэнэ.
3. Барилгын дэргэдэх мод орон сууц, олон нийтийн өрөө тасалгаанд тусах нарны тусгал болон гэрэлтүүлгийг бууруулахааргүй байх ёстой.

8.7 Нөхөн сэргээх бүсэд нийтийн тээврээр 1.5 цаг явах зайд олныг хамарсан түр хугацааны амралт төлөвлөнө. Олныг хамарсан түр хугацааны амралт (цаашид амралтын бүс гэх)-ын талбайг нэг зочинд 500 хүртэл м² байхаар, идэвхитэй амралтын хэсэгт нэг зочинд 100 м² байхаар тус тус тооцож төлөвлөнө. Түр хугацааны амралтын талбайг 50.0 хүртэлх га байхыг зөвшөөрнө.

8.8 Хот, суурины нутаг дэвсгэрт байрлах нийтийн хэрэгцээний ногоон байгууламж парк, сад, сквер, бульварын хэмжээг хүснэгт 8.2-ын дагуу тооцож төлөвлөнө. Хотын нутаг дэвсгэр дэх ойг цэцэрлэгт хүрээлэн болгож тэдгээрийг хүснэгт 8.2-т заасны дагуу нэг хүнд 5.0 м^2 –аас ихгүйгээр тооцон нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн бүтцэд авч үзнэ.

Хүснэгт 8.2

Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн хэмжээ $\text{м}^2/\text{хүн}$			Үйлчлэх хүрээ
	Нийслэл хот	Хот	Хөдөөгийн суурин	
Хотын	10.0	7.0-(10.0)*	12.0	20 минут
Хорооллын	6.0	6.0	-	15 минут

* 20 000 хүн ам бүхий хот, сууринд хамаарах норматив.

Тайлбар:

1. Амралт сувилал хотын хувьд хотын нийтийн хэрэгцээний зүлэгжүүлсэн нутаг дэвсгэрийг 50%-иас ихгүйгээр нэмэгдүүлж болно.
2. Тундр болон ойт тундрын нийтийн хэрэгцээний зүлэгжүүлсэн талбайг 2 м^2 /хүн хүртэл багасгаж; говь болон элсэн цөлийн бүсэд 20-30% хүртэл; тал хээрийн бүсэд 10-20% ихэсгэж болно.
3. Ой модоор хүрээлэгдсэн, томоохон гол мөрөн, усан сангийн дэргэдэх хот, хөдөөгийн суурины нийтийн хэрэгцээний зүлэгжүүлсэн талбайг 20% хүртэл багасгаж болно.
4. Нэг км-ээс илүү эрүүл ахуйн бүс шаардагдах тохиолдолд хотын барилгажсан нутаг дэвсгэрийн зүлэгжүүлэлтийн түвшинг 15%-иас багагүйгээр нэмэгдүүлнэ.

8.9 Ногоон байгууламжийн бүтцэд нийтийн хэрэгцээний 0.5км өргөн болон түүнээс их томоохон цэцэрлэгт хүрээлэн болон ойн цэцэрлэг 10-аас багагүй хувийг эзлэнэ.

8.10 Цэцэрлэгт хүрээлэн, ойн цэцэрлэг, ногоон бүсийн нэгэн зэрэг хүлээж авах хүний тоо: /хүн/га/

- Хот, суурины цэцэрлэгт хүрээлэнд100.0
- Амралтын цэцэрлэгт хүрээлэнд70.0
- Сувилалын цэцэрлэгт хүрээлэнд..... 50.0
- Ойн цэцэрлэг (нуга, усан цэнгэлдэх).....10.0
- Ногоон бүс.....1.0-3.0

Тайлбар: 1. Говь, цөлийн бүсэд 20%-иар багасгахыг зөвшөөрнө. 2. Нэгэн зэрэг олон зочин хүлээн авах хүчин чадал 10-15 хүн/га байхаар тооцон хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор явган хүний зам, ойн чөлөөнд нэгэн зэрэг буюу 50 хүн/га хүлээн авах хүчин чадлаар тооцон хөрс хамгаалах суулгац, ойн тогтоцыг цэцэрлэгт хүрээлэн болгон өөрчлөнө.

8.11 Нийслэл хот, хотуудад хотын болон хорооллын цэцэрлэгт хүрээлэнгээс гадна тусгай буюу хүүхдийн, биеийн тамирын, үзэсгэлэнгийн, амьтны болон бусад төрлийн хүрээлэн, ботаникийн цэцэрлэг байхаар төлөвлөх ба хэмжээг тухайн төлөвлөлттэй уялдуулан тодорхойлно. Хүүхдийн цэцэрлэгт хүрээлэнг $0,5\text{м}^2/\text{хүн}$ байхаар тооцож биеийн тамир спортын төхөөрөмж бүхий талбайтай төлөвлөнө.

8.12 Танин мэдэхүй, гоо сайхны үнэ цэнэ бүхий байгалийн тогтоц (ландшафт)-нь хадгалагдсан газар нутагт үндэсний болон байгалийн цогцолбор хүрээлэн байгуулахаар төлөвлөнө. Үндэсний болон байгалийн хүрээлэнгийн архитектур орон зайн зохион байгуулалтад тухайн газрыг эрдэм шинжилгээ, соёл-боловсролын болон амралт зугаалгын зориулалтаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн бүсийн дэглэмд нийцүүлэн ашиглах боломжийг тооцож төлөвлөнө.

8.13 Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газрын хязгаарлалтын бүсэд байгаль хамгаалах, эрдэм шинжилгээний, түүх-соёлын, нөхөн сэргээх, эрүүлжүүлэх болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад онцгой зориулалтын газрууд төлөвлөнө,

8.14 Цэцэрлэгт хүрээлэн болон цэцэрлэг байгуулахад өмнө нь байсан суулгац болон усан сан бүхий хэсгүүдийг аль болох хэвээр хадгална. Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамжийн талбайн хэмжээ /га/:

хотын цэцэрлэгт хүрээлэнд15.0;

орон сууцны хороололд10.0;

орон сууцны бичил хороололд3.0;

цэцэрлэгт гудамжинд0,5 (дахин төлөвлөлтөнд 0,1)-аас багагүй байхаар тооцож болно.

Нийт талбайн хэмжээнд цэцэрлэгт хүрээлэн дэх ногоон байгууламжийн талбай нь 70%-иас багагүй байна.

Тундр, ойт тундрын бүс дэх хотын хувьд цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгт талбай болон барилга дотор өвлийн цэцэрлэг 1.0-1.5 га байхаар тооцож болно.

8.15 Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж бүхий газар нь архитектурын жижиг хэлбэрүүд, усан оргилуур, бассейн, шат, налуу талбай, түшиц хана, сүүдрэвч, гэрэлтүүлэгээр тохижуулан тоноглогдсон байна

8.16 Хот болон орон нутгийн задгай орон зай, зүлэгжүүлсэн талбайг тасралтгүй арчлан хөгжүүлэх системээр төлөвлөнө. Хотын бүс дэх янз бүрийн зориулалттай зүлэгжүүлсэн талбайн эзлэх хувь (барилгын зүлэгжүүлэлтийн түвшин) 40% хүртэл байх бол орон сууцны хэсэгт 25% (бичил хорооллын зүлэгжүүлсэн талбайн ерөнхий талбайг оруулан) хүртэл байна.

8.17 Газрын нутгийн ландшафт, нөхөн сэргэх орчин, замын сүлжээ (зам, гудамжилж тарьсан мод, жим)-г явган зорчигчдын явах үндсэн чиглэлийн дагуу аль болох бага налуутай, зогсоол, амралтын цэг, тоглоом болон биеийн тамирын талбай руу хамгийн дөтөөр хөтөлсөн байхаар тооцно.

Явган хүний замын өргөн нь 0,75м буюу нэг хүн чөлөөтэй алхах хэмжээтэй байх ба явган хүний зам, талбайг байгалийн чулуун хийцтэй төлөвлөхийг зөвшөөрнө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн замын дагуугийн налуу 8%-с ихгүй, хөндлөн налуу 2%-с ихгүй, замын өргөн 1.0м-ээс багагүй байна.

8.18 Хот, суурины хэрэгцээнд ногоон бүсэд мод, бут, цэцгийн хүлэмж, мод үржүүлгийн газар байгуулна. Мод үржүүлгийн газрын талбай 80.0 га-с багагүй байна.

Мод үржүүлгийн талбайг 3-5м²/хүн байхаар, оршин суугчдын нийтийн хэрэгцээний ногоон байгууламжаар хангагдсан түвшин, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, цэцэрлэгжүүлэх нөхөрлөлийн хөгжлийн түвшин, байгаль цаг уурын онцлог зэрэгт үндэслэн тооцож төлөвлөнө. Цэцгийн хүлэмжийн нийт талбайг 0,4м²/хүн байхаар тооцно

Амралт, сувилалын төлөвлөлт

8.19 Онцгой хамгаалалттай газар нутгийн бүтцэд байгалийн эмчилгээний хүчин зүйл /рашаан/ бүхий хамгийн тохиромжтой бичил орчин, байгалийн ороншил (ландшафт) болон эрүүл ахуйн тааламжит нөхцөл бүхий газар нутаг хамаарна.

Сувиллын нутаг дэвсгэрт сувилал-амралтын газар болон бялдаржуулан эрүүлжүүлэх байгууллага, амралт жуулчлалын амрагчид болон эмчлүүлэгчдэд үйлчлэх үйлчилгээний

байгууллага, амралтын газрын цэцэрлэгт хүрээлэн болон бусад төрлийн нийтийн хэрэгцээний зүлэгжүүлсэн талбай, наран шарлагын газар байрлаж болно.

Сувилалын газрын нийтийн хэрэгцээний зүлэгжүүлсэн талбайн хэмжээ рашаан сувилалын болон баялдаржуулан эрүүлжүүлэх байгууллагын нэг байранд 100 м² байхаар тооцно.

Тайлбар: Тал хээрийн бүсэд амралтын газрын нийтийн хэрэгцээний зүлэгжүүлсэн талбайн хэмжээг 50%-иас хэтрүүлэхгүйгээр багасгаж төлөвлөхийг зөвшөөрнө.

8.20 Онцгой хамгаалалттай газар нутгийн ашиглалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна. Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд байгалийн эмчилгээний хүчин зүйл, эрүүл ахуйн болон нэн тохиромжтой бичил цаг уур, хөрсний тогтоц бүхий бие бялдар эрүүлжүүлэх-эмчилгээ сувилалын газар төлөвлөж болно.

8.21 Голын эрэг дагуух зурвас газарт амралтын, амралт-сувиллын байгууллага байгуулахад энэхүү норм, дүрмийн 8 дугаар бүлгийн холбогдох зүйл заалтыг баримтлах ба голын эрэг, усан сангаас 50.0 метр хүртэлх зайд байрлуулна.

8.22 Амралт-сувиллын газрыг шинээр болон дахин төлөвлөхөд сувилал-амралтын газар болон бялдаржуулан эрүүлжүүлэх байгууллагын эдэлбэр газрын хязгаар дараахи үзүүлэлтээс багагүй байна, /метр/:

- Орон сууц (амралтын болон сувиллын үйлчилгээнд үл хамаарах), агуулах, аж ахуйн барилга, байгууламж хүртэл500.0
- Төмөр замын зам, сүлжээ хүртэл500.0
- I-III зэрэглэлийн автозам хүртэл500.0
- IV зэрэглэлийн авто зам хүртэл200.0
- Зуслангийн барилга хүртэл300.0

Нийтийг хамарсан түр хугацааны амралтын газрыг нийтийн тээврээр зорчих зөвшөөрөгдөх хэмжээ 1.5 цагаас ихгүй байхаар байршуулж төлөвлөнө.

8.23 Амралт, сувилалын эдэлбэр газрын захаас рашаан сувилалын барилга, байгууламж хүртэлх зай хэмжээг доор дурдсанаас багагүйгээр тооцож төлөвлөнө.

- Нийтийн аж ахуй ба агуулах, ажиллагсадын орон сууцны барилга, байгууламж хүртэл500.0м;
- Автозам хүртэл.....200.0-500.0м

8.24 Амралтын бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээг нэг хүнд 500-1000м² идэвхитэй амралтын талбайн хэмжээ нэг хүнд 100 м² байхаар тус тус тооцно. Нийтийг хамарсан түр хугацааны амралтын газрын талбай нь 50.0 га-аас багагүй говь, цөлийн бүсэд 30.0 га-аас багагүй байхаар тооцно.

8.25 Амралтын бүсийг сувилал, хүүхдийн зуслан, сургуулийн өмнөх насны хүүхдийн сувилал-бялдаржуулах байгууллага, авто зам, төмөр зам зэргээс 500.0 м-ээс багагүй, амралтын газраас 300.0 м-ээс багагүй зайд тус тус байрлууна.

8.26 Ойн парк, амралт, сувиллын газрын дэргэд байрлах тээврийн хэрэгсэлийн зогсоолын хэмжээг энэхүү эмхэтгэлийн хавсралт И-ын дагуу тооцож төлөвлөнө. Шаардлагатай тохиолдолд зураг төсөл боловсруулах даалгаварыг үндэслэл болгоно.

8.27 Сувилалын газрын төлөвлөлтөнд дараахь зүйлийг анхаарна. Үүнд:

- урт хугацаагаар амрах сувилал-амралтын газар нь дуу, шуугианы зөвшөөрөгдөх хэмжээг хангасан байх; хүүхдийн амралт-сувиллын болон бялдаржуулан эрүүлжүүлэх газар нь насанд хүрэгчдийн адил барилга, байгууламжаас 100.0м өргөн ногоон байгууламжаар тусгаарлагдсан байх;

- үйлдвэр аж ахуйн болон нийтийн эзэмшлийн агуулах, орон сууц олон нийтийн барилга зэрэг амрагч, эмчлүүлэгчийн үйлчилгээнд холбогдолгүй барилга, байгууламжийг амралтын бүсийн гадна төлөвлөх;

- тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг хязгаарлаж тээврийн хэрэгсэл дамжин өнгөрөх хөдөлгөөнийг хориглох;

Амралт-сувиллын болон бялдаржуулан эрүүлжүүлэх газрын үйлчилгээний ажилтнуудын орон сууцыг амралтын бүсийн гадна, ажилд ирэх хугацааг 30 минут байхаар тооцож болно.

8.28 Амралтын зориулалтын газарт байрлах ижил төрлийн үйл ажиллагаатай болон үйл ажиллагаа нь төстэй амралт-сувиллын болон бялдаржуулан эрүүлжүүлэх газрын эмчилгээ, соёл-ахуйн болон аж ахуйн үйлчилгээг нэгтгэн архитектур-орон зайн оновчтой шийдлээр цогцолбор байдлаар төлөвлөхийг зөвшөөрнө.

8.29 Амралтын болон алжаал тайлах, чөлөөт цагаа өнгөрөөх зориулалтын газарт наран шарлагын газар байгуулахдаа нэг зочинд ногдох талбайг дараахи үзүүлэлтээр тооцно. Үүнд:

- Далайн5.0м²/зочин
- Гол нуурын 8.0м²/зочин
- Далайн болон гол нуурын.....4.0 м²/зочин

Амралт сувиллын бус хөдөө аж ахуйн зориулалттай газрын гол, нуурын эрэг дээрх наран шарлагын талбайн хэмжээ нэг зочинд 5.0 м² байхаар, хөдөлгөөний хомсдолтой өвчтөн эмчлэх тусгай зориулалтын эмчилгээний наран шарлагын газрын талбайн хэмжээ нэг эмчлүүлэгчид 8.0-12.0 м² байхаар тус тус тооцно. Эргийн наран шарлагын зурвасын урт /хамгийн бага/, м: далайн наран шарлагынх 0.2, гол нуурынх 0.25 байна. Наран шарлагын газар нэгэн зэрэг ирэх зочдын тоог, наран шарлагын газрын нэгэн зэрэг ачаалын коэффициентийг тооцож тодорхойлно. Үүнд:

- Сувиллын0.6-0.8
- Амралт, жуулчлалын0.7-0.9
- Хүүхдийн амралтын0.5-1.0
- Нийтийн хэрэгцээний нутгийн хүн ам.....0.2
- Сувиллын0.6-0.8
- Амрах эрхийн бичиггүй0.5

9. Хүрээлэн буй орчин²⁵

9.1 Хот, хөдөөгийн суурины төлөвлөлт, барилгажилтанд экологийн аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах шаардлагыг хангах байгаль орчныг хамгаалах; байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх; хүрээлэн буй орчныг эрүүлжүүлэх арга хэмжээг анхаарна.

9.2 Суурины нутаг дэвсгэрт хөрс, агаарын бохирдол, дуу чимээ, доргилт чичирхийлэлт, цахилгаан соронзон болон цацраг туяа бусад байгалийн болон техноген гаралтай хортой бодисын ялгарлын хэмжээний норматив шаардлага хагагдсан байх ёстой.

Эрүүл ахуйн тухай хууль

²⁵ 3.1.2. "хүрээлэн байгаа орчин" гэж хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлөх байгаль, нийгмийн орчныг;

Хот, суурины архитектур

9.3 Хүн амын амьдралын хэв маяг, орон байрны хэрэгцээ, хүрээлэн буй байгаль орчин, соёл, уламжлал, технологи, эдийн засгийн болон түүхэн нөхцөлүүдээс шалтгаалан хөгжлийн явцад бий болсон барилгажилт, архитектурын хэв загвар, орон зайн зохиомж нь орон нутгийн архитектурын түүх бөгөөд энэ нь хот, суурины төлөвлөлтийн үндэс, төлөвлөлтийн онцлог болно.

9.4 Хот, суурины архитектурын түүхийг тухайн хот, суурины төлөвлөлтийн онцлог болгон хүрээлэн буй орчинтойгоо нягт уялдаатай хөгжих “органик архитектур”-ын шийдлүүдийг сонгож төлөвлөнө. Үүнд:

- Хүрээлэн буй орчны байгаль, газарзүйн онцлогийг тодотгон тодорхойлох;
- Тасралтгүй хөдөлгөөнд орших нөхөн төлжих байгалийн шинж чанарыг тусгах;
- Хүрээлэн буй орчны хувьсал өөрчлөлтөд дасан зохицох;
- Хүмүүсийн нийгмийн болон оюун санааны хэрэгцээг хангах;

9.5 Хот, суурины архитектур төлөвлөлт нь хүний гараар бүтээсэн амьгүй орон зайн төсөөлөл бөгөөд гадаад, дотоод орчны архитектур, орон зайн төлөвлөлтийг хүний эрүүл мэнд, ая тух, аюулгүй байдлыг бүрэн хангасан, хүрээлэн буй байгальдаа зохицсон, амьд организм мэт сэтгэл татам түр төрхийг бүрдүүлж удаан настай, найдвартай орчныг бүтээх шийдлийг тодорхойлж төлөвлөнө.

9.6 Хот, суурины архитектурын бүрэлдэхүүн хэсэг болох түүх соёлын дурсгал, ногоон байгууламж, хүрээлэн буй байгалийн элементүүдийн харилцан шүтэлцээн нь дотоод орон зайг; гадаад орчин, барилгажилт, барилга хоорондын зай, ногоон байгууламж бүхий парк, хүүхдийн тоглоомын талбай, амрах, салхилах орчин зэрэг нь гадаад орон зайг илэрхийлнэ. Төлөвлөлтөнд гадаад, дотоод орчны архитектур, орон зайн зохиомж, байгалийн ландшафтад онцгой анхаарал хандуулан харгалзан үзэх нь нэн чухал.

Байгалийн нөөцийн зохистой ашиглалт ба хамгаалалт

9.7 Хот, суурин газрыг шинээр байгуулах, өртгөтгөн хөгжүүлэх нутаг дэвсгэрийг сонгохдоо нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн баримт бичиг, хот байгуулалтын, газрын, уулын, эрүүл ахуйн, байгаль хамгаалах тухай Монгол улсын эрх зүйн актууд болон бусад хууль, тогтоомжийг үндэслэл болгоно.

9.8 Ашигт талтмалын нөөц бүхий газарт суурин газар, аж үйлдвэрийн цогцолбор болон бусад барилга байгууламж барихыг хориглоно.

Ашигт малтмал бүхий нутаг дэвсгэрт болон газрын гүнд байгууламж барих ажлыг Газрын хэвлийн тухай хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм, журмын дагуу ашигт малтмалыг ашиглах болон барилга, байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулсан тохиолдолд гүйцэтгэнэ.

9.9 Хотын болон хот орчмын бүсийг төлөвлөх, барилгажуулахад Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, тогтоомжинд заасан дараахи ангилалын газрын онцлогийг харгалзан үзнэ. Үүнд: онцгой хамгаалалттай нутаг дэвсгэр – улсын байгалийн дархан цаазат газар; мөн агаар мандалын, үндэсний цэцэрлэгт хүрээлэн, улсын байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газар, мод судлалын хүрээлэн ба ботаникийн цэцэрлэг, түүнчлэн эмчилэн-эрүүлжүүлэх газар ба амралтын газар зэрэг болно.

- 1) Дархан цаазат газар
- 2) Байгалийн цогцолбор газар
- 3) Байгалийн нөөц газар
- 4) Дурсгалт газар гэсэн ангилалын онцлогуудыг харгалзан үзнэ.

9.10 Дархан цаазат газрын бүс нутгийн төлөвлөлтөнд Дархан цаазат газрын онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүсийн дэглэм, хориглох үйл ажиллагаанд ТХГН-ын хуулийг үндэслэл болгоно.

9.11 Байгалийн цогцолбор газрын төлөвлөлтөнд онгон бүс, аялал жуулчлалын бүс, хязгаарлалтын бүсийн дэглэм, хориглох үйл ажиллагаанд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг, рашаан эмчилгээ, амралтын газрын төлөвлөлт, барилгажилтанд эрүүл ахуйн хориглолтын бүс, хязгаарлалтын бүсэд хориглох үйл ажиллагаанд “Усны тухай” хуулийг тус тус мөрдөнө.

9.12 Байгалийн дархан цаазат газар ба үндэсний цэцэрлэгт хүрээлэн орчмын нутаг дэвсгэрт үйл ажиллагааны горимыг нь тогтоосон хамгаалалтын бүс байгуулж болно.

Байгалийн дархан цаазат газарт аж ахуйн зориулалтын ашиглалтыг хориглоно. Гагцхүү хот, суурины оршин суугчдын амьдралыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж тухайлсан хэсэг газарт байрлаж болно.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн нутаг дэвсгэрт өөр хоорондоо ялгаатай үйл ажиллагаа зохицуулах онцгой хамгаалалтын ялгамжтай горим тогтоодог. Үүнд: а) дархан цаазат газар, аливаа аж ахуйн болон нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулахыг хориглосон; б) онцгой хамгаалалт хяналтанд орж орж болох; в) танин мэдэхүй, аялалын; г) нөхөн сэргээх буюу амралт, спортын үйл ажиллагааны зориулалтын.

Харилцан хамаарал бүхий бүсэд биеийн тамир-эрүүлжүүлэх; спортын болон спорт-техникийн байгууламж ба инженерийн; тээврийн хэрэгсэлийн; нийгмийн дэд бүтцийн барилга барих, ашиглахыг зөвшөөрнө. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаатай холбоогүй төв зам, дамжуулах хоолой, аж ахуйн болон орон сууцны барилга, байгууламж барих ашиглахыг хориглоно. Байгалийн цэцэрлэгт хүрээлэнд байгаль хамгаалах, нөхөн сэргээх, хөдөө аж ахуй, газар тариалангийн болон бусад уялдаа холбоо бүхий бүс байгуулж болох ба үүнд мөн онцгой хамгаалалтын горим бүхий түүх-соёлын цогцолбор ба объектууд багтана. Онцгой бүсэд хамгаалалт зохион байгуулж болно.

9.13 Эмчилэн-эрүүлжүүлэх газар, амралтын газрын болон уулын эрүүл ахуй хамгаалалтанд хамгаалалтын янз бүрийн горим бүхий бүсүүдийг онцгойлон анхаарна. Үүнд:

Нэгдүгээр бүс: нутаг дэвсгэр дээр нь байгальд ээлтэй ба хэмнэлттэй технологи бүхий байгалийн эмчилгээний нөөцийг эмчилгээ эрүүлжүүлэх зорилгоор судалгааны ажил эрхлэн ашигладаггүй бол аж ахуйн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглодог;

Хоёрдугаар бүс: тухайн нутаг дэвсгэрт амралт сувиллын орчин бүрдүүлэх, хөгжүүлэхтэй холбоогүй барилга, байгууламж барих түүнчлэн хүрээлэн буй орчныг бохирдуулах, байгалийн эмчилгээний нөөцийн хомсдол үүсгэх аливаа үйл ажиллагаа хориотой;

Гуравдугаар бүс: нутаг дэвсгэр дээр нь хязгаарлагдмал хүрээнд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, газар тариалангийн байгууллага барилга барьж болох боловч хүрээлэн буй орчин, байгалийн эмчилгээний нөөцийг бохирдуулах, хомсдол үүсгэх нөлөөтэй аливаа үйл ажиллагаанд хязгаар тогтооно.

Тайлбар: 1. Дархан цаазат газрын болон бусад онцгой хамгаалалттай нутаг дэвсгэрийн хамгаалалтын бүсэд ашиглалтын явцад ямар нэг хор нөлөөгүй бол барилга, байгууламж барихыг зөвшөөрнө. Ийм объектуудад аж ахуйн ашиглалтын горим ба хамгаалалтын бүс тогтоож байршуулна. 2. Усны хамгаалалтын бүсийн ашиглалт Усны тухай хууль, дүрмээр зохицуулагдана. 3. Ундны усны ундрагын эрүүл ахуйн хамгаалалтын хоёр ба гуравдугаар бүсэд объект байршуулахад Усны тухай, Эрүүл ахуйн тухай хууль, норм дүрмийн шаардлагыг мөрдөнө.

9.14 Тээврийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний барилга, байгууламж барихыг хориглоно. Үүнд: Экологийн шаардлагын дагуу:

- Дархан цаазат газар, нөөц газар, байгалийн үндэсний цэцэрлэгт хүрээлэн, ботаникийн цэцэрлэг, мод судлалын хүрээлэн ба усны хамгаалалтын бүсийн нутаг дэвсгэрт, төлөвлөж буй барилга, байгууламж нь тухайн нутаг дэвсгэрийн ашиглалтын зориулалтад нийцэхгүй бол;

- Хот, суурины хотын ой мод бүхий нутаг дэвсгэрт төлөвлөж буй барилга, байгууламж нь амралт, спорт эсвэл хотын ойр орчмын ойн аж ахуйн үйлчилгээний зориулалтын бус бол;

- Ус хангамжийн эх ундрага, ус дамжуулах байгууламжийн талбайн эрүүл ахуйн нэгдүгээр бүсэд тухайн эх ундрагатай холбоогүй объект барихаар төлөвлөж байгаа бол;

- Хөрсний бохирдол нь Эрүүл ахуйн тухай хуулийн шаардлагыг²⁶ зөрчсөн бол;

- Экологийн болзошгүй үр дагавар болон аюулгүйн шаардлагын дагуу;

- Ус цаг уурын станцын хамгаалалтын бүсэд;

- Уулын олборлолт ба уулын олборлолт боловсруулалтын байгууллагын уулын чулуулаг бутлах бүсэд, хөрсний гулсалт болж болзошгүй бүсэд, сайрын үер болон цасны нуралт болж болзошгүй бүсэд;

- Зохих инженерийн бэлтгэл ажил хийгдээгүй усанд автаж болзошгүй (1,5 м-ийн ба түүнээс дээш гүнтэй усанд автах) бүсэд;

- Бүтээгдэхүүн дамжуулах гол хоолойн бүсэд;

9.15 Ойн сан бүхий нутаг дэвсгэрийг хотын ногоон байгууламжийн нэгдсэн системтэй уялдуулан төлөвлөх ба ойн сан бүхий нутаг дэвсгэрт ногоон бүс байгуулахаар тооцно.

Хотуудын ногоон бүсийн нутаг дэвсгэрийг ойн парк ба ойн аж ахуйн хэсэг болгон авч үзнэ. Хотын ногоон бүсийн ойн паркийг оршин суугчдын амралт, спорт аялалын чиглэлээр ашиглаж хамгаална. Ногоон бүсэд экологийн орчин, эрүүл ахуй, нөхөн сэргээх ажилд сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Ой мод багатай бүс нутагт хүн амын суурьшлын орчинд салхи болон элсний нүүдлээс хамгаалсан ойн зурвас; уулын налуу, гуу жалтын захаар хөрс, ургамалан бүрхэвчийг хамгаалсан ойн зурвас байгуулна. Ойн зурвасын өргөн нийслэл хотод 500.0м; хотод 100.0м; сууринд 50.0м байна.

9.16 Хотын ногоон бүсийн ой болон уулын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн газар болон амралтын газрын ой мод зэрэг нэгдүгээр бүлэгт хамаарах ой мод түүний орчинг нөхөн сэргээх, эрүүл ахуйн болон эмчлэн эрүүлжүүлэх зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө.

9.17 Хотын болон ногоон бүсийн нутаг дэвсгэрт гидрографын сүлжээний өгөгдөлд тулгуурлан байгалийн “каркас” байгуулж болох ба үүнд байгалийн онцгой хамгаалалттай газар нутаг; хотын ой ба модот хүрээлэн болон нөхөн сэргээх зориулалттай бусад бүсүүд; байгалийн экосистем; хөдөө аж ахуйн эдэлбэр газар; ашиглалтын онцгой нөхцөлтэй газар (байгалийн болон соёлын өвийн объектын хамгаалалтын бүс; усны хамгаалалтын бүс; усан хангамжийн эх ундрагын хамгаалалтын бүс), ойн бүсийн үнэт мод (хөрсний гулгалтаас хамгаалах, эргийн хамгаалалтын, хөрс хамгаалалын, ховор төрлийн амьтан амьдардаг газар г.м.) багтана. Хот байгуулалтын болон хөдөө аж ахуйн үйл ажиллагааны хүрээ, ажлын горимыг Монгол улсын Усны тухай, Газрын тухай болон Ойн тухай хуулиудаар зохицуулна.

Агаар мандал, гадаргын болон хөрсний ус, хөрсийг бохирдлоос хамгаалах

9.18 Хот, суурин газрын төлөвлөлт, барилгажилтад агаар мандалын чанарын шаардлагыг эрүүл ахуйн нормд нийцүүлнэ. Ингэхдээ суурьшлын болон холимог ашиглалтын зориулалтын бүсэд эрүүл ахуйн нормоор тогтоосон бохирдолын зөвшөөрөгдөх хэмжээг хангах ба агаар мандалын чанарт онцгой шаардлага тавигдах бүсэд (эрүүл мэндийн

²⁶ 4.4.Хүн амын суурьшлын хөрс нь эрүүл ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:

байгууллага, хүүхдийн цэцэрлэг, сургууль, нөхөн сэргээх объектууд) бохирдолын зөвшөөрөгдөх хэмжээ 0,8 байна.

Суурьшлын бүсэд хортой бодисын зөвшөөрөгдөх хэмжээ зөрчигдсэн тохиолдолд эрүүл ахуйн бүс нь энэхүү норм, дүрмийн 7.14 -д заасан нөхцөлийг тооцон агаарын бохирдлын хэмжээг бууруулах технологийн болон төлөвлөлтийн арга хэмжээ авна.

Суурьшлын болон нөхөн сэргээх бүсийг салхины зонхилох чиглэлийн дээд талд буюу агаарын бохирдлын эх үүсвэр болох үйлдвэрийн бүсийн дээд талд түүнчлэн галын аюулын өндөр магадлалтай объектын дээд талд тус тус байрлуулна.

Мал аж ахуй, шувуу, гахайн аж ахуй, химийн бодис, био бэлдмэл, бордоо, галын болон тэсэрч дэлбэрэх аюултай бодисын үйлдвэрлэл, агуулах, мал эмнэлэг, хог хаягдал боловсруулах үйлдвэр, байгууламж, халаалтын зуух, цэвэрлэх байгууламж, өтөг бууц хадгалах газар зэргийг суурьшлын болон нөхөн сэргээх бүс болон үйлдвэрийн бусад объектын салхины зонхилох чиглэлийн доод талд байрлуулж төлөвлөнө.

Тайлбар: 1. Хортой бодисоор агаар бохирдуулах эх үүсвэр бүхий аж үйлдвэрийн газруудыг 500.0 м-ийн өргөнтэй эрүүл ахуйн бүс тогтоосны дараа салхины хурд 1 м/с мөн цаг агаар тогтворгүй, үргэлжилсэн эсвэл давтамжтай далайн шуурга, манан (жилд өдрийн 30-40%, өвлийн туршид өдрийн 50-60%) нутаг оронд байгуулах нь тохиромжгүй. 2. Агаарын бохирдол, тээврийн хэрэгсэлийн ялгаруулах хортой бодисын хэмжээ “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. /MNS 5885:2008/” –ын шаардлагыг хангасан байна.

9.19 Усан сан бүхий газрын төлөвлөлтөнд Усны тухай хуулийн усны нөөцийг хамгаалах зүйл заалтуудын дагуу усны нөөцийг бохирдлоос хамгаалах, байнгын ундаргатай, рашаан булаг түшиглэн хөв цөөрөм төлөвлөх хамгаалалтад авч бохирдлоос сэргийлэх нөхцөл, шаардлагыг мөрдөнө. Оршин суугчдын амралт, загасны аж ахуйн, түүнчлэн тухайн бүсэд оршиж байгаа суурин газрын ахуйн болон ундны ус хангамж дахь хортой бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг хангана.

Хот, суурины суурьшлын болон холимог ашиглалтын бүс, нөхөн сэргээх бүсийг хот, суурины усан сан болон бүх төрлийн гадаргын ус, усны урсгалын дээд талд байгуулна.

Дурдсан бүсүүдийг тогтоосон журмын дагуу гадаргуугийн ус хамгаалах дүрэм, түүнчлэн далайн эргийн ус хамгаалах эрүүл ахуйн дүрмийн заалтуудыг хангасан тохиолдолд урсгалын доод талд байрлуулахыг зөвшөөрнө.

9.20 Гадаргын усыг бохирдлоос сэргийлэх, усан сан бүхий газарт байрлах амралт сувилал тухайн нутаг дэвсгэрт байгаа хот, суурин газрын ундны усны зориулалтаар ашиглах ус хангамжийн эх үүсвэрийн болон хөрсний усыг бохирдуулах эх үүсвэрүүдийн нормативыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Гэр сууцны хороололд био жорлон, биологийн цэвэрлэгээний жижиг төхөөрөмж ашиглах;
- Хүнд металлын бохирдлыг бууруулах;
- Хатуу хог хаягдлыг ангилан дахин боловсруулах

9.21 Усан боомтын байгууламж, усан зогсоол, ачаа ачих, буулгах зогсоол, бусад төхөөрөмж, шаардлагатай үйлдвэрүүдийг суурьшлын бүсээс голын урсацын доод хэсэгт 200 метрээс багагүй зайд байгуулна.

9.22 Хот, суурин газрыг төлөвлөх, барилгажуулахад усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд “Усны тухай” хуулийг мөрдлөг болгоно. Усан сан бүхий газрын урсацыг ундны - ахуйн болон соёл – ахуйн хэрэглээний эх ундрагын зориулалтаар ашиглаж байгаа, ашиглахаар төлөвлөж байгаа бол усан сан бүхий газрыг ашиглах, барилгажуулах эрүүл ахуйн шаардлагыг мөрдөнө.

9.23 Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйлдвэр байгуулах тохиолдолд ус хамгаалах, усны хэрэглээг зохицуулах байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулна. Үйлдвэрийн эдэлбэр газрын хэмжээ, хүчин чадлыг шаардлагын хэмжээнд хязгаар тогтоож хянана.

9.24 Эрдэс бордоо, ургамал хамгааллын химийн бодисын агуулахыг загас үржүүлгийн усан сангаас 2.0км-ээс багагүй зайд байрлуулна. Эрдэс бордооны агуулах, ургамал хамгааллын химийн бодис, мал шувуу үржүүлгийн газар зэргийг байгуулахад химийн бодис, өтөг бууц, шувууны сангасыг усанд орохоос хамгаалах төлөвлөлтөнд “Ургамал хамгааллын химийн бодис болон хуурай эрдэс бордооны агуулах БНБД 31-14-07”-г мөрлөг болгоно.

9.25 Суурин газрын нутаг дэвсгэрт байгуулсан усанд сэлэх зориулалттай задгай усан сан, битүү усан санд тольны хэмжээнээс шалгаалан дулааны улиралд усыг сэлгэхээр төлөвлөнө. Усанд сэлэх, задгай усан сангийн толь 3.0 га хүртэл бол өдөрт 2 удаа; 3.0 га-гаас их бол 1 удаа; усан сэлэлтийн битүү усан санд 3-4 удаа; талбайн хэмжээ нэг га-гаас том бол хоёр удаа сэлгэхээр тооцож төлөвлөнө. .

Суурин газарт битүү усан сангийн гүн дулааны улиралд 1,5 м байна. Эрэг хавийн усанд тогтмол хугацаанд усны ургамлыг зайлуулах нөхцөлтэйгээр гүн нь 1.0 м хүртэл байна.

Дуу чимээ, цахилгаан соронзон долгион

9.26 Орон сууц, олон нийтийн барилга түүний орчны газарт зөвшөөрөгдөх дуу чимээ, гадна дуу чимээний эх үүсвэр, дуу чимээг тодорхойлох, зөвшөөрөгдөх хэмжээг хангах төлөвлөлтөнд “Дуу чимээ тусгаарлалт БНБД 23-05-10”-ыг мөрдөнө.

Хүснэгт 9.1 Үйлдвэр болон амралт, чөлөөт цагийн байгууламжийн дуу чимээний хязгаар

дд	Дуу чимээнээс хамгаалах нутаг дэвсгэр	Хэмжих нэгж ДБ	
		Өдөр 06-22 цаг	Шөнө 22-06 цаг
1	Амралт сувилал, эрүүл мэндийн байгууллага	45	35
2	Орон сууцны хорооллын эдэлбэр газар /суурин газар/ боловсролын байгууллага, амралт зугаалгын бүс	50	40
3	Орон сууцны хорооллын эдэлбэр газар /хот/ холимог бүс	55	45
4	Үйлдвэр –эдийн засгийн бүсийн нутаг дэвсгэр	60	50

Хүснэгт 9.2 Авто замын хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээний хязгаар

дд	Дуу чимээнээс хамгаалах нутаг дэвсгэр	Үйлчилгээ, орон сууцны гудамж		III зэрэглэлийн хөдөлгөөний зохицуулалттай гол гудамж, орон сууцны хорооллын гудамж, жижиг онгоцны буудлаас үүсэх дуу чимээ /ДБ/		Хотын гол зам; гол гудамж; төмөр замын вокзал, төмөр зам, нисэх онгоцны буудлаас үүсэх дуу чимээ /ДБ/	
		Өдөр 06-22 цаг	Шөнө 22-06 цаг	Өдөр 06-22 цаг	Шөнө 22-06 цаг	Өдөр 06-22 цаг	Шөнө 22-06 цаг
1	Амралт сувилал, эрүүл мэндийн байгууллага	50	40	55	45	60	50
2	Суурьшлын бүс, /хот маягийн суурин/	55	45	60	50	65	55

Хот, суурины төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /30-01-24/						2024 он	
	боловсролын байгууллага, нөхөн сэргээх бүс						
3	Суурьшлын бүс, /нийслэл хот, хот/	60	50	65	55	65	55
4	Үйлдвэр, эдийн засгийн бүсийн нутаг дэвсгэр	65	55	65	55	65	55

9.27 Орон сууц, олон нийтийн барилга дотор байвал зохих чичиргээний түвшин, ариун цэвэр, эрүүл ахуйн нормоор заасан чичиргээний үзүүлэлтэд нийцсэн байна. Эдгээр шаардлагуудыг хэрэгжүүлэхэд орон сууц, олон нийтийн барилга болон чичиргээний эх үүсвэр хооронд шаардлагатай зай авч чичиргээ, доргио бууруулах, тусгаарлах материал, бүтээц, тоноглол ашиглана.

9.28 Ураны задралын үед үүсдэг Радоны (Rn-222) тоосонцор шатаасан үнс, фосфорын гипс, шатаасан тоосго зэрэг барилгын өргөн хэрэглээний материалын хамт бүтээн байгуулсан орчинд орж ирснийг ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүйн шаардлагын дагуу радоны дээд хязгаарыг $400\text{Bq}/\text{m}^3$ жилийн түвшнээс доош хязгаарлана.

9.29 Радиотехникийн объект цахилгаан соронзон эрчим хүч ялгаруулагч, цаг уурын, радиолокатор, телевизийн төв ба дамжуулах төхөөрөмж, радио станц, антен суурилуулсан цамхаг, тулгуур шон, ЛЕП, үйлдвэрийн генератор болон бусад төрлийн байгууламж байрлуулахад аюулгүйн зай хэмжээ, эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг тооцоход Монгол улсын Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, “Харилцаа холбооны цамхаг байгуулахад тавих ерөнхий шаардлага” MNS 5884:2016 болон холбогдох бусад хууль норм, дүрмийг мөрдөнө.

9.30 Цацраг идэвхит бодис, ионжуулах туяаны эх үүсвэрүүдийн үйлдвэрлэлийн явц дахь боловсруулалт, дахин боловсруулалт, ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн төлөвлөлтөнд Цацрагийн аюулгүйн норм²⁷, дүрмийг мөрдөнө. Атомын цахилгаан станц байрлуулах болон иргэдийг гадна цацруулалтаас хамгаалах ажлыг тогтоосон журмын дагуу гүйцэтгэнэ. Атомын цахилгаан станцаас төвлөрсөн дулаан хангамж авах төсөл боловсруулах, байрлуулах болон ашиглалтанд атомын цахилгаан станц болон төвлөрсөн дулаан хангамжийн системд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг мөрдөнө.

Бичил уур амьсгалыг сайжруулах

9.31 Хот, суурины төлөвлөлт, барилгажилтанд уур амьсгалын бүсчлэлийн өгөгдөлтэй нийцүүлэн суурин газрын мезо болон бичил уур амьсгалыг сайжруулах арга хэмжээ /салхи болон элсний нүүдлээс хамгаалах, нутаг дэвсгэрийн агаарын сэлгэлт, зүлэгжүүлэх, усжуулах замаар орчны чийглэгийн горимыг тогтвортой болгох, нарны гэрлийг зохистой ашиглах зэрэг/-г тооцно.

9.32 Төлөвлөлтийн онцлог, барилгын норматив шаардлага ба өгөгдлийг тухайн орон нутгийн байгаль цаг уурын онцлог байгалийн онц аюултай нөхцөл зэргийг Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23-01-09-ийг үндэслэн энэхүү нормын хавсралт Н-ын дагуу тооцож төлөвлөнө.

9.33 Орон сууц, олон нийтийн барилгын байршлыг тодорхойлоход нутаг дэвсгэрийн онцлог нарын тусалын үргэлжлэх хугацааг тооцох, олон нийтийн барилга, орон сууцны нарны гэрлийн тасралтгүй хангах норм дүрмийг баримтлана.

²⁷ Цөмийн энергийн комиссын 2015 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

9.34 Орон сууц, олон нийтийн барилгын нарын гэрлийн тасралтгүй тусгалын үргэлжлэх хугацааг газар зүйн өргөрөг, өрөө тасалгааны зориулалт, орон сууцны төрөл зэргийг харгалзан Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж БНБД 23-07-04-ийн дагуу тооцож төлөвлөнө.

- Хойд бүсийн хувьд (хойд өргөргийн 58° -аас хойш)- дөвөрдүгээр сарын 22-ноос наймдугаар сарын 22-н хүртэл 2.5 цаг хүртэл;
- Төвийн бүсэд (хойр өргөргийн 48° урагш)- гуравдугаар сарын 22-ноос есдүгээр сарын 22-н хүртэл 2 цаг хүртэл;
- Өмнөд бүсийн хувьд (хойд өргөргийн 48° урагш)- хоёрдугаар сарын 22-ноос аравдугаар сарын 22-н хүртэл өдөрт 1.5 цаг хүртэл;

Тайлбар: 1. Барилгажилтын зарим тохиолдолд бүс тус бүрт өдрийн турш 0.5 цагаар нарын гэрэл тусах үргэлжлэх хугацааг нэмэх нөхцөлтэйгээр сууцны нарны гэрэл тусгалтыг нэг удаа тасалдахаар зохицуулж болно. 2. Суурин газрын орон сууцны барилгажилт, голдоч маягийн олон сууцтай орон сууцанд нарны гэрлийн тусгал бүх сууцанд тусч байгаа бол түүнчлэн хот төлөвлөлтийн онцгой хүнд нөхцөл (түүхэн үнэ цэнэтэй орчин, өртөг өндөртэй инженерийн бэлтгэл ажил)-д барилгажилтын ажил гүйцэтгэхэд бүс тус бүрт нарны гэрлийн тусгалын үргэлжлэх хугацааг 0.5 цагаар багасгаж болно. 3. Хойд өргөргийн 62.5° -аас хойш оршин суугчдын тав тухтай байдлыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах нөхцөл (сууцны талбай нэмэх, хиймэл хэт ягаан туяа, эмчилгээ-урьдчилан сэргийлэхүйн үйлчилгээ)-д орон сууц, нийтийн барилгын нарны гэрлийн тусгалын үргэлжлэх хугацааг бууруулж болно.

9.35 Хүүхдийн тоглоомын талбай, биеийн тамирын талбайн хагаст нарны тусгалын хэрэгцээ талбайн 50 %-д 3 цаг байна. Жилийн улирлын халуун үед хүүхдийн тоглоомын талбай, биеийн тамирын тоноглолтой талбайн хэсэг, оршин суугчдын амрах талбайд дулааны нөлөөллийг бууруулах тусгай сүүдэрлэх байгууламж, зүлэгжүүлэлт зэргээр нарны тусгалын нөлөөг хязгаарлана.

Түүх соёлын дурсгалын хамгаалалт

9.36 Хот, сууринг төлөвлөх, барилгажуулахад соёлын өвийн дурсгалууд, объектыг хамгаалах тэдгээрийн хот байгуулалтын чадавхийг ашиглах, хадгалах нөхцлийг хангах хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Соёлын өв²⁸ийн объектод: түүхэн тодорхой цаг үеийн илэрхийлэл архитектурын дурсгалууд ба түүний нутаг дэвсгэр, археологийн өвийн объектууд, архитектурын цогцолбор, түүнчлэн суурингийн түүхэн төлөвлөлт ба барилгажилтын фрагментууд, дурсгалт газрууд хамаарна.

9.37 Хот байгуулалтын баримт бичигт түүхэн газар нутгийн хил хязгаарыг түүх соёлын судалгаанд үндэслэн тодорхойлох бөгөөд хот, суурины төлөвлөлтийн баримт бичигт соёлын өвийн хамгаалалтын бүс (хамгаалалтын бүс, барилгажилтыг зохицуулах бүс, хамгаалалттай байгалийн ландшафт)-ийг холбогдох эрхзүйн хүрээнд тогтоох ёстой. Тэдгээрийн хил хязгаарыг түүх-соёлын судалгаанд үндэслэн тогтооно.

Хамгаалалтын бүс болон нутаг дэвсгэрийн ашиглалтын журам зэргийг улсын түүх-соёлын шинжээчид дүгнэлт гаргаснаар холбогдох хууль тогтоомжийн дагуу батална.

9.38 Соёлын өвийн объектийн батлагдсан нутаг дэвсгэр болон ашиглалтын бүс нь нутаг дэвсгэрийн төлөвлөлт, газар ашиглалтын болон барилгажилтын төлөвлөлтөнд тусгагдсан байна.

²⁸ Соёлын тухай хуулийн 3.1.1-д зааснаар түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;

Түүх соёлын дурсгалт барилга, байгууламжийн үнэ цэнийг хадгалах зорилгоор үзэгдэх орчинг харгалзан барилгажилтын өндрийг тодорхойлж төлөвлөнө.

9.39 Хот, суурин газрыг төлөвлөх ба барилгажуулахад соёлын өвийн объектыг нураах, шилжүүлэх гэх мэтээр тухайн объектын байгаа байдлыг өөрчлөхийг хориглоно. Онцгой тохиолдолд түүх дурсгалын байршил, байдлыг өөрчлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

9.40 Сэргээн засварлах төсөлд түүхийн болон байгалийн үнэт орчинг бүрэн бүтэн авч үлдэх, хадгалах талаар арга хэмжээ авсан байх ёстой ба ингэхдээ суурин газрын ландшафт түүнчлэн соёлын өвийн болон байгалийн ландшафтын нөхцөлийг гажуудуулах, өөрчлөхийг хориглоно.

Тайлбар: Дархан цаазат газар (дархан цаазат бүс) бүрийн талаар хамгаалалтын тусгай горим, ашиглалтын дүрэм, шаардлага нь тогтоосон журмын дагуу улсын түүх-архитектурын дархан цаазат газар эсвэл түүх-соёлын дархан цаазат нутаг дэвсгэр (газар) хэмээн зарлагдсан түүх, соёлын дурсгалууд тэдгээрийн цогцолбор, түүхэн төв, сууц, талбай, гудамж, дурсгалт газар, эртний хотуудын соёлын давхарга зэрэг түүх, археологи ба архитектурын үнэ цэнэтэй байгалийн болон хиймэл ландшафт, цэцэрлэг-хүрээлэнгийн урлагийн дурсгал зэргүүдэд адил хүчинтэй үйлчилнэ.

9.41 Өмнө баригдсан хот, сууринг дахин төлөвлөх болон хот төлөвлөлтийн төвөгшилтэй нөхцлийн үндэслэлийн дагуу энэхүү нормативын шаардлагуудыг хот төлөвлөлт, эрүүл ахуй-халдвар судлал, байгаль хамгаалал, галын аюулаас хамгаалах эрх бүхий байгууллага байгууллагуудтай тохиролцсоны үндсэн дээр тодруулга хийж болно.

9.42 Нэмэлт давхар болон мансардтай орон сууц ба нийтийн орон сууцыг сэргээн сайжруулахад нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа болон гэрэлтүүлэгийг холбогдох норм, дүрмийн дагуу тооцож төлөвлөнө. Түүхэн газар нутаг дах барилгажилтыг сэргээн сайжруулахад барилгажилт болон соёлын дурсгалын түүхэн хэв маягийг хэвээр хадгалагдахаар төлөвлөнө.

Түүх, соёлын дурсгалаас тээврийн хэрэгсэл, инженерийн байгууламж хүртэлх зай, метрээр:

- | | |
|--|------|
| - Хурдны болон тасралтгүй хөдөлгөөнтэй явах хэсэг, гүехэн суулгасан газар доорхи төмөр зам /метрополитен/-ний шугам хүртэл | |
| - Төвөгшил ихтэй газрын гадаргуутай бол | 100м |
| - Тэгшивтэр гадаргуутай бол | 50м |
| - Ус хангамж, ариутгах татуурга ба дулаан хангамжийн шугам сүлжээ (түгээгүүрээс бусад) | 15м |
| - Бусад газар доорх инженерийн сүлжээ хүртэл | 5м |

Сэргээн засварлах нөхцөлд инженерийн шугам сүлжээ хүртэлх тогтоосон зайг багасгаж болох ч метрийн хэмжээсээр ус хангамжийн сүлжээ хүртэл – 5.0м; ус хангамжийн бус -2.0м зайтай байна. Ингэхдээ барилгын ажилтай холбогдуулан тусгай техникийн ажил гүйцэтгэх нөхцөлийг хангасан байна.

10. Тээвэр ба гудамж, замын сүлжээ

10.1 Суурин газрыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулахад газар нутгийн болон тээврийн сүлжээний блансын харьцааг хангах хэрэгтэй. Хот, суурин газрын гудамж, замын сүлжээ тээврийн системийг нутагшилтын систем дэх бусад суурин газрууд болон түүний хаяа нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн бүтэцтэй нягт уялдуулан хот орчмын болон хот, суурины нутаг дэвсгэрийн ашиглалтын зориулалтын бүсүүд, хотоос гаднах тээврийн байгууламжууд, улсын чанартай зам руу тав тухтай, хурдан бөгөөд аюулгүй зорчих тээврээр холбогдох

нөхцлийг бүрдүүлнэ. Гудамж замын сүлжээний бүтэц нь хөдөлгөөний чиглэлүүдийг орлох боломжоор хангагдсан байх шаардлагатай.

10.2 Хотод ажиллагсдын 90% нь амьдарч байгаа газраас ажил эрхэлж байгаа газар хүртэл /нэг чиглэлдээ/ шилжилт хөдөлгөөн хийх хугацаа нь: 2 сая хүртэлх хүн амтай хотод 45 минут; 1 сая хүртэлх хүн амтай хотод 40 минут; 500 мянган хүн амтай хотод 37 минут; 250 мянган хүн амтай хотод 35 минут; 100 мянга ба түүнээс доош хүн амтай хотод 30 минутаас ихгүй байна. Бусад хаяа суурингуудаас өдөр бүр хотын төвд ирж ажиллагсдын шилжилт хөдөлгөөн хийх хугацааг нэмэгдүүлж болохч хоёр дахинаас нэмэгдүүлж тооцохгүй.

Хөдөөгийн суурины оршин суугчдын хувьд хөдөлмөрлөх зорилгоор болон хөдөө аж ахуйн байгууламж руу шилжилт хөдөлгөөн хийх хугацаа нь /явганаар болон тээврийн хэрэгслээр/ 30 минутаас ихгүй байна.

Тайлбар: 1. Хоёр саяаас дээш хүн амтай хотод шилжилт хөдөлгөөн хийх хамгийн их хугацааг барилгажилтын бодит хязгаар, ажлын байрны байршил, нийтийн тээврийн хөгжлийн түвшинд үндэслэн тогтооно. 2. Хотуудын хүн амын тоог нормд заагдсан хэмжээнүүдийн хооронд тооцохдоо интерполяцлах аргыг хэрэглэнэ.

10.3 3 Гудамж, замын сүлжээ, замын уулзваруудын хөдөлгөөн нэвтрүүлэх чадвар, автомашин хадгалахад шаардагдах талбайн хэмжээг гаргахдаа хотын 1000 хүн ам тутамд хичнээн автомашин ноогдох харьцаа болох автомашинжилтын түвшинг үндэслэн тодорхойлно.

Автомашинжилтын түвшинг хот байгуулалтын төлөвлөлтийн бүсчилсэн нормативаар тодорхойлно. Бусад хаяа суурингуудаас хотод ирж байгаа болон хотыг нэвт дайран өнгөрч байгаа транзит автомашины тоог тооцоогоор тодорхойлно.

Гудамж, замын сүлжээ

10.4 Гудамж, замын сүлжээг тээврийн хэрэгсэл, гудамж, замын зориулалт, явган болон дугуйгаар зорчигчдын хөдөлгөөний эрчим, хотын газар нутгийн архитектур төлөвлөлтийн зохион байгуулалт, барилгажилтийн онцлогт тохируулан тасралтгүй үргэлжлэх систем байдлаар төлөвлөнө. Хот, суурины төлөвлөлтөөр гудамж, замын сүлжээний бүрэлдэхүүн дэх тасралтгүй хөдөлгөөнтэй зам, нутаг дэвсгэрийн зам болон хотын гол гудамжуудыг тодорхойлно.

Хот, суурины гудамж, замын ангилалыг хүснэгт 10.1-т заасны дагуу төлөвлөнө.

Хүснэгт 10.1

Гудамж, замын ангилал	Гудамж, замын үндсэн зориулалт
Хотын гол зам:	
I зэргийн Хурдны хөдөлгөөний зам	Нийслэл хот, хотуудын алслагдсан дүүрэг, хотхон, үйлдвэрийн бүс, нисэх онгоцны буудал, томоохон нийтийн амралт зугаалгын газар, дагуул хотын авто тээврийн хөдөлгөөн болон хотын гаднах автозам руу гарах хөдөлгөөнд зориулсан хурдны зам байна. Хурдны зам нь тээврийн хэрэгслийн тасралтгүй хөдөлгөөний нөхцөлийг хангасан, дамжин өнгөрөх хөдөлгөөнд үйлчлэх зам байна. Бусад авто замаас хурдны замын хөдөлгөөнд олон түвшний уулзвараар нийлэх боломжийг хангана. Бүх төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлнэ. Бүх ангиллын гудамж, замтай олон түвшний уулзвар, зангилгаагаар огтлолцоно. Явган зорчигчдийн хөдөлгөөнийг хурдны замын зорчих хэсгээс өөр түвшинд төлөвлөнө.
II зэргийн, хөдөлгөөний	Хот, суурины гудамж замын сүлжээг хотын гадна замтай холбох, хотын томоохон бүс дүүргүүдийн хоорондох авто тээврийн хөдөлгөөнд зориулагдана. Энэ ангиллын замыг орон сууц, гэр хорооллын бүсийн гадна төлөвлөнө. Тээврийн хөдөлгөөнийг зохицуулалттай нэвтрүүлнэ, бусад ангиллын замаас

зохицуулалттай зам	гарц, уулзвараар нэвтрэх бөгөөд гарц, уулзварыг 300-400м-ээс багагүй зайд төлөвлөж хөдөлгөөний жигд хурдыг хангана. Бүх төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлнэ. Бүх ангиллын гудамж замтай нэг болон олон түвшний уулзвараар огтлолцоно. Явган зорчигчдийн хөдөлгөөнийг авто замын зорчих хэсэгтэй нэг болон өөр түвшинд төлөвлөнө.
Хотын гол гудамж:	
I зэргийн, тасралтгүй хөдөлгөөнтэй зам	Хот доторх тээврийн үндсэн хөдөлгөөнийг нэвтрүүлдэг, суурьшлын болон үйлдвэрийн бүсүүдийг хооронд нь болон бусад гол гудамж замтай холбосон зам. Үндсэн чиглэлдээ тээврийн хөдөлгөөний тасралтгүй зогсолтгүй хөдөлгөөнийг хангах зам байна. Хотын барилгажсан нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг хурднаар холбох гол үүрэг гүйцэтгэнэ. Авто замууд руу гарах хөдөлгөөнийг хангана. Замын зэргэлдээ барилгажилт руу хажуугийн болон орон нутгийн замаар дамжин холбогдоно. Бүх төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлнэ. Явган зорчигчдийн хөдөлгөөнийг замын зорчих хэсгээс өөр түвшинд төлөвлөнө.
II зэргийн, хөдөлгөөний зохицуулалттай зам	Суурьшлын болон үйлдвэрийн бүсийг хотын төв, дүүргийн төвүүдтэй болон тэдгээрийг хотын гадна замтай холбоно. Хот суурины төлөвлөлтийн бүтэц болох хот төлөвлөлт-тээврийн үндсэн тэнхлэгийн үүрэг гүйцэтгэдэг зохицуулгатай хөдөлгөөнтэй зам байна. Бүх төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрэнэ. Нийтийн тээврийн хөдөлгөөнийг тусгаарласан зурвас, тусгай эгнээгээр нэвтрүүлнэ. Бүх ангиллын гудамж замтай нэг болон олон түвшний уулзвараар огтлолцоно. Явган зорчигчдийн хөдөлгөөнийг замын зорчих хэсгээс өөр түвшинд, гэрлэн зохицуулгатай бол нэг түвшинд төлөвлөнө.
III зэргийн, хөдөлгөөний зохицуулалттай зам	Хотын дүүргүүд, хот орчмын бүсийг холбох үүрэгтэй, зохицуулгатай болон өөрийн зохицуулалттай хөдөлгөөнтэй зам. Бүх төрлийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлнэ. Шаардлагатай тохиолдолд газар дээрх нийтийн тээврийн хөдөлгөөнд тусгайлсан зурвас зохион байгуулж болно. Явган зорчигчдийн хөдөлгөөнийг авто замын зорчих хэсэгтэй нэг болон өөр түвшинд төлөвлөнө.
Туслах гудамж, зам:	
Дүүргийн /Районы/ гол гудамж	Суурьшлын бүс дотор тээврийн хэрэгслээр болон явганаар холбох зориулалттай. Бусад гудамж зам руу гарах гарц. Хотын чанартай болон хороолол хоорондын гудамж зам руу гарах хөдөлгөөнийг хангана. Хөдөлгөөн нь зохицуулгатай болон өөрийн зохицуулалттай байна. Бүх төрлийн тээврийн хэрэгсэл зорчино. Бусад гудамж замуудтай нэг түвшинд огтлолцоно. Явган зорчигчдийн хөдөлгөөнийг авто замын зорчих хэсэгтэй нэг болон өөр түвшинд төлөвлөнө.
Нутаг дэвсгэрийн гудамж, зам:	
Орон сууцны хороолол, гэр сууцны хорооллын гудамж	Орон сууцны хороолол, гэр хорооллын доторхи тээврийн болон явган зорчигчдын хөдөлгөөн явахад зориулагдсан. Зохицуулалттай хөдөлгөөнтэй гудамж зам, хорооллын чанартай гол гудамж зам руу холбогдоно. Барилга, орон сууцны эдэлбэр газарт шууд хүрэх хөдөлгөөнийг хангана.
Олон нийтийн болон худалдааны гудамж	Худалдааны, албан болон засаг захиргааны барилгууд, хүн амын ахуйн үйлчилгээний объектууд, боловсролын байгууллагууд руу хүрэх суурьшлын бүс доторхи хөдөлгөөнийг хангана. Явган зорчигчдын хөдөлгөөнийг авто замын зорчих хэсэгтэй нэг түвшинд төлөвлөнө.
Үйлдвэрийн гудамж, зам	Үйлдвэрийн болон аж ахуй, агуулахын бүсийн дотор, барилга байгууламж эдэлбэр газар, барилга байгууламжид тээврийн хэрэгслээр болон явганаар хүрэх хөдөлгөөнийг хангана. Явган зорчигчдын хөдөлгөөнийг авто замын зорчих хэсэгтэй нэг түвшинд төлөвлөнө.

Явганаар зорчих гудамж, зам талбай	<p>Гудамж замын сүлжээнд явган зорчигчдын аюулгүй, тав тухтай зорчих, зугаалах нөхцөлийг бүрэн хангасан, тохижуулж тоногловсон гудамж, талбай байна.</p> <p>Энэхүү гудамж, талбайг хүн ам олноор цуглардаг газар, явган зорчигчдын хөдөлгөөний нягтрал өндөр газруудад зөвхөн явган зорчигчдын хөдөлгөөнд зориулан төлөвлөн.</p> <p>Бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хориотой, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл зорчих боломжийг хангасан байна.</p>
<p><i>Тайлбар: 1. Гудамж, замын сүлжээн дэх хотын гол гудамжууд нь хотын төвийн архитектур-төлөвлөлтийн бүтцийн үндэс нь болно.</i></p> <p><i>2. Хотын газар нутгийн хэмжээ, төлөвлөлтийн бүтэц, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тоо хэмжээнээс хамааруулан гудамж, замын ангилалыг авч хэрэглэнэ.</i></p> <p><i>3. Авто замд өргөтгөл, шинэчлэл хийх үед болон дүүргийн гол гудамжийг зөвхөн нийтийн тээврийн хэрэгсэл, явган зорчигчдыг нэвтрүүлэхэд зориулж орчны газрыг тоноглохыг зөвшөөрнө.</i></p> <p><i>4. Түүхэн хотуудад хотын төв хэсэгт нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг төлөвлөхгүй буюу хөдөлгөөний тоо хэмжээг багасгаж төлөвлөх ба</i> <i>-тойрон гарсан гол гудамж байгуулах,</i> <i>-тээврийн хөдөлгөөн хязгаарлагдсан гудамж, явган зорчигчдын бүс бий болгох,</i> <i>- төвийг тойруулан авто машины зогсоолууд байгуулах зэргээр төлөвлөлтийг хийнэ.</i></p> <p><i>5. Дугуйн замыг тээврийн хэрэгслийн бие даасан хэлбэр гэж үзэн тусгайлан болон гудамж замын сүлжээгээр явахаар төлөвлөх хэрэгтэй.</i></p>	

10.5 Хотуудын гудамж замын тооцоот хэмжигдэхүүнүүдийг хүснэгт 10.3-ын дагуу төлөвлөнө.

Хүснэгт 10.3 Гудамж, замын тооцоот хэмжигдэхүүн

Гудамж замын зэрэглэл	Хөдөлгөөний тооцоот хурд, км/цаг	Зорчих хэсгийн өргөн, м	Зорчих хэсгийн тоо (хоёр чиглэлийн нийлбэр)	Хавтгай дээрх хамгийн бага радиус эргэцтэй/эргэцгүй, м	Хамгийн их дагуу налуу, ‰	Босоо гүдэр муруйн хамгийн бага радиус, м	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус, м	Явган замын хамгийн бага өргөн, м
Хотын гол гудамж зам								
Хотын гол зам:								
I зэрэглэл	130	3.5-3.75	4-10	1200/1900	40	21500	2600	-
	110			760/1100	45	12500	1900	
	90			430/580	55	6700	1300	
II зэрэглэл	90	3.5-3.75	4-8	430/580	55	5700	1300	-
	80	3.25-3.75		310/420	60	3900	1000	
	70			230/310	65	2600	800	
Хотын гол гудамж:								
I зэрэглэл	90	3.5-3.75	4-10	430/580	55	5700	1300	4.5
	80	3.25-3.75		310/420	60	3900	1000	
	70			230/310	65	2600	800	
II зэрэглэл	80	3.25-3.75	4-10	310/420	60	3900	1000	3.0
	70			230/310	65	2600	800	
	60			170/220	70	1700	600	
III зэрэглэл	70	3.25-3.75	4-6	230/310	65	2600	800	3.0
	60			170/220	70	1700	600	
	50			110/140	70	1000	400	
Хорооллын чанартай гол гудамж	70	3.25-3.75	2-4	230/310	60	2600	800	2.25
	60			170/220	70	1700	600	
	50			110/140	70	1000	400	
Нутаг дэвсгэрийн гудамж, зам Орон нутгийн								
Орон сууцны хороолол, гэр сууцны хорооллын гудамж	50	3.0-3.5	2-4	110/140	80	1000	400	2.0
	40			70/80	80	600	250	
	30			40/40	80	600	200	
Олон нийтийн болон худалдааны гудамж	50	3.0-3.5	2-4	110/140	80	1000	400	2.0
	40			70/80	80	600	250	
	30			40/40	80	600	200	
Үйлдвэрийн бүс дэх гудамж, зам	50	3.5	2-4	110/140	60	1000	400	2.0
Явганаар зорчих гудамж, зам талбай:								
Явганаар зорчих гудамж, зам талбай	-	Тооцоогоор	Тооцоогоор	-	50	-	-	Зураг төслийн дагуу
Нэг зурвасыг суудлын авто машины зогсоол байхаар тооцсон.								

Тайлбар:

1. Гудамж замын өргөнийг тээврийн хэрэгслийн болон явган зорчигчдын хөдөлгөөний эрчмээс хамааруулан тооцоогоор тодорхойлох ба хөндлөн огтлол дотор байх элементүүдийн бүрэлдэхүүн (зорчих хэсэг, газар доорх шугам сүлжээ байрлуулах техникийн зурвас, явган зорчигчдын зам, ногоон байгууламж гэх мэт), ариун цэврийн болон иргэний хамгаалалтын шаардлагуудыг тооцож үзнэ. Гудамж замын улаан шугмын өргөнийг гол замд – 50.0-100.0 м; гол гудамжинд – 40.0-100.0 м; нутаг дэвсгэрийн гудамж, замд – 15.0-30.0 м байхаар төлөвлөнө.
2. Тооцоот хурдыг гудамж, замын ангилалаас хамааруулан зам, барилгын төрөл /шинээр барих, өргөтгөл шинэчлэлт/ ба гудамж, замыг дайран өнгөрөх нөхцөлөөс хамааруулан авна. Барилгажаагүй газар нутагт шинээр барилга байшин барих зураг төсөл зохиох үед тооцоот хурдыг хамгийн их утгыг хэрэглэнэ. Дахин төлөвлөлтийн үед ба барилгажиттай хэсэгт өндрийн их уналттай газрын гадаргуугийн хүндрэлтэй нөхцөлд техник эдийн засгийн үндэслэлийг баримтлан тооцоот хурдыг тогтсон хязгаарлалтаас хамааруулан зэргэлдээх газрын гадаргуу, барилгажилттанд тооцсонтой нийцүүлэн заагдсан үзүүлэлтээс доогуур авахыг зөвшөөрнө. Зөвшөөрөгдсөн хөдөлгөөний хурдыг тогтоохдоо тооцоот хурднаас 10 км/ц-аар багаар авна.
3. Авто замын зорчих хэсгийг 10 эгнээтэй байхаар төлөвлөх үед замын уулзваруудын хоорондох хамгийн бага зайг 1.2 дахин ихэсгэнэ.
4. Нийслэл хот, хотын гол гудамж, замд автобус ба троллейбусны хөдөлгөөнд зориулж зорчих хэсгийн өргөнийг 3.75 м-ээр төлөвлөнө.
5. IA, IB ба IG цаг уурын дэд бүсэд гол гудамж, замын зорчих хэсгийн хамгийн их дагуу налууг 10% багасгаж төлөвлөнө.
6. Явган зам, тротуарын явганаар зорчих хэсгийн өргөнд үйлчилгээний мухлаг, сандал байрлах талбай орохгүй.
7. Нутаг дэвсгэрийн ангилалын гудамжны өргөтгөл шинэчлэлтийн нөхцөлд болон явган зорчигчдын тооцоот хөдөлгөөний эрчим хоёр чиглэлдээ 50 хүн/цаг-аас бага бол явган зам, зөргийн өргөн 1.0 м байна.
8. Явган зам нь барилгын хана, түшиц хана болон хайс хашлагатай зайлшгүй нийлж байгаа тохиолдолд түүний өргөнийг 0.5м-ээс багагүйгээр нэмэгдүүлж төлөвлөнө.
9. Тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын хөдөлгөөний тоо хэмжээнд үндэслэн гол гудамж, зам, замын уулзваруудын тооцоот өгөгдөхүүнүүдийг үе шаттайгаар төлөвлөхдөө ирээдүйн барилгажилтанд зориулсан талбай, газар доорх орон зайг заавал тооцож төлөвлөнө.
10. Хотын гол замуудыг төлөвлөхдөө авто зам дагуух бүсэд байгаа элдэв саадаас зайлуулан /Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрэл дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014 –д заасан замын хөдөлгөөний зохион байгуулах техник хэрэгслийг оролцуулахгүйгээр/ төлөвлөх ба хязгаарлагдмал нөхцлийн үе дэх тооцоот хурднаас хамааруулан авч үзнэ.

Хөдөөгийн суурин /хоторхуу суурин, хот маягийн суурин/-ы гудамж, замын тооцоот өгөгдөхүүнүүдийг хүснэгт 10.4 ба 10.5-ийн дагуу төлөвлөнө.

Хүснэгт 10.4 Хөдөөгийн суурины гудамж, замын тооцоот өгөгдөхүүн

Гудамж, замын ангилал	Гудамж, замын үндсэн зориулалт
Гол гудамж	Хоторхуу суурин, хот маягийн суурины эдэлбэр газраар дайран өнгөрөх ба тээврийн хэрэгслийн ба явганаар зорчих холболтуудыг гүйцэтгэнэ, мөн олон нийтийн төв бүхий орон сууцны барилгуудын эдэлбэр газартай холбоно.
Орон нутгийн гудамж	Орон сууцны барилгуудыг гол гудамжтай холбох холбоосыг хангана.
Орон нутгийн зам	Үйлдвэрлэлийн бүсэд үйлчлэх ба үйлдвэрлэлийн болон орон сууцны бүсийг холбох холбоосыг хангана.
Гарц зам	Олон нийтийн ба үйлдвэрийн барилгууд, суурьшлын бүсэд шууд очих гарцыг хангана.

Хүснэгт 10.5

Гудамж, замын зэрэглэл	Хөдөлгөөний тооцоот хурд, км/цаг	Хөдөлгөөний зурвасын өргөн, м	Хөдөлгөөний зурвасын тоо (хоёр чиглэлийн нийлбэр)	Эргэцгүй үеийн хавтгай дээрх хамгийн бага радиус, м	Хамгийн их дагуу налуу, %	Босоо гүдэр муруйн хамгийн бага радиус, м	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус, м	Явган замын явах хэсгийн өргөн, м
Гол гудамж	60	3.5	2-4	220	70	1700	600	1.5-2.25
Орон нутгийн гудамж	40	3.0	2	80	80	600	250	1.5
Орон нутгийн зам	30	2.75	2	40	80	600	200	1.0 /нэг талд нь төлөвлөхийг зөвшөөрнө/
Гарц зам	30	4.5	1	40	80	600	200	-

10.6 Цэцэрлэгт хүрээлэнгийн зам, дугуйн зам ба гарцуудыг хүснэгт 10.6 ба 10.7-ын дагуу гудамж, замын тусгаарлах зурвасын хэмжээг хүснэгт 10.8-ын дагуу төлөвлөнө.

Хүснэгт 10.6 Цэцэрлэгт хүрээлэнгийн зам, дугуйн зам ба гарц

Гудамж, замын зэрэглэл	Гудамж, замын үндсэн зориулалт
Цэцэрлэгт хүрээлэнгийн зам	Цэцэрлэгт хүрээлэнд ирэх үйлчлүүлэгчид, байгальд ээлтэй тээврийн хэрэгслийн гарц зам, дугуйн зам, мөн тусгай зориулалтын /цэвэрлэгээний, түргэний болон цагдаагийн/ тээврийн хэрэгсэлд зориулагдсан зам.
Гарц зам	Орон сууцны ба олон нийтийн барилгууд, үйлдвэр албан байгууллагууд болон хороолол, бичил хорооллын барилгажилтын бусад объектууд руу тээврийн хэрэгсэл очих гарц зам.
Дугуйн зам: - Гудамж замын сүлжээний хөндлөн огтлол дотор - Суурьшлын бүс, амралт зугаалгын бүсэд	Дугуйн хөдөлгөөнд зориулсан тусгайлан гаргасан зурвас. Зохицуулалттай хөдөлгөөний II болон III зэрэглэлийн хотын чанартай гол зам, орон сууцны хорооллын гудамжинд байгуулж болно. Дугуйгаар явах зориулалттай тусгайлан гаргасан зурвас.

Хүснэгт 10.7

Гудамж замын зэрэглэл	Хөдөлгөөний тооцоот хурд, км/цаг	Хөдөлгөөний зурвасын өргөн, м	Хөдөлгөөний зурвасын тоо (хоёр чиглэлийн нийлбэр)	Хавтгай дээрх хамгийн бага радиус, м	Хамгийн их дагуу налуу, %	Босоо гүдэр муруйн хамгийн бага радиус, м	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус, м	Явган замын явах хэсгийн өргөн, м
Цэцэрлэгт хүрээлэнгийн зам	40	3.0	2	75	80	600	250	-
Гарц:								
- үндсэн	40	3.0	2	50	70	600	250	1.0
- хоёрдугаар зэргийн	30	3.5	1	25	80	600	200	0.75
Дугуйн зам:								
-Гудамж замын сүлжээний хөндлөн огтлол дотор	-	1.5*	1-2					
- Суурьшлын бүсийн амралт зугаалгын бүсийн газар нутагт	20	1.00**	2	25	70	-	-	-
		1.5*	1-2	25	70	-	-	-
		1.00**	2					

* Нэг чиглэлийн хөдөлгөөнтэй тохиолдолд;

**Хоёр чиглэлийн хөдөлгөөн тохиолдолд;

Гудамж, замын тусгаарлах зурвасын хэмжээ Хүснэгт 10.8

Зурвасын байрлал	Гудамж зам дахь зурвасын өргөн, м			Дүүргийн гол гудамж
	Хотын гол зам			
	Хурдны болон тасралтгүй хөдөлгөөнтэй	Зохицуулалттай хөдөлгөөнтэй		
	Зам	Гудамж		
Төвийн тусгаарлах	6.0/2.65*	4.0/2.65*	3.5/2.65*	3.5/-
Үндсэн зорчих хэсэг нутаг дэвсгэрийн болон хажуугийн гарц хоорондын	-	3.0	3.0/2.0	-
Зорчих хэсэг ба трамвайны далангийн хоорондын	3.0	3.0/2.0	1.0/-	-
Зорчих хэсэг явган замын хоорондын	-	3.0	3.0	2.0/-
Явган зам ба трамвайны далангийн хоорондын	-	2.0	-	-

*Хаалтаар хашаалж тусгаарласан үед

Тайлбар:

1. Хүртвэрт шинээр барилгажихад зориулсан утга, хуваарьт дахин төлөвлөлт болон хязгаарлагдмал нөхцөлд зориулсан утга.
2. Хязгаарлагдмал нөхцөлд зохицуулалттай хөдөлгөөнтэй гудамж замд өргөтгөл шинэчлэлт хийж байгаа үед, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тооцоот хурд 70 км/цаг –с илүүгүй үед төвийн тусгаарлах зурвасыг энэхүү хүснэгтэнд заасан хэмжээнээс зурвасыг багаар авах буюу хийхгүй байхыг зөвшөөрнө.
3. Хотын зохицуулалттай хөдөлгөөнтэй ба дүүргийн гол гудамжинд зүүн гэр тийш эргэх зурвасыг авахдаа төвийн тусгаарлах зурвасыг багасган авахыг зөвшөөрнө.

10.7 Авто зам ашиглагчид хотын гол зам ба хурдны хөдөлгөөнтэй замуудын үндсэн зорчих хэсэгт зөвхөн олон түвшинд огтлолцсон тээврийн зангилгаагаар дамжин нэвтрэнэ.

Хотын II зэрэглэлийн гол гудамж, хотын II зэрэглэлийн гол замуудын үндсэн зорчих хэсэгт нэвтрэхэд хязгаарлагмал ба зохицуулалттай хөдөлгөөнтэй уулзвар, доод зэрэглэлийн гудамжтай /баруун гар тийш эргэх хөдөлгөөнтэй/, нутаг дэвсгэрийн ба хажуугийн гарцаар дамжин нэвтрэнэ. Зэргэлдээ газар нутагт үйлчлэхдээ хажуугийн болон орон нутгийн гарцаар дамжин нэвтрэнэ.

Хот байгуулалтын хүндрэлтэй нөхцөлд хотын чанартай II зэргийн гудамжийг өргөтгөж шинэчлэх болон нэвтрэн өнгөрөхдөө зэргэлдээ газар нутгийн одоо байгаа гарцуудыг хадгалж үлдэхийг зөвшөөрнө.

10.8 Хавтгай дээрх муруйн радиус нь 400 м ба түүнээс бага бол зорчих хэсэгт өргөсөлт хийж өгнө. Хавтгай дээрх муруйн хөдөлгөөний зурвасын өргөсөлтийг хүснэгт М.1 – д зааснаар буюу тооцоон дээр үндэслэн авахыг зөвшөөрнө.

10.9 Байгууламжийн хөндлөн огтлолын хөндлөн налуу:

-зорчих хэсэгт – хамгийн бага - 10‰, хамгийн их - 30‰

-явган замд – хамгийн бага - 5‰, хамгийн их - 20‰

-дугуйн замд – хамгийн бага - 5‰, хамгийн их - 30‰-аар тооцож төлөвлөнө.

10.10 Гол замын үндсэн зорчих хэсгийн захаас орон сууцны барилгуудын тохируулах шугам хүртэлх зай 50.0 м-ээс багагүй, дуу чимээнээс тусгаарлах байгууламж хэрэглэх нөхцөлд 25.0 м-ээс багагүй байна.

Гудамжны үндсэн зорчих хэсэг, нутаг дэвсгэрийн болон хажуугийн гарцийн ирмэгээс барилгажилтын шугам хүртэл 25.0 м-ээс ихгүй зай авна. Заасан хэмжээг нэмэгдүүлэх тохиолдолд барилгажилтын шугамнаас 5.0 м-ээс ойргүй зайнд 6.0 м өргөн зурвасыг галын машин явахад тохиромжтой байдлаар авна.

Мухар гудамж, замын төгсгөлд автомашин эргэхэд зориулан талбай гаргаж өгөх ба зайлшгүй тохиолдолд нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл эргэх талбайг байгуулж өгнө.

10.11 Суурин газрын гудамж замын хөндлөн огтлол нь өөртөө зорчих хэсэг /түүн дотор хурдны шилжилтийн зурвас, цуглуулах зурвас, нийтийн тээврийн зогсоолд зориулсан зурвас, тээврийн хэрэгслийг зогсоох, удаанаар зогсоох зогсоол/, явган зам, дугуйн зам, төвийн болон хажуугийн тусгаарлах зурвас, цэцэрлэгт гудамжтай байна. Гудамж замын сүлжээний хөндлөн огтлолын бүрэлдэхүүнд цахилгаанжсан төмөр замын тээврийн шугам-трамвай, хурдан трамвай ба газар дээрх метроны шугмын хэсэг багтана.

Хөндлөн огтлолын хэсгүүдийг өөр хооронд нь зааглахын тулд тусгаарлах зурвасыг ашиглана. Тусгаарлах зурвасын хамгийн бага өргөнийг хүснэгт 10.8-д заасны дагуу тооцно.

10.12 Хөдөлгөөний зохицуулалттай гол гудамж, замд тусгаарлах зурвасаар зааглагдсан дугуйн зам төлөвлөхийг зөвшөөрнө. “Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5683:2016-д заасны дагуу дугуйн замын автозамын хөндлөн огтлолд үзүүлнэ. Хүн амын нийтийн амралт зугаалгын бүсэд болон бусад ногоон байгууламж бүхий газар нутагт гудамж зам болон явган зорчигчдоос тусгаарлагдсан дугуйн зам байгуулахаар төлөвлөнө.

Нэг чиглэлийн болон хоёр чиглэлийн хөдөлгөөнтэй дугуйн зам байгуулахдаа дугуйн замын ирмэгээс аюулгүй байдал хангасан хамгийн бага зай, м:

- зорчих хэсэг, тулгуур шон, мод хүртэл 0.75;

- явган зам хүртэл 0.5

Тайлбар: Нутаг дэвсгэрийн замын ирмэгээр дугуйн зам байгуулахыг зөвшөөрнө. Зурвасын өргөн нь тээврийн хэрэгслийн урсгалын хөдөлгөөний чигийн дагууд 1.0 м-ээс

багагүй, хөдөлгөөний эсрэг чигт 1.5 м-ээс багагүй байна. Явган зам дагуу байгуулсан дугуйн замын зурвасын өргөн 1.0 м-ээс багагүй байна.

10.13 Гудамж, замын хажуугийн хашлага болон зорчих хэсгийн ирмэгийн дугуйрсан радиусыг тооцоогоор тодорхойлох бөгөөд 6.0 м-ээс багагүй, хөдөлгөөнгүй нөхцөлд 1.0 м – ээр авахыг зөвшөөрнө.

Нийтийн тээврийн /автобус, троллейбус/ эргэлтийн муруйг энэ төрлийн тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үеийн техникийн шаардлагын дугуу тогтооно.

10.14 Зохицуулалтгүй хөдөлгөөнтэй уулзвар ба гудамж, замын нийлэх хэсэг болон явган зорчигчдын гарцан дээр үзэгдэх гурвалжинг зайлшгүй тооцно. Гурвалжингийн талуудын хэмжээг «тээврийн хэрэгсэл – тээврийн хэрэгсэл» нөхцөлд болон «явган зорчигч – тээврийн хэрэгсэл» нөхцөлд тооцооны дагуу төлөвлөх шаардлагатай.

Үзэгдэх гурвалжингийн хязгаар дотор барилга байгууламж, хөдөлгөөнт зүйлс /мухлаг, битүү ачааны бүхээг, сурталчилгааны самбар, архитектурын жижиг биетүүд ба бусад/ 1.0м-ээс өндөртэй мод, бут сөөг байрлуулахыг зөвшөөрөхгүй.

Тайлбар: Барилгажилтын нягтрал ихтэй үзэгдэх гурвалжинг зохион байгуулах боломжгүй нөхцөлд тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын аюулгүй байдлыг хөдөлгөөн зохицуулга болон тусгай техник тоноглол ашиглан зохион байгуулна.

10.15 Гудамж замын сүлжээний бүхий л байгууламжид тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан үзэгдэлтийн зайг хангах шаардлагатай.

10.16 Нэг түвшинд огтлолцсон уулзварыг зохицуулалттай, зохицуулалтгүй болон тойрог уулзвар гэж ангилна. Тээврийн хэрэгслийн урсгалыг гудамж замын сүлжээнд оновчтой хуваарилахаар тооцоолон ирээдүйн хөдөлгөөний эрчим дээр үндэслэн уулзварыг төлөвлөнө. Нэг түвшинд огтлолцсон уулзвар хоорондох зайг дараах зайнаас багагүйгээр тооцно, м:

- зохицуулалттай хөдөлгөөнтэй гол гудамж, замд 400;
- дүүргийн гол гудамжинд /хуваарилах/ 200;
- нутаг дэвсгэрийн гудамж, замд 60

Зохицуулалттай хөдөлгөөнтэй уулзварын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд баруун болон зүүн гарын эргэлтийг зохион байгуулах нэмэлт зурвасыг хийнэ.

10.17 Хурдны болон тасралтгүй хөдөлгөөнтэй гудамж замын уулзвар, нийлэх хэсэгт өөр хооронд нь бүрэн огтлолцсон, зохицуулалттай хөдөлгөөнтэй болон гол гудамж замын огтлолцол дээр бүрэн биш огтлолцсон өөр өөр түвшний уулзвар төлөвлөнө.

10.18 Өөр өөр түвшинд огтлолцсон тээврийн уулзваруудын хоорондох зай 2000 м-ээс багагүйгээр тооцож төлөвлөнө. Хот байгуулалтын төвөгтэй нөхцөл болон дахин төлөвлөлтийн үед тээврийн уулзваруудын хоорондох зайг 600 м-ээс багагүйгээр төлөвлөнө. Замын уулзваруудын хоорондох зайг хамгийн багаар **тооцох** боломжгүй нөхцөлд тэдгээрийн нэгтгэн ажиллуулах төлөвлөлтийн шийдлийг авч үзнэ.

Нийтийн зорчигч тээврийн сүлжээ, явган хүний хөдөлгөөн

10.19 Нийтийн зорчигч тээврийн төрлийг тооцоот зорчигч урсгал ба зорчигчдын зорчилтын алслалт дээр үндэслэн төлөвлөнө. Нийтийн тээврийн төрлүүдийн нэвтрүүлэх чадвар байгууламжийн өгөгдөхүүн, байгууламжуудыг /зогсоолын тавцан, буух талбай/ тодорхойлохдоо ердийн нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний дүүргэлтийн нормыг тооцоот хугацаанд, хөдлөх бүрэлдэхүүний шалан дээрх чөлөөт талбай нь 4 хүн/м², хурдтай тээврийн хэрэгсэлд 3 хүн/м² байхаар тооцно.

10.20 Нийтийн зорчигч тээврийн шугамыг гол гудамж замд бусад тээврийн хэрэгслийн урсгалтай нь хамт хөдөлгөөн зохион байгуулахдаа троллейбусны шугам, газар дээрх метроны хэсгүүдийг зорчих хэсгийн зориулалтын тусгайлсан зурваст эсвэл тусгаарлагдсан далан дээр төлөвлөнө.

Тайлбар: 1. Том, томоохон хотуудын төвийн дүүргүүдэд гудамж замын сүлжээний нэвтрүүлэх чадвар хязгаарлагдсан үед гудамжны гаднах трамвайны шугамыг бага гүнтэй туннель болон эстакад дээр төлөвлөхийг зөвшөөрнө. 2. Хотын түүхэн цөмтэй холбоотой төв хэсэгт нийтийн зорчигч тээврийн зогсоолоос явганаар хүрэлцэх нормативт зайг хангах боломжгүй нөхцөлд тухайн нутаг дэвсгэрт тусгай төрлийн тээврийн системийг хэрэгжүүлэхийг зөвшөөрнө.

Гол гудамжнуудын хоорондох нутаг дэвсгэрийн хэмжээ 100 га-гаас их /дахин төлөвлөлтийн үед 50 га-гаас их/ талбайд нийтийн зорчигч тээврийн шугам төлөвлөхдөө орон нутгийн гудамж зам дагуу болон тусгаарлагдсан далан дээгүүр байгуулахыг зөвшөөрнө. Тухайн нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим хоёр чиглэлдээ 30 нэгж/цаг- аас хэтрэхгүй, тооцоот хурд нь 40 км/цаг байна.

10.21 Барилгажсан нутаг дэвсгэрт нийтийн зорчигч тээврийн шугамын сүлжээний нягтралыг тухайн ашиглалтын зориулалт болон зорчигч урсгалын эрчимээс хамааруулан төлөвлөнө.

10.22 Нийтийн тээврийн хамгийн ойр буудал хүртэл явганаар зорчих алслалт 500 м-ээс ихгүй байхаар төлөвлөх ба дээрх зайг цаг уурын IA, IB, IG ба IIA дэд бүсэд 300 м хүртэл, цаг уурын ID ба IV дэд бүсэд 400 м хүртэл багасгахыг зөвшөөрнө.

Хотын олон нийтийн төвд нийтийн тээврийн хамгийн ойрын буудлаас олон нийтийн байгууламж хүртэл явганаар хүрэх алслалт нь 250 м-ээс ихгүй;

- эмнэлгийн байгууллага, суурин поликлиник, иргэдийн нийгмийн үйлчилгээний салбар хүртэл 150м-ээс ихгүй;
- үйлдвэрийн болон аж ахуй агуулахын бүсэд байгууллагын орц хаалганаас 400 м-ээс ихгүй;
- нийтээр амрах болон биеийн тамирын бүсэд гол хаалганаас 800 м-ээс тус тус ихгүй байна.

Газрын гадаргын хүндрэлтэй нөхцөлд, зорчигчдын тусгай өргөх тээврийн хэрэгсэл байхгүй бол заагдсан зай хэмжээг газрын гадарггуугийн 10.0м уналт тутамд 50.0м-ээр багасгаж тооцоно.

Тайлбар: 1. Хувийн эдлэн бүхий барилгажилттай бүсэд нийтийн тээврийн хамгийн ойр буудалд явганаар очих алслалт нь их хот, том болон томоохон хотод 600 м хүртэл, жижиг дунд зэргийн хотод 800 м хүртэл ихэсгэж авна.

10.23 Нийтийн зорчигч тээврийн шугамын буудал хоорондын зайг суурьшлын бүсэд автобус, троллейбус ба трамвайд 400.0–600.0м; буухиа автобус 800.0–1200.0м; метронд 1000.0–2000.0м; цахилгаан галт тэргэнд 1500.0–2000.0 м-ээр тооцно.

10.24 Дамжин суулт хийх нийтийн тээврийн зангилгаануудад зорчигч урсгалын хэмжээ, зорчигчдын хугацаанаас хамаарахгүйгээр зорчигчдын дамжин суулт хийх хугацаа нь тээврийн хэрэгслийг хүлээх хугацааг оруулахгүйгээр 5 минутаас ихгүй байна. Бусад тохиолдолд нэг төрлийн тээврийн хэрэгслээс өөр төрлийн тээврийн хэрэгсэлд дамжин суух газруудад бүх асуудлыг иж бүрнээр шийдвэрлэсэн дамжин суултын зангилгааг байгуулна.

Дамжин суух зангилгааны төрлөөс хамааруулан түүний бүрэлдэхүүнд: хотын гаднах болон хот орчмын нийтийн тээврийн буудал, гудамжнаас тусгаарлагдсан цахилгаан тээврийн зогсоол, нийтийн тээврийн буудал, автомашины зогсоол, явган хүний хөдөлгөөнд зориулсан зам талбай багтана.

Нийтийн тээврийн хэрэгслийн буудлаас тээврийн дамжин суултын зангилгаа хүртэл явганаар хүрэх зай нь дараах зайнаас ихгүй байна, м:

- Метро болон экспресс метро, хурдан трамвай болон хотын хөнгөн төмөр замын зорчигчдын буудал хүртэл 100 м-ээс ихгүй;
- Хот орчмын төмөр замын зорчигчдын буудал, станц хүртэл 150 м-ээс ихгүй.
- «Метро, хот орчмын нийтийн тээвэр, хотын доторх хөнгөн төмөр зам»-ын дамжин суулт хийх зангилгаанд явган зорчих замын урт нь 150 м-ээс ихгүй байна.
- «Нийтийн тээвэр нийтийн тээвэр»-ийн дамжин суултын зангилгаанд явган зорчих алслалт нь 120 м-ээс ихгүй байна.

Тайлбар: Явганаар зорчих замын уртыг нийтийн тээврийн буудлаас хурдтай зорчих нийтийн тээврийн хэрэгслийн буудал, станцын орох хаалганы гонх хүртэл зайгаар тооцно.

Тээврийн дамжин суух зангилгааны байгууламж дахь метро, нийтийн тээврийн буудлын зорчигчдыг буулгах талбайг хөдөлгөөний урсгалын тооцоолсон нягтралыг хангах нөхцөлөөс хамааруулан 0.45 хүн/м² –аас ихгүйгээр төлөвлөнө. Хөдөлгөөний хомсдолтой зорчигчдыг явахад зориулж тусгай тээвэрлэгч, цахилгаан өргүүр, урсдаг явган зам, өргөгч ашиглана.

10.25 Бага гүнд байгуулах метроны шугамын дагууд техникийн зурвасыг төлөвлөж өгөх ба метроны барилгын ажил дуустал мод тарихыг хориглож, метроны шугамыг төлөвлөсөн байгууллагатай зөвшөөрөлцсөний дагуу барилга байгууламжийг сэргээн босгох, газар доогуурх инженерийн шугам сүлжээ байрлуулна.

10.26 Суурин газрын явган зорчигчидод зориулсан дэд бүтцэд нь хүн амын хөдөлгөөний хомсдолтой хэсгийг хамруулан, явганаар зорчигчдын урсгалыг саадгүй нэвтрүүлэх нэгдсэн тасралтгүй систем бий болгох ёстой. Явганаар зорчигчидод зориулсан дэд бүтцийн бүрэлдэхүүнд явганаар зорчих бүс; явган гудамж, зам, талбай; явган гаререй, явган эспланад, нэг болон олон түвшний явган гарц орно.

а. Зам-тээврийн барилга байгууламжийн төлөвлөлтийн үед /бага гүнд байрлах метро, бага гүнд байрлах авто машины тунель, тээврийн олон түвшний зангилгааны барилга байгууламж (эстакад, гарц, эргэлт), тээврийн дамжин суултын зангилгаа зэрэг өөр хоорондоо ойрхон байрласан боловч өөр өөр хугацаанд баригдаж дуусахаар нөхцөлтэй байвал явган зорчигчидод зориулсан гарцыг холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн нэгдмэл байдлаар байгуулах боломжийг харгалзан үзнэ.

б. Суурьшлын болон олон нийтийн зориулалтын газарт явганаар зорчигчдын дэд бүтцийг бий болгох үед тодорхой газар нутгийн төлөвлөлтийн болон функциональ онцлогт тохирсон явганаар холбогдох хамгийн богино, бага хугацаа зарцуулан явганаар зорчих үндсэн үүрэг зориулалтыг хангасан байхаар хэрэгжүүлэх хэрэгтэй.

в. Явганаар зорчигчдын орон зай, /явган гудамж, талбай, бүсүүд/ явган байгууламжуудыг /явган зам, зам, гүүр гэх мэт/ төлөвлөх үед гудамж, замын сүлжээний зориулалтын газарт Хот, суурины гудамж замын сүлжээг төлөвлөх норм ба дүрмийн холбогдох шаардлагуудыг тооцож үзэх хэрэгтэй.

г. Явган гарцын байршлыг төлөвлөхдөө тухайн гудамж замын сүлжээний хэтийн хөгжил, суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн тээврийн дэд бүтэц, бүх төрлийн нийтийн тээврийг иж бүрнээр хөгжүүлэх схем болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулна.

д. Явган зорчигчдын зорчих хөдөлгөөний дагуу, зэргэлдээ байрласан барилгажилтын бүрэлдэхүүнд худалдаа, үйлчилгээ, соёл, урлаг, спортын болон чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулалтын барилга, байгууламж, орон сууц /зочид буудал/ төлөвлөнө.

е. Явган зорчигчдын олон түвшний төрөл бүрийн үйл ажиллагаатай орон зайг бий болгохдоо газрын түвшин болон аль болохоор газарт ойрхон байхаар төлөвлөх хэрэгтэй.

10.27 Зохицуулалттай хөдөлгөөн бүхий гол гудамж замын барилгажсан хэсэгт нэг түвшинд огтлолцсон явган гарцыг 200-400 м давтамжтайгаар байрлуулна.

Шат болон налуу зам, өргөгчөөр тоноглогдсон олон түвшний явган гарцыг дараах давтамжтайгаар төлөвлөнө, м:

- Хурдны авто зам, хурдан трамвайны зам болон төмөр замын дагуу 400-800 м;
- Тасралтгүй хөдөлгөөнтэй гол гудамжинд 300-400 м.

Тайлбар: 1. Зохицуулалттай хөдөлгөөнтэй гол гудамжинд замын зорчих хэсгийг хөндлөн гарч байгаа явган зорчигчдын урсгал 3000 хүн/цагаас их байвал олон түвшний явган гарцийг байгуулж болно. 2.Засаг захиргааны болон худалдааны төв, зочид буудал, театр, үзэсгэлэн болон худалдааны захуудад явган зам /тротуар, талбай, шат/ төлөвлөхдөө явган зорчигчдын хөдөлгөөний нягтрал оргил цагт 0.3 хүн/м² –с ихгүй; үйлдвэрийн өмнөх талбай, спорт үзвэрийн байгууллага, кинотеатр, вокзал орчимд 0.8 хүн/м² байх нөхцлийг хангасан байх хэрэгтэй.

10.28 Явган хүний зам, зогсоол, авто замын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдал, тав тухтай зорчиход зориулж MNS 6808:2019 “Явган хүний зам, талбайн төлөвлөлт техникийн шаардлага” стандартын дагуу зориулалтын налуу зам, гарцуудыг төлөвлөнө. Нийтийн тээврийн буудал зогсоол болон тусгайлсан зогсоолын газрууд руу хүрэх зам нь саадгүй байна.

Тээврийн хэрэгслийн хадгалалт, үйлчилгээний барилга, байгууламж

10.29 Хот дотор авто машин байрлуулах орон зайг дараахи байдлаар авч үзнэ. Үүнд:

- Хотын байнгын оршин суугчдын суудлын авто машиныг оршин сууж байгаа газрынх нь ойролцоо хадгалах байгууламж;
- Байнгын оршин суугчид болон өдөртөө төрөл бүрийн зорилгоор ирж очдог хотод байдаг хүн амын суудлын авто машины зогсоолын байгууламж.

10.30 Хадгалах болон зогсоолоор хангах суудлын авто машины шаардлагатай зай талбайн тоог хэмжээг хүснэгт 10.9 болон хавсралт Ж-д заасны дагуу төлөвлөнө. Тээврийн хэрэгсэл байрлуулах барилга, байгууламж, талбай, тусгай байранд байрлах авто зогсоолын төлөвлөлтөнд Авто зогсоол БНБД 21-05-10-ыг мөрдөнө.

Тайлбар: 1. Төлөвлөлтийн норматив үзүүлэлтээс гажсан хэмжээ нь энэхүү бүлэг болон хавсралт Ж-д зааснаас $\pm 30\%$ ихгүй байна.

Хүснэгт 10.9

Тав тухтай байдлаас хамаарсан орон сууцны төрөл	Сууц бүрт авто тээврийн хэрэгсэл хадгалах орон зай
1. Тансаг зэрэглэл	2.0
2. Бизнес зэрэглэл	1.2
3. Ердийн	1.0
4. Тусгай зориулалтын	0.7
<i>Тайлбар:</i> 1. Суурьшлын бүсээс гадна байрласан гараашуудад нийт суудлын авто машины 10%-г улирлын чанартай хадгалахаар төлөвлөнө. 2. Хадгалах газруудын хэрэгцээ шаардлагын тооцоололд хувийн хэрэгцээний бусад тээврийн хэрэгсэл /мотоцикл, мопед,	

моторт дугуй, мотороллер/-ийг зайлшгүй тооцож үзэх ба нэгдсэн тооцооны нэгжид /хувийн автомашин/ шилжүүлсэн дараах итгэлцүүрээр тооцоно:

- Мотоцикл, дугуйтай мотороллер болон моторт дугуй 0,5;
- Мотоцикл ба дугуйгүй мотороллер0,25;
- Мопед ба унадаг дугуй, скүүтэр..... 0,1

Үйлчилгээний зориулалттай барилгуудад үйлчлэх /орон сууц, худалдаа, үзвэр үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалттай/ дундын эзэмшлийн авто зогсоолыг, зогсоолоор үйлчлүүлж байгаа объектын үйл ажиллагааны үед оргил ачааллын үеийн өөрчлөлтийн хангамжийг багасгахгүйгээр зохион байгуулахдаа нийт шаардагдах машины талбайг хот, суурин газрын эдэлбэр газрын төвд 15%-20%, алслагдсан бүсүүдэд 10%-15% хүртэл тус тус багасгахыг зөвшөөрнө.

10.31 Суурьшлын бүсэд оршин суугчдын суудлын авто машиныг хадгалах ил зогсоол болон дулаан зогсоолыг Орон сууцны барилгын зураг төсөл, төлөвлөлт БНБД 31-01-10-ын дагуу тооцож төлөвлөх ба явганаар хүрэх зай нь 800 м-ээс, дахин төлөвлөлт хийж байгаа бол 1000 м-ээс ихгүй байна.

10.32 Орон сууцны хороолол, бичил хороолол дотор авто машины газар доорх зогсоолыг хотод, орон сууц бүрд 0.5-аас багагүйгээр, нийслэл хотод 0.2 машин байхаар тооцно. Дахин төлөвлөлтөнд барилгажилтын хүндрэлтэй нөхцөлд шинээр орон сууц барьж байгаа талбайд авто машин хадгалах газрыг орон сууцны эдэлбэр газрын хил дагуу, орон сууцны өрх бүрд 1.0 машинаар тооцож төлөвлөнө.

Орон сууц, олон нийтийн барилга ба түүний өргөтгөлд /сургууль, сургуулийн өмнөх хүүхдийн байгууллага орохгүйгээр/ суудлын автомашины битүү гарааш байрлуулахдаа олон нийтийн болон орон сууцны барилга төлөвлөх норм, дүрэмд заасан шаардлагуудыг хангана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний автомашин болон бусад моторт тээврийн хэрэгсэл хадгалах зориулалттай зогсоолыг орон сууцны орцноос 50.0 м-ээс ихгүй үйлчлэх хүрээтэй төлөвлөнө. Зогсоолын орон зай, тоо хэмжээг холбогдох норм болон зураг төслийн даалгаварыг баримтлана. .

Тайлбар: Газар доорх гарааш барих боломжгүй болон боломж нь хязгаарлагдмал гидрогеологийн тааламжгүй нөхцөлтэй нутаг дэвсгэрт энэхүү бүлгийн нэгдүгээр хэсгийн шаардлагыг хангах зорилгоор спортын болон аж ахуйн зориулалттай талбайд газар дээр болон газар дээрх-доорх байгууламжийг байгуулсаны дараа шороогоор дүүргэх болон асгаасан шороогоор бүрхэх аргыг ашиглаж болно.

10.33 Суудлын авто машиныг байнгын болон түр хугацаагаар хадгалах зориулалттай газар дээрх болон газар дээрх-доорх гарааш, ил зогсоол /машин угаалга, техникийн үйлчилгээний станц/ бохирдолгүй талбайгаас суурьшлын бүсэд байрласан орон сууц, олон нийтийн зориулалттай барилга, түүний дотроос ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, эрүүлийг хамгаалах байгууллага хүртэлх зайг дуу чимээний болон эрүүл ахуйн нормчлолыг хангахаар тооцно.

Тэдгээрийг байрлуулахдаа хот байгуулалтын нөхцөл, барилгажих талбайн архитектур-төлөвлөлтийн шийдэл, орчны агаарын бохирдол, дуу чимээний түвшин замхрах тооцоон дээр үндэслэн дуу чимээ, галын аюулгүй байдлын норматив шаардлагын дагуу тооцно.

Тайлбар: 1. Авто машины газар доорх зогсоолын агааржуулалтын цооног хүртэлх зайг эрүүл ахуйн норм дүрэмд заасны дагуу авах хэрэгтэй.

10.34 Төрөл бүрийн функц, зориулалттай байгууламжинд ажиллагсад болон хүрэлцэн ирэгчдийн суудлын авто машины зогсоолд тухайн байгууламжийн дэргэдэх, хувийн болон замаас нь хүлээж авах зогсоолуудыг ашиглахаар тооцох хэрэгтэй. Тухайн байгууламжийн дэргэдэх суудлын авто машины зогсоолыг хавсралт И-ын дагуу тооцож төлөвлөнө.

Хурдан төмөр замын тээвэр бүхий хотод төмөр замын станцаас явганаар хүрэх тойрог дотор тухайн объектод шаардагдах машины-зай талбайг олохдоо тооцоогоор гарсан машины-зай талбайг 25 %-иар багасгахыг зөвшөөрнө.

10.35 Буудал, зогсоолоос суудлын автомашин тавих зогсоол хүртэлх зайг дараах үзүүлэлтээс ихгүйгээр төлөвлөнө, м:

- вокзалын зорчигчдын байгууламж, томоохон худалдааны болон нийтийн хоолны байгууламжийн орцноос150.0;
- бусад байгууламж болон үйлчилгээ болон засаг захиргааны барилгаас250.0;
- цэцэрлэгт хүрээлэн, үзэсгэлэн болон стадионы орцноос400.0

Тайлбар: 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн авто машин байрлуулах талбайн байршлыг авто зогсоолын дүрэм болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн норм дүрмийн шаардлагыг мөрдөнө.

10.36 Суудлын авто машины гарааш зогсоолын нэг машины талбайг давхрын тооноос хамааруулан дараах байдлаар тооцно, м2:

- нэг давхар 30.0;
- хоёр давхар 20.0
- гурван давхар 14.0;
- дөрвөн давхар 12.0;
- таван давхар 10.0;
- газар дээр зогсоолд25.0

10.37 Гараашийн орц, гарц хүртэл хамгийн бага зай хэмжээ дараах үзүүлэлтээс багагүй байна, м:

- гол гудамжны уулзвараас – 50.0
- нутаг дэвсгэрийн гудамжнаас – 20.0
- нийтийн зорчигч тээврийн буудал зогсоолоос – 30.0

Суудлын авто машины газар доорх гараашийн зогсоол орц болон гарц хүртэлх зайг эрүүл ахуйн норм дүрэмд заасны дагуу тооцоно. Газар доорх гараашийн агааржуулалтын цооногийг эрүүл ахуйн норм дүрэмд заасны дагуу төлөвлөнө.

10.38 Албаны авто машин, тусгай зориулалтын суудлын авто машин, ачааны тэрэг, такси болон түрээс, автобус троллейбусны бааз, трамвайны депо, мөн түүнчлэн техникийн үйлчилгээний төвлөрсөн бааз болон авто машиныг улирлын чанартай хадгалах, авто машин түрээслэх цэгүүдийн эдэлбэр газрын хэмжээг хавсралт Ж-ын дагуу тооцох ба эдгээрийг үйлдвэрийн бүсэд төлөвлөнө.

10.39 Автомашины техникийн үйлчилгээний станцийн нэг /өргүүрт/ постонд 200 хөнгөн тэрэг ноогдохоор тооцож төлөвлөнө. Эдэлбэр газрын хэмжээ, га:

- 10 цэг /пост/-нд 1,0
- » 15 » 1,5
- » 25 » 2,0
- » 40 » 3,5

10.40 Шатахуун түгээх станц (ШТС)-ийг түлш түгээх нэг хошуунд 1200 суудлын авто машин ноогдохоор тооцно. Эдэлбэр газрын хэмжээ, га:

» 2 ».....	0,1
» 5 »	0,2
» 7 »	0,30
» 9 »	0,35
» 11 »	0,4

10.41 Газар доор шингэн түлш хадгалах зориулалтын сав бүхий шатахуун түгээх станцаас сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн боловсролын байгууламж, сургууль, дотуур байртай сургууль, эмнэлгийн болон эрүүл ахуйн байгууламжийн барилгын хана хүртэл зайг холбогдох норм дүрмийг үндэслэн авна. Заагдсан зай хэмжээг дизель түлш түгээх станц, шингэн түлш хадгалах газар доорх савнуудад мөн адил дагаж мөрдөнө.

10.42 Хот, суурин газарт цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх үйлчилгээний дэд бүтцийг төлөвлөнө. Цэнэглэх цэгийг ШТС, техникийн үйлчилгээний станц, авто машины зогсоол, бизнесийн болон худалдааны төв, орон сууцны хороололд байгуулж болно.

11. Аюулгүй байдал

Хот, суурины төлөвлөлтөнд Гамшгаас²⁹ хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох бусад хууль, норм, дүрмийг үндэслэн хүн амын аюулгүй байдал, байгалийн аюулт үзэгдлийн³⁰ үр дагаварыг тооцох ёстой.

Инженерийн бэлтгэл³¹ ба нутаг дэвсгэрийн хамгаалалт

11.1 Хот, хөдөөгийн суурины төлөвлөлт, барилгажилтанд нутаг дэвсгэрийн инженер геологи, гидрогеологийн нөхцлийн өөрчлөлтийн судалгаа, үнэлгээ, газар ашиглалт, зохион байгуулалтын байдалд тулгуурлан тухайн нутаг дэвсгэрийн гадаргын усыг зайлуулах, хөрсний ус доошлуулах, үерийн аюул, уруй, цасны нуралт, хөрсний гулсалт, нуралтаас хамгаалах инженерийн барилга, байгууламжийг тооцсон байх ёстой

11.2 “Хот хөдөөгийн суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар” /УББ 30-201-09/-ын хүрээнд хот, суурины нутаг дэвсгэрийн өндөржилт төлөвлөлтийг тооцож хот байгуулалтанд тохиромжтой байдлыг үнэлнэ. Өндөржилт төлөвлөлтөнд Хот, суурин газрын өндөржилт төлөвлөлтийн геодезийн ажил БДг мөрдөнө.

11.3 Хот байгуулалтын үнэлгээг үндэслэн хот, суурины хүн амыг байгалийн болзошгүй эрсдлээс хамгаалах, гадаргын усыг зайлуулах инженерийн шугам сүлжээ барилга, байгууламжийг төлөвлөнө.

Инженерийн барилга, байгууламжийн төлөвлөлтөнд Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам, талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/, Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар /БД 30-103-21/, Үер борооны усны байгууламж /UCS 0501B:2023/ –ыг мөрдөнө.

²⁹ 4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

³⁰ 4.1.2.“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;”

³¹ **Инженерийн бэлтгэл ажил**- Хот байгуулалтын тухай хуульд зааснаар хот, суурины нутаг дэвсгэрийн өндөржилт, хүн ам, барилга, байгууламжийг үер, хөрсний нуралт, элсний нүүлт, цасны хунгарлалтаас хамгаалах бэхэлгээ, далан суваг, гүүр, гарц, зам, талбай барьж байгуулах урьдчилсан арга хэмжээ;

11.4 Зам, талбайн борооны ус зайлуулах гол сүлжээнд салбар сүлжээний ус зайлуулах шугамуудыг холбож /далд аргаар/ нэгдсэн сүлжээ байгуулан гадаргын усыг дахин ашиглахаар тооцож төлөвлөнө. Гадаргын ус зайлуулах ил арга суваг, шуудуу, жалга, ховил зэргийг нам давхар барилга болон цэцэрлэгт хүрээлэнд, гүүр, гудамж, зам, гарц, хучилттай явган хүний замтай огтлолцох тохиолдолд ашиглаж болно.

11.5 Гол усны эрэг орчимд байрласан суурьшлын нутаг дэвсгэр шар усанд автах, салхиар туугдах ус; хөрсний усанд автах (усанд идэгдэх, нурах) үзэгдлээс хамгаалагдсан байна. Шороон дэвсгэр давхарга тавьсан талбайн ирмэгийн тэмдэглэгээг салхитай үед усны хөвөөний үеийн давалгааны өндрийг бодолцон тооцоот хэвтээ тэнхлэгээс 0,5 м-ээр дээш байхаар тооцно. Тооцоот түвшнээс дээгүүр тавих шороон далангийн хярын өндөр, зэрэглэлээс хамааран Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам, талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/-ын зохих шаардлагад нийцсэн байна.

11.6 Усны түвшний тооцоот өндрийг усны түвшний хамгийн өндөр тэмдэглэгээг давтамжаар буюу орон сууц, нийтийн эзэмшлийн барилга, байгууламж бүхий талбай болон барилгажуулахаар төлөвлөж байгаа талбайд – 100 жилд нэг удаа; цэцэрлэгт хүрээлэн биеийн тамирын талбай зэрэг тэгш гадарга бүхий байгууламжийн хувьд – 10 жилд нэг удаа байхаар тус тус тооцно.

11.7 Уруйн (шар усны үер) аюултай нутаг дэвсгэр дэх барилга, байгууламжийг хамгаалахын тулд ой модыг дээд зэргээр арчлан тордох мод, сөөг тарьж ургуулах, хиймэл нуурын байгууламж барих, голын эрэгт далан хаалт хийж бэхлэх, уруйн усны урсацыг чиглүүлэх, сааруулах инженерийн барилга, байгууламжуудыг зайлшгүй төлөвлөх хэрэгтэй.

11.8 Эрозийн³² үйлчлэлийн явцад гуу, жалга үүссэн газарт гадаргын усыг зохион байгуулалттай урсгах, жалганы суурь ёроолыг бэхжүүлэх, энгэр газрыг тэгшлэх, ойжуулахаар төлөвлөнө.

11.9 Хөрсний усны түвшин өндөртэй суурьшлын нутаг дэвсгэрт, намгархаг хэсэгт үндсэн барилгажилтын бүсэд ус шүүрүүлж урсгах хаалттай аргаар хөрсний усны түвшинг бууруулна. Хот, суурин газрын барилгажилтын талбайд болон цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэг болон бусад зүлэгжүүлсэн нийтийн эзэмшлийн нутаг дэвсгэрт задгай хатаах сүлжээ байгуулж болно.

Хөрсний усны түвшинг барилгажилтын талбайд гадаргын төслийн тэмдэгтээс 2.0 м-ээс багагүй; цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэг, модот гудамж болон бусад ногоон суулгацаас 1.0 м – ээс багагүйгээр бууруулахаар тооцоно.

11.10 Онцгой тохиолдолд бүрэн ба хэсэгчлэн тэгшлэх арга хэмжээг авахдаа тэдгээрийн доор гадаргын усыг урсган зайлуулах хоолой болон дренажны коллекторуудыг байрлуулахыг зөвшөөрнө. Гуу жалгатай газруудад тээврийн хэрэгслийн гараж, аж ахуйн агуулах, түүнчлэн цэцэрлэгт хүрээлэнг барьж ашиглахыг зөвшөөрнө.

11.11 Хүлрийн оршоостой талбайд барилгажилт явагдахаар төлөвлөгдсөн бол хөрсний ус бууруулахын зэрэгцээ гадаргууг эрдэст шороон дэвсгэр давхарга тавьж, зохих

³² **Эрози:** Урсгал усны эвдэх үйл ажиллагааг хэлнэ. Эрозийн процесс нь: А. Гүний Б. Хажуугийн В. Ухрах гэсэн гуран төрөл чиглэлээр явагдана.

Ус ямар нэг ховилоор урсахдаа ямагт ховилын ёроолыг ухаж, идэж өөрийн голдрилыг үүсгэдэг. Үүнийг **гүний эрози** гэнэ. Гүний эрозийн үр дүнд голын дэнж үүснэ. Голын ус эргээ идэж нураах процессыг **хажуугийн эрози** гэнэ. Голын гүний эрозийн үр дүнд голын голдрилын налуу адгаасаа эхрүүгээ аажим тэгширч эхэлдэг. Үүний үр дүнд голын хөндий эхрүүгээ улам давшаар өөрийн эх авдаг уул нуруудыг сэтэлж хэрчиж эхэлнэ. Үүнийг голын **ухрах эрози** гэдэг.

үндэслэлтэй бол хүлрийг зайлуулж болно. Эрдэст шороон дэвсгэр давхаргын зузаан нь хүлрийн үе шаттай сууж байгаа суултыг гадаргууны усны урсацад шаардлагатай налуу үүсэх хүртэл тооцож төлөвлөнө.

Хорооллын талбайд дэвсгэр давхаргын хамгийн бага зузаан нь 1.0м-тэй тэнцүү; зорчих хэсэг буюу гудамж, замын хэсэгт эрдэст шороон дэвсгэр давхаргын зузаан нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний эрчимээс хамаарна.

11.12 Хөрсний нүүлт, гулсалттай нутаг дэвсгэрт байрлах хот, суурины газрын гадаргуу, хөрсний нөхцөл, инженер геологи-гидрогеологийн нөхцөлийг иж бүрэн судалсны үндсэнд гадаргын усны урсацыг зохицуулан урсгах, хөрсний усны урсгалыг зохицуулах, байгалийн гулсалтын хүчний эвдрэл, нуралтаас хамгаалах, байгалийн контрфорс (чулуун хашлага)-ыг хамгаалах, налуугийн тэсвэрлэх чанарыг механик болон физик-химийн хэрэгсэл ашиглан сайржуулан бэхжүүлэх, ногоон суулгац тарихаар тус тус төлөвлөнө.

11.13 Хөрсний элэгдэлтэй гуу жалга үүсэх эрсдэлтэй газарт гадаргын урсацыг цэгцтэй болгож жалганы улыг бэхжүүлэх, налуу газрын энгэр дэнжлэх арга хэмжээг төлөвлөнө. Шаардлагатай тохиолдолд уг жалганд ус урсгуур, шүүрүүл урсгуур төлөвлөнө.

12. Инженерийн хангамж

12.1 Ус хангамж, ариутгах татуурга

12.1.1 Хот, суурины нутаг дэвсгэрийн нийтийн аж ахуйн дэд бүтцийг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг үндэслэн одоо байгаа инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, шинээр төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.

12.1.2 “Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж” /БНБД 40-02-16/, “Ариутгах татуурга.Гадна сүлжээ ба байгууламж” /БНБД 40-01-14/, ”Ус хангамж,ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төсөллөх ба угсрах /БД 40-102-06/, MNS 4990:2015. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”-тай уялдуулан хот, суурин газрын унд-ахуйн ус хангамж, ариутгах татуургын системийг хүрээлэн буй орчин, байгалийн нөөц хамгаалах шаардлага, ариун цэвэр-эрүүл ахуйн найдваршилыг тооцож төлөвлөнө.

Суурьшлийн бүсийн орон сууц ба барилгажсан хэсгүүд, үйлдвэрийн газрууд нь төвлөрсөн болон бие даасан ус хангамж, ариутгах татуургын системтэй байна. Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын системгүй суурьшлын өрөн сууцны бүсэд орон сууцны олон давхар барилга төлөвлөх, байршуулахыг хориглоно.

12.1.3 Унд-ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг эрүүл ахуйн шаардлага, цацраг идэвхжилийн нормыг тооцож улсын эрүүл ахуй-тархвар судлалын хяналтын байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн сонговол зохино.

12.1.4 Ус цэвэршүүлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээ хүчин чадлаас хамаарах эрүүл ахуйн³³ хамгаалалтын бүстэй уялдуулан,тооцоогоор сонгох ба дараах хүснэгтэнд зааснаас ихгүй байна. Үүнд:

Хүснэгт 12.1

Хүчин чадал (мян.м ³ /хон)	Эдэлбэр газар, га
0.8 хүртэл	1.0
0.8-аас дээш 12 хүртэл	2.0
>>12 >>32	3.0

³³ Усны тухай хууль

3.1.10.“эрүүл ахуйн бүс” гэдэгт ус хангамжийн эх үүсвэр болон рашааны ордыг хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг;

3.1.4.“усны сан бүхий газар” гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг;

>>32 >>80	4.0
>>80 >>125	6.0
>>125>>250	12.0
>>250>> 400	18.0
>>400 >> 800	24.0

12.1.5 Ариутгах татуургын Цэвэрлэх³⁴ байгууламжийн эдэлбэр газрын хэмжээ дараах хүснэгт 12.2-т зааснаас ихгүй байна. Үүнд:

Хүснэгт 12.2

Ариутгах татуургын цэвэрлэх байгууламж мян. м ³ /хон	Эдэлбэр газрын хэмжээ,га		
	Цэвэрлэх байгууламж	Лагийн талбай	Гүн цэвэрлэгээний биоцөөрөм
0.1 хүртэл	0.1		
0.1-с дээш »0.2 хүртэл	0.25		
»0.2»0.4	0.4		
» 0.4 »0.8	0.8		
»0.8»17	4.0	3.0	3.0
»17 » 40	6.0	9.0	6.0
»40 » 130	12.0	25.0	20.0
»130 » 175	14.0	30.0	30.0
»175 » 280	18.0	55.0	

Тайлбар:

280 мян.м³/хон-с дээш хүч чадалтай цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг зохих журмын дагуу боловсруулсан тухайлсан зураг төслөөр буюу улсын эрүүл ахуй-тархвар судлалын хяналтын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоовол зохино.

12.1.6 Ариутгах татуургын бие даасан системийн цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газар болон тэдгээрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хөрсний бүтэц, бохир усны зардлаас хамааруулан 0.25 га-аас ихгүй байх ба Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж. /БНБД 40-01-14/-ийн шаардлагад нийцүүлнэ.

12.1.7 Ариутгах татуургын төвлөрсөн системгүй үед улсын эрүүл ахуй-тархвар судлалын хяналтын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр юүлэх станц төлөвлөнө.

12.1.8 Юүлэх станцийн байршлыг Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж. /БНБД 40-01-14/-тэй уялдуулан түүний эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг ~~Байгаль өрчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/А/171 тоот хамтарсан тушаалын 2-р хавсралтын дагуу~~ тогтооно.

Борооны усны ариутгах татуурга

12.1.9 Борооны усны ариутгах татуургын сүлжээг Монгол улсын Усны тухай, Ус хангамж, ариутгах татуургын тухай хууль болон Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж (БНБД 40-01-14) (7.Борооны усны ариутгах татуургын сүлжээ); Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам, талбайгаас бороо, цасны ус зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм, дүрэм (БД 40-302-13) -ийн дагуу төлөвлөнө.

³⁴ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль 3.1.11. "цэвэрлэх байгууламж" гэж бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч цэвэрлэх цогц байгууламжийг;

12.1.10 Борооны усны ариутгах татуургыг нэгдсэн ба салангид систем гэж ангилна.

Гадаргын ус зайлуулах төлөвлөлтөнд *Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж. /БНБД 40-01-14/, Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД40-302-13/ ба MNS 4990:2015 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага"-ыг мөрдөнө.*

Суурьшлийн бүс болон хотын **дүүргүүдээс** цуглуулж, тээвэрлэсэн цас, мөсний бөөгнөрлийг **цэвэрлэхдээ** цас хайлуулах камер, шингэн түлшээр ажилладаг цас хайлуулах хөдөлгөөнт төхөөрөмж болон ариутгах татуургын коллектор дээр байрласан, эрчим хүчний бусад эх үүсвэрээр, тухайлбал урсацын дулааныг ашиглан ажиллуулах цас хайлах бусад аргыг хэрэглэж **гүйцэтгэнэ**. Хаягдал усыг усан орчин, гадаргын усны мөсөн бүрхүүлийн гадаргуу, ус цуглуулах талбай руу урсгахыг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шаардлагын дагуу хориглоно.

12.1.11 Ус зайлуулах хоолойн голч ба сувгийн хэмжээг тодорхойлохдоо БНБД 40-01-14-ийг мөрдлөг болгоно.

12.1.11а Хотын болон хөдөөгийн суурьшлийн нутаг дэвсгэрт хаягдал ус зайлуулах хаалттай шугам сүлжээ төлөвлөнө. Дараах газруудад, **Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-01-14/-ийн зүйл 6.1.6-д** заасан арга хэмжээг хангахыг харгалзан хаягдал ус зайлуулах ил системийг замын огтлолцол дээр гүүрэн гарц буюу хоолой төлөвлөж хийхийг зөвшөөрнө. Үүнд:

-цөөн давхартай барилгажсан **дүүрэг**

-олон давхартай барилгажсан **дүүргийн** гарц [хөндлөн огтлолын талбай багатай (200x200 мм, өргөн*гүн), динамик ачааллыг тооцсон борооны ус хүлээн авах шүүртэй] ба явган зорчигчийн хэсэг

-барилгажаагүй эдэлбэр газар

-хотын суурьшлийн бүсийн гудамж, замын дагуу

Ус зайлуулах ховилын тооцооны урсацыг **Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-01-14/-ийн зүйл 7.1.10-н** шаардлагыг баримтлан тооцно. Борооны усны ил ариутгах татуурга нь байгалийн болон хялбаршуулсан бүтэц бүхий хиймэл гадаргуутай янз бүрийн хэмжээтэй суваг, шуудуунаас бүрдэнэ. Борооны ус хүлээн авах худгийг энэ тохиолдолд хийхгүй .

12.1.12 Газар доорхи ерөнхий коллекторууд, дулааны сүлжээ ба дренажны усыг хүлээн авах боломжийг гадаргын ус зайлуулах системд тооцсон байвал зохино. Борооны усны хүлээн авах худагт зам, талбай, зүлэг услахад зарцуулж байгаа бага хэмжээтэй усны зардлыг тооцохгүй байж болно. Энэ усыг техникийн боломжтой тохиолдолд чимэглэлийн зориулалттай усан орчинд тусдаа хоолойгоор нийлүүлэхийг зөвшөөрнө.

12.1.13 Сүлжээнд орж буй борооны усны тооцооны хамгийн их зардлыг үндэслэн ус зайлуулах хоолойн голч ба сувгийн хэмжээг тодорхойлно. Энэ зардал нь борооны эрчимшил, үргэлжлэх хугацаа, ус цуглуулах талбай ба урсацын коэффициентээс хамаарна.

Хотын нутаг дэвсгэрт ус зайлуулах битүү шугам сүлжээ төлөвлөнө. Ус зайлуулах задгай суваг, шуудууг хоторхуу суурин, хот маягийн суурин, парк, ногоон бүс, замын уулзвар, огтлолцолд зохих норм, дүрмийг баримтлан төлөвлөнө. Ус зайлуулах хоолойны хамгийн бага голч нь 400.0 мм байна.

Тайлбар: 1. Ус зайлуулах ил байгууламжийг авто зам дагуу шуудуу маягаар, цөөн давхартай барилгажсан бүсэд байгуулж болно. 2. Борооны усны ил ариутгах татуурга нь

байгалийн болон хялбаршуулсан бүтэц бүхий хиймэл гадаргуутай янз бүрийн хэмжээтэй суваг, шуудуунаас бүрдэнэ. Энэ тохиолдолд борооны ус хүлээн авах худаг төлөвлөхгүй.

12.1.14 Газар доорхи ерөнхий коллекторууд, дулааны сүлжээ ба дренажны усыг хүлээн авах боломжийг гадаргын ус зайлуулах системд тооцсон байвал зохино. Борооны усны хүлээн авах худагт зам, талбай, зүлэг услахад зарцуулж байгаа бага хэмжээтэй усны зардлыг тооцохгүй байж болно.

12.1.15 Борооны усны ариутгах татуургын сүлжээний тооцоог **Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж** /БНБД 40-01-14/-ийн дагуу гүйцэтгэнэ.

12.1.16 Хотын суурьшлийн бүсээс гарах гадаргын урсац усны цэвэрлэгээг эдийн засгийн үр ашгийг тооцож **“байран”** болон төвлөрсөн цэвэрлэх байгууламжинд³⁵ цэвэрлэнэ. Цэвэрлэгээ хийгдэх борооны усны урсацын тооцоот зардлыг **Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж** /БНБД 40-01-14/-ийн дагуу тодорхойлно. Үйлдвэрийн объектуудын эдэлбэр газар болон орон сууцны ба хотын нийтлэг үйлчилгээний бүсэд байрласан органик ба органик бус гаралтай хортой бодисоор бохирдсон хэсгүүдийн гадаргын урсац усыг хотын сүлжээнд нийлүүлэхээс урьд, үйлдвэрийн эргэлтийн ус хангамжинд дахин ашиглах **боломжтойгоор “байран”** бие даасан цэвэрлэх байгууламжинд цэвэрлэх ёстой.

Хуванцар /полимер/ материалаар үйлдвэрлэсэн **“байран”** цэвэрлэх байгууламжийг төлөвлөхдөө **Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам.** /БД 40-102-06/-ын шаардлагатай уялдуулан төлөвлөнө.

Барилгажсан талбайгаас гаднах гудамж, замын улаан шугамын хязгаарт, тэрчлэн хөдөөгийн суурьшлийн бүсэд цэвэрлэх байгууламж төлөвлөхдөө ГОСТ Р 59205-ын шаардлагыг тооцож төлөвлөнө.

Хот, хөдөөгийн суурины суурьшлын бүсийн эдэлбэр газрын гудамж, замын сүлжээнд **хурын усны** газар доорхи шугам сүлжээ байхгүй тохиолдолд **Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж** /БНБД 40-01-14/ ба СП 396.1325800-н шаардлагыг **удирдамж болгоно.**

12.1.17 Гадаргын ба гүний усыг Усны тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичигт заасан шаардлагын хэмжээнд байлгах нь усны объектод үзүүлэх зөвшөөрөгдөх нөлөөллийн норматив хэмжээг тогтоон, мөрдүүлэх замаар хийгдэнэ.

Усны объектод үзүүлэх зөвшөөрөгдөх нөлөөллийн норматив хэмжээг усны объект дах химийн бодисын концентрацийн зөвшөөрөгдөх хүлцэл, цацраг идэвхит бодис, бичил биетнүүд болон усны бусад чанарын үзүүлэлтийг үндэслэн тогтооно.

Усан орчинд нийлүүлэх хаягдал усанд агуулагдах бодис, бичил биетийн тоо хэмжээ нь усны объектод үзүүлэх зөвшөөрөгдөх нөлөөллийн тогтоосон нормативаас илүү гарах ёсгүй.

Усан орчинд нийлүүлж байгаа гадаргын урсац усны цэвэрлэгээний чанар нь MNS 4943:2015-ын шаардлагыг хангаж байх ёстой.

Хотын бохир усны тооцооны зардлууд, ариутгах татуургын сүлжээний гидравлик тооцоо, хувийн цутгалан, жигд бусын илтгэлцүүрүүд болон тухайлсан объект, байгууламжийн бохир усны тооцооны зардлыг **Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж** /БНБД 40-01-14/-ийн шаардлага ба нутаг дэвсгэрийн инженерийн хамгаалалтын зүй тогтол болох инженерийн гидрологийн тооцооны дагуу тодорхойлоно .

³⁵ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
3.1.11. “цэвэрлэх байгууламж” гэж бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч цэвэрлэх **цогц** байгууламжийг;

Хуванцар Полимер материалаар үйлдвэрлэсэн хоолойн гидравликийн тооцоог Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам. /БД 40-102-06/-ын шаардлагатай уялдуулан гүйцэтгэвэл зохино

12.2 Эрчим хүч

12.2.1 Эрчим хүчний хэрэглээ, эрчим хүчний эх үүсвэрт шаардагдах хүчин чадлыг дараахь байдлаар тодорхойлбол **зохино**: Үүнд: үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууламжийн **хувьд** - одоо ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн мэдүүлгээр, шинээр баригдах, сэргээн босгож байгаа эсвэл ижил төстэй үйлдвэрийн газруудын хувьд зураг төслөөр болон орон нутгийн онцлогийг тусгасан салбарын томсгосон үзүүлэлтээр; ахуйн ба нийтийн хэрэглээний **хувьд** - цахилгаан, дулаан, хийн хангамжийн салбаруудын хүчин төгөлдөр мөрдөж байгаа стандартын дагуу. Цахилгааны хэрэглээний томсгосон үзүүлэлтийг хүснэгт 12.4-ийн дагуу **авахыг** зөвшөөрнө.

Эрчим хүчний хэрэглээний томсгосон үзүүлэлт

Хүснэгт 12.4

Суурьшлийн бүсийн тохижилтын зэрэг	Цахилгааны хэрэглээ, нэг хүнд ноогдох кВт.цаг/жил	Хамгийн их цахилгаан ачаалалаар тооцох, цаг/ жил
Хот:		
- агааржуулагчгүй	1700	5200
- агааржуулагтай	2000	5700
Төвлөрсөн цахилгаан хангамжийн систем - байнгын цахилгаан зуухтай хэрэглэгч бүхий хотууд (хамрах хүрээ 100 %):		
- агааржуулагчгүй	2100	5300
- агааржуулагтай	2400	5800
Суурин: (агааржуулагчгүй):		
- Төвлөрсөн цахилгаан зуухгүй	950	4100
- Төвлөрсөн цахилгаан зуухтай (100% хамрагдсан)	1350	4400
<p>Тайлбар: 1. Эрчим хүчний хэрэглээний хүчин чадлыг тооцох томсгосон үзүүлэлтийг хот, суурины зэрэглэлийг харгалзан дараахи илтгэлцүүрийг хэрэглэнэ: Нийслэл хот: 1.2; Хот: 1.1 ; Суурин: 0.8-0.9</p> <p>Томсгосон үзүүлэлтүүдэд орон сууцны болон олон нийтийн барилга байгууламж, нийтийн аж ахуй, гадна гэрэлтүүлэг, хотын цахилгаан тээвэр (метро байхгүй бол), ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн системийн цахилгааны хэрэглээ орно. 2. Орон сууцны барилгад байнгын цахилгаан зуух ашиглах нөхцөл түүнчлэн амины орон сууц, гэр ахуйн агааржуулалтын системтэй хэрэглэгчдийг талбайн хэмжээнээс хамааруулан Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан төхөөрөмжийг төсөллөх ба угсрах /БД43-102-07/ ба орон сууц, иргэний өлөн нийтийн барилгын төлөвлөлтийн нормын дагуу тооцно.</p>		

Одоо байгаа мөн сэргээн засварлах болон баригдахаар төлөвлөж байгаа байгууламжуудын эрчим хүчний хэтийн төлвийн хэрэгцээнд дүн шинжилгээ хийхдээ **салбарласан ба үргэлжилсэн урт дулааны сүлжээтэй том эрчим хүчтэй** байгууламж (Уур-хийн, хийн турбин төхөөрөмж ба бусад) мөн бага (түгээсэн) эрчим хүчтэй байгууламжид ч гэсэн техник эдийн засгийн үндэслэл тооцоотойгоор эрчим хүчний бие даасан эх үүсвэр, сэргээгдэх эрчим хүчний үүсвэр ба эрчим хүчний **шинэ технологийг** оролцуулж, цахилгаан ба дулааны эрчим хүчний хосолмол үйлдвэрлэгч эх үүсвэрээс шаардлагатай эрчим хүчээр хангахаар **тусгавал зохино**.

Хот, суурин газрын эрчим хүчний хэрэгцээг хүчин чадлаас нь хамааруулан эх үүсвэрийг бага оворын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хосолмол байдлаар ашиглах шийдлийг **төрийн захиргааны төв байгууллагын судалгаа**, зургийн даалгаварыг үндэслэн, тухайн нутаг дэвсгэрийн онцлог, нийгэм эдийн засаг, байгаль орчины үр ашигтай тооцоог үндэслэн төлөвлөж болно.

12.2.2 Хот, суурин газрын цахилгаан хангамжийг бүсийн эрчим хүчний системээс хангахаар тусгавал зохино. Бүсийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдох боломжгүй холбогдсон ч зохисгүй тохиолдолд цахилгаан хангамжийг өөр цахилгаан станцтай байхаар тусгана. Хотын суурьшлын бүсийн цахилгаан хангамж нь харилцан хамааралгүй цахилгааны хоёр эх үүсвэрээс өгөгдөх ёстой.

12.2.3 Ачаалах төвийн ойролцоох үйлдвэрлэл, инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтцийн бүсэд хот, хөдөөгийн суурин газрын нутаг дэвсгэрт шинээр дулааны цахилгаан станц байршуулахыг зөвшөөрнө.

12.2.4 110 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй өндөр хүчдэлийн цахилгааны шугам, түүний дотор дамжин өнгөрөх шугамыг угсрахдаа /10/-р шаардлагыг мөрдөнө. Өндөр хүчдэлийн шугамын коридорын өргөн, түүний ашиглалтын зөвшөөрөгдөх горимыг /32/-т заасны дагуу тодорхойлно.

12.2.5 Орон сууц, нийтийн аж ахуй, амралтын газрын бүс доторх 110 кВ ба түүнээс дээш хүчдэлийн гүний дэд станц хүртэлх цахилгаан шугам сүлжээг /10/-д заасны дагуу хийх ёстой.

12.2.6 Хот суурин газрыг хөгжүүлэхдээ одоо байгаа хот төлөвлөлтийн нөхцөлийг харгалзан 35 кВ-110 кВ ба түүнээс дээш хүчдэлийн агаарын шугамыг орон сууцны болон нийтийн аж ахуйн нэгжийн гадна талд буулгах, эсхүл агаарын шугамыг кабелиар солихыг зөвлөж байна.

12.2.7 Хот болон бусад хүн ам суурьшсан бүс нутгийн бүх нутаг дэвсгэрийн бүсэд дөрвөн давхар буюу түүнээс дээш давхар барилга барихдаа 20 кВ ба түүнээс дээш хүчдэлийн цахилгааны сүлжээг (амралтын бүсэд - бүх хүчдэлийн сүлжээг) кабель шугамаар төлөвлөсөн байх ёстой.

12.2.8 35 кВ хүртэлх хүчдэлтэй дэд станц болон хуваарилах байгууламжийн дуу чимээнээс хамгаалах, арга хэмжээг хангахын тулд орон сууц, олон нийтийн барилгын цонхноос 10 метрээс багагүй зайтай байршуулан төлөвлөнө.

12.2.9 Суурин газрын дулаан хангамжийг төвлөрсөн бус дулаан хангамжийн эх үүсвэрийн **оновчтой хослолтой** эдийн засгийн хувьд хэмнэлттэй эрчим хүчийг харгалзан, тогтоосон журмаар батлагдсан дулаан хангамжийн схемийн дагуу төлөвлөж хангавал зохино. Аж үйлдвэр, орон сууц ба олон нийтийн барилга байгууламжийг дулаанаар хангах зориулалттай дулаан хуваарилах байгууламж ба төхөөрөмжийг аж үйлдвэрийн болон нийтийн үйлчилгээний бүсэд байрлуулна. Аж үйлдвэр, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийг дулаанаар хангах зориулалттай халаалтын зуухыг аж үйлдвэрийн бүсэд байрлуулна.

Олон айлын орон сууцтай цөөхөн давхар бүхий хороололд, мөн эдэлбэр газартай нэг, хоёр орон сууцтай байшингийн дулаан хангамжийг техникийн шаардлагын дагуу байгальд хоргүй, ариун цэвэр-эрүүл ахуй, галын аюулаас хамгаалах дүрмийн шаардлагад нийцсэн бие

даасан дулаан үйлдвэрлэгч халаалтын зуухнаас нэг бүлэг орон сууц, барилга байгууламжийг хангахаар зохицуулж болно. Орон сууцны дунд тусдаа байрласан халаалтын зуухны талбайн хэмжээ нь хүснэгт 12.5-ийн дагуу байна.

Хүснэгт 12.5

Халаалтын зуухны дулаан үйлдвэрлэх хүчин чадал, Гкал/ц (МВт)	Халаалтын зуухны эдэлбэр газрын хэмжээ, га	
	Хатуу түлшээр ажилладаг	Хий-мазут түлшээр ажилладаг
5 хүртэл	0,7	0,7
5-аас » 10 (6-аас 12 хүртэл)	1,0	1,0
10-аас » 50 (12-оос дээш » 58)	2,0	1,5
» 50 » 100 (» 58 » 116)	3,0	2,5
» 100 » 200 (» 116 » 223)	3,7	3,0
» 200 » 400 (» 233 » 466)	4,3	3,5

Тайлбар:

1. Хэрэглэгчдийг хэрэгцээний халуун усаар хангаж байгаа халаалтын зуух, түүнчлэн төмөр замаар түлшний хангалт нь хийгддэг зуухны хувьд талбайн хэмжээг нь 20% хүртэл нэмнэ.
2. Үнс, хаягдал агуулах цэгийг орон сууц, олон нийтийн барилга байгууламж, рекреацийн бүсийн гадна байрлуулна. Үнс, шлак хаягдал агуулах цэг байгуулах нөхцөл болон талбайн хэмжээ нь /БНБД 41-02-03/-ын дагуу байна.
3. Эрүүл ахуй-хамгаалалтын бүсийн хэмжээ нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль - ийн дагуу байна. Хүснэгтэнд зааснаас бусад төрлийн түлшээр ажилладаг зуухны эдэлбэр газрын хэмжээг “Зуухны тоног төхөөрөмж” /БНБД 41-03-13/, ГОСТ Р55006-ын шаардлагатай уялдуулан төлөвлөнө.

12.2.10 /БНБД 44-01-08/-ын шаардлагын дагуу магистральний хийн хоолойн хий хуваарилах станцыг суурин газрын гадна байрлуулна.

Инженерийн дэд бүтцийн бүс дэх суурьшлийн нутаг дэвсгэр дээр байрласан магистральний хийн хоолойн одоо байгаа хий хуваарилах станцын шинэчлэлийг шинэ талбайд шилжүүлэлгүйгээр гүйцэтгэхийг зөвшөөрнө .

12.2.11 Хий цэнэглэх станцын эдэлбэр газрын хэмжээг хүчин чадлаас нь хамааруулан зураг төслийн дагуу тогтоох ба дараах хүснэгтэнд зааснаас ихгүй байна .

Хүснэгт 12.6

Хүч чадал, тн/жил	Эдэлбэр газар, га
10.0 мян	6.0
20.0 мян»»	7.0
40.0 мян»»	8.0

12.2.12 Хий цэнэглэх станц (ХЦС) ба хийн баллоны агуулах (ХБА)-ын талбайн хэмжээг 0.6 га-гаас ихгүй байхаар тооцно. Тэдгээрээс төрөл бүрийн зориулалттай барилга хүртэлх зайг БНБД 42-01-04-ын дагуу тогтооно.

12.2.13 Үйлдвэрийн газруудын байршил, холбооны барилга байгууламжууд, радио телевиз, галын ба хамгаалалтын дохиолол, инженерийн тоног төхөөрөмжийн системийн диспетчержүүлэлтийг тогтоосон журамаар батлагдсан нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

12.2.14 Хий цэнэглэх станц ба хийн баллоны агуулахаас аливаа барилга, байгууламж хүртэлх зайг техникийн шаардлагыг тусгасан журмын дагуу тогтооно.

1.2.14а Хот, хөдөөгийн суурины нутаг дэвсгэрт “ЛКС ТМК”³⁶-г зүлэг, дугуйн замын доор ГЗС-ний ногоон бүс буюу автозамын хажуугийн **бэхлэгдсэн хэсэгт** байрлуулахаар төлөвлөнө.

Инженерийн шугам сүлжээний байршил

12.2.15³⁷. Газар доорхи инженерийн шугам сүлжээг гудамж, замын хөндлөн огтлолын хязгаарт, явган хүний замын доор, эсвэл тусгаарлах зурваст дараах байдлаар байрлуулна.

СП 42, 12.33 Үүнд:

- Авто ба явган зорчигчийн зам, түүний тусгаарлах зурвас доор инженерийн шугам сүлжээг траншей, суваг буюу хонгил дотор (нэвтрэх сувагт)
- Тусгаарлах зурваст ахуйн болон хурын усны шугам, үерийн усны шугам, хөрсний ус зайлуулах шугам хоолойг
- Улаан шугам ба барилгажилтын бүсийн хоорондох зурваст нам болон дунд даралтын хийн сүлжээ ба кабель (хүчний, холбооны, дохиоллын, диспетчерийн) шугамуудыг байрлуулбал зохино

Гудамж, замын зорчих хэсгийн өргөн нь 22.0 м-ээс их үед цэвэр усны шугамыг гудамжны хоёр талд байрлуулахаар төлөвлөнө.

Хатуу хучилттай гудамж, замын зорчих хэсгийг өргөтгөх, шинэчлэн засварлахдаа түүн доор байрлаж буй инженерийн шугам сүлжээг тусгаарлах зурвас болон явган хүний замын доор шилжүүлэн байрлуулахаар төлөвлөнө. Хамгаалалтын бүтээц (тоннель, суваг, коллектор, ган гэр хоолой г.м) хийж, барилга-угсралтын ажлыг далд аргаар гүйцэтгэх үед гудамжны зорчих хэсгийн доор одоо байгаа шугам сүлжээг хэвээр нь байлгах, **шинэ сүлжээ** тавихыг зөвшөөрнө. **СП 42, 12.33**

Зай, талбай багатай давчуу нөхцөлд хамгаалалтын бүтээц (тоннель, суваг, коллектор, ган гэр хоолой, төмөр бетон гильз г.м) хийсэн тохиолдолд одоо байгаа шугам сүлжээг зорчих хэсгийн ба замын хашлага доор хэвээр нь байлгахыг зөвшөөрнө.

Хот ба хөдөөгийн суурьшлийн бүсэд гудамж, зам, зөрлөгийн барилга-угсралт, шинэчлэх болон тэдгээрийн их засварын үед зорчих хэсгийн доор байрласан инженерийн шугам сүлжээг хэвээр нь хадгалахыг зөвшөөрнө. Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүтээцийг барих, зөөж шилжүүлэх шаардлагыг төлөвлөлтөөр тодорхойлно.

12.2.16 Зайлшгүй нэг зэрэг байрлуулах шаардлагатай дулааны шугам, кабель (10кВ хүртэл хүчдэлтэй хүчний болон холбооны кабель), тэрчлэн гол гудамж ба төмөр замын огтлолцол дээр газар доорхи инженерийн шугам сүлжээг тоннель (нэвтрэх суваг)-д байрлуулвал зохино. Ослын албадмал агааржуулалт ба хийн бохирдлыг хянах төхөөрөмжгүйгээр амархан гал авалцах, хортой ба шатамхай бодис тээвэрлэж буй хоолойг тоннель (коллектор)-д тавихыг хориглоно. Түүхэн дурсгалт барилгажилтын бүсэд сэргээн засах ажил явуулах болон гудамжны өргөн хангалтгүй үед дулааны шугамын диаметр 200.0 мм-с тоннель (коллектор)-д **хийхийг** зөвшөөрнө.

Олон жилийн цэвдэг хөрстэй бүсэд, хөрсний цэвдгийг хөндөхгүйгээр барилгын ажил явуулахдаа дулааны шугамыг диаметрээс нь үл хамааран тоннельд байрлуулвал зохино.

Хөрсний төвөгтэй нөхцөл (суулттай, **химэрлэгт** ул хөрс)-тэй барилгажилтын хэсэгт “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” /БНБД 23-01-09/, “Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж” /БНБД 40-01-14/ ба Дулааны сүлжээ /БНБД 41-02-13/

³⁶ Линейно-кабельные сооружения транспортной многоканальной коммуникации (ЛКС ТМК): Тээврийн олон сувгийн сүлжээний шугаман-кабелийн байгууламж

³⁷ Орос хувилбарт нь энэ хэсэгт бага зэргийн өөрчлөлт орсон байгаа ч хэвээр нь үлдээлээ

-тэй уялдуулан инженерийн шугам сүлжээг дүрмийн дагуу **тоннель /хонгил/-д** байрлуулна. Шугам сүлжээний хонгилын төлөвлөлтөнд **“Хонгилын систем” /БНБД 44-04-21/-ийг** мөрдөнө.

Тайлбар: Хот байгуулалтын онцгой зохицуулалттай бүсэд жичэд нь дулааны шугамыг газар доор тавих боломжгүй үед буюу түр зуурын шийдлээр газар дээр тавихыг зөвшөөрнө.

12.2.17 Газар доорх инженерийн шугам сүлжээнээс (гадаргуугаас гадаргууд) барилга, байгууламж хүртэлх зай хэмжээг хүснэгт 12.7-д зааснаар төлөвлөнө. Газар доорх (газар дээр овоолгонд) хий дамжуулах сүлжээнээс (гадаргуугаас гадаргууд)) барилга, байгууламж хүртэлх зай хэмжээг Хийн хангамж /БНБД 42-01-19/, **дулааны сүлжээнээс** Дулааны сүлжээ. /БНБД 41-02-13/ -тэй **уялдуулан авна.**

Шугам сүлжээний коллекторт инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд **тавих шаардлагыг** СП-265.1325800-н дагуу **авна** **“Хонгилын систем” /БНБД 44-04-21/-ийг** мөрдөнө

Хүснэгт 12.7

Инженерийн шугам сүлжээ	Газар доорх шугам сүлжээнээс (хэвтээгээр) барилга байгууламж хүртэл /м/								
	Барилга, байгууламжийн суурь хүртэл	Төмөр замын холбоо ба контактын шугамын тулгуур, эстакад, хашлагын суурь хүртэл	Гадна замын тэнхлэг		Гудамж, замын ирмэг хүртэл /зорчих хэсгийн ирмэг ба замын хажуугийн бөхлөгдсэн зурвас/	Шуудууны гадна ирмэг буюу замын асгаасны үл хвотөл	ЦДАШ-ын тулгуурын суурь хүртэл, хүчдэлтэй		
			1520 мм царигтай төмөр зам хүртэл /далан ба ухлагын ирмэг хүртэлх траншейны гүнээс багагүй/	750 мм царигтай төмөр зам ба трамвайны зам хүртэл			1 кВ хүртэлх хүчдэлтэй гадна гэрэлтүүлэг, троллейбус, трамвайны контактын шугам	1 кВ-с дээш 35 кВ хүртэл	35 кВ-с дээш 110 кВ хүртэл ба түүнээс дээш
0.	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
Цэвэр усны ба ариутгах татуургын даралттай шугам	5 /тайлбар 7/	3* ⁶	4	2.8	2**	1**	1	2	3
Өөрийн урсгалтай ариутгах татуургын шугам /ахуйн ба борооны усны/	3 /тайлбар 7/	1.5* ⁶	4	2.8	1.5**	1**	1	2	3
Дренаж	2 /тайлбар 7/	1	4	2.8	1**	1**	0.5	2	3
Дагах дренаж	0.4	0.4	0.4	0	0.4				
Шатамхай хийн хий дамжуулах хоолой. Үүнд: а/ 0.005 МПа хүртэлх нам даралтын б/ 0.005-0.3 МПа хүртэл дунд даралтын в/ 0.3-0.6 МПа хүртэл өндөр даралтын г/ 0.6-1.2 МПа хүртэл өндөр даралтын	БНБД 42-01-21 Хавсралт В; хүснэгт В1								

Хот, суурины төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /30-01-24/							2024 он			
/байгалийн хийг оруулан/ 0.6-1.6 МПа хүртэл /Шингэрүүлсэн нефтийн хийг оруулан /										
Дулааны шугам сүлжээ /дулааны хоолой***/	БНБД 41-02-13 Хавсралт А									
Бүх хүчдлийн хүчний кабель,холбооны кабель, кабелийн сувагжуулалт	0.6	0.5	3.25	2.75	1.5* ⁴	1* ⁴	1*	5*	10*	
Суваг,туннель,шугам сүлжээний коллектор	2	1.5	4	2.75	1.5	1	1	2	3	
ЛКС ТМК*5	0.5	0.5	3.25	2.75	0.5	0.5	0.5	0.5	0.5	
Гадна хог дамжуулах хийн шахалтат хоолой	2	1	3.8	2.8	1.5	1	1	3	5	
<p>* Зөвхөн хүчний кабелиас баримтлах зайнд хамаарна.</p> <p>** Хоолойг хөлдөлт ба механик гэмтлээс хамгаалах арга хэмжээ /гэр хоолой,гильз/ авсан төлөвлөсөн нөхцөлд хоолойноос гудамж, замын ирмэг /зорчих хэсгийн ирмэг ба замын хажуугийн бэхлэгдсэн зурвас/ хүртэлх зайг 0.3 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө.</p> <p>*** Үйлдвэрийн объектад дулааны хоолойг суваггүй тавьсан үед дулаалгийн гаднаас барилга, байгууламж хүртэлх зайг 2 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө.</p> <p>*⁴ Кабелийг механик гэмтлээс хамгаалсан арга хэмжээ /хоолойд сүвлэх,хавтан тавих г.м/ авсан нөхцөлд хүчний кабелиас гудамж, замын ирмэг /зорчих хэсгийн ирмэг ба замын хажуугийн бэхлэгдсэн зурвас/ хүртэлх зайг 0.7 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө.</p> <p>*⁵ Зай талбай давчуу нөхцөлд заасан утгуудыг 0.1 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө.</p> <p>*⁶ Троллейбус,трамвайны контактын шугамын тулгуурын суурьнаас цэвэр усны ба даралттай бохирын шугам хүртэлх зайг 0.5 метр хүртэл багасгахыг хамгаалалтын арга хэмжээ /хоолой хоорондын орон зайг цутгамал төмөр бетоноор дүүргэсэн хамгаалалтын гэр хоолой хийх г.м/ авсан нөхцөлд зөвшөөрнө.</p>										
<p>1.Найдваршилын аюулгүй байдлын шаардлагыг хангасан техникийн компенсацлах арга хэмжээг [гагнаасан холбоос ба хамгаалалтын гэр хоолойн үл эвдрэх 100%-н хяналт, ойролцоох барилга, байгууламжийн бүрэн бүтэн байдал, залгаасан холбоосны ус үл нэвтрэлтийг хангах, худгийн хана (камер) ба хоолой хоорондын зайг бин битүү чигжих, ус тусгаарлалт хийх, хамгаалалтын хийцийг (төмөр бетон суваг, гэр хоолой) хэрэглэх г.м] биелүүлсэн тохиолдолд заагдсан зайг багасгахыг зөвшөөрнө.</p> <p>СП 131.13330-н дагуу цаг уурын IA,IB,IG ба ID дэд бүсэд олон жилийн мөнх цэвдэг хөрсийг хэвээр хадгалан барилга барих үед газар доорхи шугам сүлжээнээс / цэвэр ус,ахуйн ба борооны усны ариутгах татуургын шугам, дулааны сүлжээ / баримтлах зайг тооцоогоор авбал зохино.</p> <p>2.Барилгын суурь суусан тохиолдолд шугам сүлжээг гэмтээхгүй байх ,мөн эдгээр шугам сүлжээн дээр осол гарсан үед суурийг гэмтэхээс хамгаалсан арга хэмжээ авсан нөхцөлд барилга, байгууламжийн суурь,хоолойн тулгуур, стакад, контактний сүлжээний хязгаарт газар доорхи инженерийн шугам сүлжээг тавихыг зөвшөөрнө.</p> <p>Усны түвшинг бууруулах арга хэмжээг авч инженерийн шугам сүлжээг угсрах тохиолдолд барилга байгууламж хүртэлх зайг суурийн бат бэх болон хийцэд нөлөөлөхгүй байхаар тооцсон байна</p> <p>3.Суваггүй тавьсан дулааны сүлжээнээс барилга,байгууламж хүртэлх зайг БНБД 41-02-13-н хүснэгт 8.3-н дагуу тооцоно.</p> <p>Барилга, байгууламжийн аюулгүй байдал, дулааны сүлжээний осолгүй ажиллагааг хангасан компенсацлах арга хэмжээг гүйцэтгэсэн нөхцөлд газар дээр тавьсан дулааны сүлжээнээс барилга,байгууламжийн суурь хүртэлх норматив зай хэмжээг багасгахыг зөвшөөрнө. Дулааны сүлжээний аюулгүй ажиллагаа түүнд засвар, үйлчилгээхийг боломжийг хангасан арга хэмжээг биелүүлсэн нөхцөлд дулааны сүлжээнээс орон нутгийн замуудын ирмэг хүртэлх зай хэмжээг багасгахыг зөвшөөрнө.</p> <p>“4.110-220 кВ хүчдэлтэй хүчний кабелиас холбоо ба контактны шугамын тулгуур, эстакад, хашлагын суурь хүртэлх” зайг 1.5 м-ээр авбал зохино. Кабель шугам өнгөрөх газарт дулааны сүлжээнээс ирэх хөрсний нэмэлт халалтын температур нь жилийн аль ч улиралд 10 кВ хүртэлх кабель шугаманд 10⁰-с, 20-220 кВ шугаманд 5⁰-с дээшгүй байх нөхцөлийг хангасан дулаан тусгаарлалтын зөвлөмжийг биелүүлсэн тохиолдолд дулааны сүлжээ ба бүх хүчдлийн хүчний кабель 0.5 м хүртэл ойртоход дурдсан зайг багасгахыг зөвшөөрнө.</p>										

5. 20.0 м-ээс бага гүнд байрласан метроны газар доорх байгууламжийн ширэм, төмөр бетон болон наалдамхай ус тусгаарлагчтай бетон доторлогооноос (доторлогооны дээд талаас газрын гадарга хүртэл) хэвтээ чиглэл дэх зайг ариутгах татуурга ба ус хангамжийн сүлжээ, дулааны сүлжээ хүртэл

5.0 м; наалдамхай ус тусгаарлагчгүй доторлогооноос ариутгах татуургын сүлжээ хүртэл 6 м байна. Хамгаалалтын арга хэмжээ (хүчитгэсэн ус тусгаарлагчтай бин битүү гэр хоолой) авсан тохиолдолд заагдсан зайг 1.5 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө. Гэр хоолой нь тухайн байгууламжийн доторлогооны хязгаараас хоёр тал руу 5.0 метрээс багагүй урттай гарсан байх ёстой. Доторлогооноос кабель хүртэлх зай 10 кВ хүртэл хүчдэлтэй бол 1.0 метр; 35 кВ хүртэл бол 3.0 м байна.

6. Усалгаатай бүсэд, суултгүй хөрсөнд газар доорхи инженерийн шугам сүлжээнээс усалгааны суваг /сүвгийн ирмэг/ хүртэлх зай:

Нам ба дунд даралтын хий дамжуулах хоолой, цэвэр усны ба ариутгах татуургын шугам, ус зайлуулах ба шатамхай шингэний хоолойноос 1.0 м; 0.6 МПа хүртэлх өндөр даралтын хий дамжуулах хоолой, ахуйн ба борооны усны ариутгах татуурга, хүчний ба холбооны кабелиас 1.5 м гудамжны услалтын сувгаас барилга, байгууламжийн суурь хүртэл 5.0 м байна.

7. Барилгын суурийг усанд автах, угаагдахаас хамгаалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн үед

барилгын гадна хийцнээс (бүтээцийн хооронд хэвтээ чиглэлд) цэвэр усны хоолой хүртэлх зайг 3.0 м хүртэл, бохир усны хоолой хүртэлх зайг 1 метр хүртэл багасгаж болно. Цэвэр ба бохир усны хоолойг суурийн дагуу, түүнтэй хийцийн хувьд холбогдсон, сууринд ойрхон төмөр бетон хайрцаг, гэрэнд тавих боломжтой бөгөөд ингэхдээ БНБД 40-05-16-н дагуу бохир усны хоолойд цэвэрлэгээ хийх төхөөрөмж хийж өгнө. Цэвэр усны хоолойг мөн барилгын суурьтай хийцийн хувьд холбогдсон суваг тавихыг зөвшөөрнө.

Гудамж, замын хийцэнд ордог ус зайлуулах ил (ховил, суваг г.м) байгууламжаас баримтлах зайг СП 34.13330.2021, зүйл 7.59-7.65-н дагуу тооцоно.

8. Ус хангамж, ариутгах татуургын хоолойг тавихдаа хашлага, эстакадны суурийг хамгаалах компенсацлах арга хэмжээ (гэр хоолой, суваг, гильз г.м) авсан бол цэвэр ба бохир усны хоолой хүртэлх зайг 0.5 метр хүртэл багасгаж болно. Зорчих хэсгийн дагуу зэрэгцээ тавигдсан, борооны усны нэгдсэн шүүр, хяналтын үзлэгийн худагтай борооны усны сүлжээний хоолойноос хэвтээ чиглэлд замын хашлага хүртэлх норматив зайг багасгах, орон зай давчуу нөхцөлд борооны усны сүлжээг хамгаалалтын хийцэнд (ган ба төмөр бетон бортог г.м) хийж замын хашлага доор тавих, борооны усны сүлжээг эстакадны хийцэнд 1.0 м хүртэл ойртуулахыг зөвшөөрнө.

9. Холбооны кабелиас баримтлах зайг СП 76.13330-н, үйлдвэрийн объектын хувьд СП 18.13330-н шаардлагатай тус тус уялдуулах ёстой.

10. Найдваршиллын аюулгүй байдлын шаардлагыг хангасан техникийн компенсацлах арга хэмжээг [гагнаасан холбоос ба хамгаалалтын гэрэвч хоолойн үл эвдрэх 100%-н хяналт, ойролцоох барилга, байгууламжийн бүрэн бүтэн байдал, залгаасан холбоосны ус үл нэвтрэлтийг хангах, худгийн хана (камер) ба хоолой хоорондын зайг бин битүү чигжих, ус тусгаарлалт хийх, хамгаалалтын хийцийг (төмөр бетон суваг, бортог) хэрэглэх г.м] биелүүлсэн тохиолдолд заагдсан зайг багасгахыг зөвшөөрнө.

12.2.16 Газар доорхи инженерийн шугам сүлжээнүүд зэрэгцээ байрласан үед тэдгээрийн хоорондын зайг хэвтээ чиглэлд (гадаргуугаас гадаргууд) хүснэгт 12.6-д зааснаар төлөвлөх ба хөдөөгийн суурины барилгын инженерийн сүлжээний оролтон дээр 0.5 метрээс багагүй байхаар төлөвлөнө. авна.

Газар доорх (газар дээр овоолгонд) хий дамжуулах сүлжээнээс (гадаргуугаас гадаргууд) инженер-техникийн хангамжийн сүлжээ хүртэлх зай хэмжээг Хийн хангамж /БНБД 42-01-21/; дулааны сүлжээнээс Дулааны сүлжээ /БНБД 41-02-13/ -тэй уялдуулан авна

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, найдвартай нөхцөл, техникийн зохих арга хэмжээг хэрэгжүүлэн хангасан тохиолдолд хүснэгт 12.7 ба 12.8-д заасан зай хэмжээг үзүүлсэн зайг бууруулахыг авахыг зөвшөөрнө. Эдгээр арга хэмжээнд бортог, гэр хоолой, бүтээцийн хүчитгэл, шугам сүлжээний суваг, тоннель, коллекторын хүчитгэсэн ус тусгаарлалт, суурийн нэмэлт ус тусгаарлалтын арга хэмжээнүүд орно.

Инженерийн шугам сүлжээ босоо чиглэлд огтлолцож байгаа үед тэдгээрийн хоорондох зайг **Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө** /БНБД 30-02-07/-ний дагуу тооцож төлөвлөнө.

12.2.18 **Метрополитены** байгууламжтай инженерийн шугам сүлжээ огтлолцох өнцгийг 90° байхаар тооцох ба засвар үйлчилгээ хийх зориулалтаар огтлолцолын өнцгийг 60° хүртэл багасгаж болно.

Зай, талбай бага давчуу нөхцөлд инженерийн шугам сүлжээг хамгаалалтын цутгамал төмөрбетон бүтээц буюу гэр хоолойд (хоолой хоорондын орон зайг элс-цементэн зуурмагаар дүүргэнэ) хийх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бол огтлолцох өнцгийг 30° хүртэл бууруулахыг зөвшөөрнө.

Хүснэгт 12.8

Инженерийн шугам сүлжээ	Хэвтээ чиглэлд, доорхи шугам сүлжээ хүртэлх зай хэмжээ, м												
	Цэвэр усны шугам	Ахуйн бохир усны шугам	Дренаж ба борооны усны шугам	Шатамхай хий дамжуулах хоолой				Бүх төрлийн хүчдэлтэй хүчний кабель	Холбооны кабель	Дулааны сүлжээ, дулааны хоолой		Гадна хог дамжуулах хийн шахалтат хоолой	
				0.005 МПа хүртэлх нам даралтын	0.005 МПа - 0.3 МПа хүртэлх дунд даралтын	0.3 МПа - 0.6 МПа хүртэлх өндөр даралтын	0.6 МПа - 1.2 МПа хүртэлх өндөр даралтын/байгалийн хий/, 0.6 - 1.6 МПа хүртэл /ШНХ/			Суваг, туннелийн гадна хана	Суваггүй тавилтын гадна бүрхүүл		Суваг, тоннель
Цэвэр усны шугам	1.5 Тбр1	Тбр2	1.5	БНБД 42-01-21 Хавсралт В Хүснэгт В.1				1*	0.5	1.5	1.5	1.5	1
Ахуйн бохир усны шугам	Тбр 1;2;3	0.4	0.4	БНБД 42-01-21 Хавсралт В Хүснэгт В.1				1*	0.5	0.5	1	1	1
Борооны усны шугам	Тбр 2;3	0.4	0.4	БНБД 42-01-21 Хавсралт В Хүснэгт В.1				1*	0.5	1	1	1	1
Шатамхай хийн хий дамжуулах хоолой. Үүнд: а/ 0.005 МПа хүртэлх нам даралтын б/ 0.005 - 0.3 МПа хүртэл дунд даралтын в/ 0.3 - 0.6 МПа хүртэл өндөр даралтын г/ 0.6 - 1.2 МПа хүртэл өндөр даралтын /байгалийн хийг оруулан/ 0.6-с дээш 1.6 МПа хүртэл /Шингэрүүлсэн нефтийн хийг оруулан/	БНБД 42-01-21 Хавсралт В; хүснэгт В1												
Бүх төрлийн хүчдэлтэй хүчний кабель	1*	1*	1*	БНБД 42-01-21 Хавсралт В; Хүснэгт В1				0.1- 0.3*	0.5	1	1	1	1.5

Хот, суурины төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /30-01-24/								2024 он					
Холбооны кабель, кабелийн сувагжуулалт	0.5	0.5	0.5	БНБД 42-01-21 Хавсралт В; Хүснэгт В1				0.5		1	1	1	1
Дулааны шугам сүлжээ /дулааны хоолой***/	"БНБД 41-02-13 Хавсралт 8;9												
Суваг, туннель, шугам сүлжээний коллектор	1.5 Тбр3	1 Тбр3	1	2	2	2	4	1	0.5	"БНБД 41-02-13 Хавсралт 8;9		1	
Гадна хог дамжуулах хийн шахалтат хоолой	1	1	1	БНБД 42-01-21 Хавсралт В; Хүснэгт В1				1.5	1		1		
ЛКС ТМК*5	0.5	0.5	0.5	1				0.1	0.1	1	0.5	0.5	

* Нүүрсний уурхайд [34] –ийн төрөл бүрийн хүчдэлтэй кабелийн хувьд [10-н ,зүйл 2.3.86] -ийн шаардлагатай **зохицуулан авна**

** Зай талбай давчуу нөхцөлд заасан утгуудыг 0.1 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө.

Тайлбар:

1.Ус дамжуулах хэд хэдэн шугамыг зэрэгцээ тавихдаа тэдгээрийн хоорондын зайг техникийн болон инженер-геологийн нөхцөлөөс хамааруулан БНБД 40-02-16-тай **зохицуулан авна**

2.Компенсацлах арга хэмжээ (гэр хоолой, суваг, бортог г.м) байхгүй үед ахуйн бохир усны хоолойноос цэвэр усны шугам хүртэлх зайг 1.5 метрээс багагүй байхаар **авна**. Ус үл нэвтрүүлэх материалаар хийгдсэн хоолойд (төмөр бетон, хризотилцементэн г.м) ослын үед тэдгээрт бохир ус орохоос сэргийлж ус тусгаарлалт хийвэл зохино.

3.Суваггүй тавьсан цэвэр усны (ариутгах татуургын) сүлжээнээс суваг,тоннелийн гадна хана хүртэлх зайг барилга-угсралт, засвар-үйлчилгээний ажил гүйцэтгэх боломжийг хангахыг тооцон 0.5 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө. Зайлшгүй шаардлагатай арга хэмжээнүүд нь (хоолойг хиймэл буурь, суурь, гэр хоолой, шугам сүлжээний коллекторт тавих, цэвэр усны хоолойг дулаалах г.м) цэвэр, бохир усны болон бусад инженерийн шугам сүлжээ, суваг, тоннелийг гэмтээхгүй байх ёстой.

4.Найдваршилын аюулгүй байдлын шаардлагыг хангасан техникийн компенсацлах арга хэмжээг [гагнаасан холбоос ба хамгаалалтын гэрэвч хоолойн үл эвдрэх 100%-н хяналт, ойролцоох барилга, байгууламжийн бүрэн бүтэн байдал, залгаасан холбоосны ус үл нэвтрэлтийг хангах, худгийн хана (камер) ба хоолой хоорондын зайг **бин битүү** чигжих, ус тусгаарлалт хийх, хамгаалалтын хийцийг хэрэглэх г.м] биелүүлсэн тохиолдолд заагдсан зайг багасгахыг зөвшөөрнө (төмөр бетон суваг, гэр хоолой) хэрэглэх г.м] биелүүлсэн тохиолдолд заагдсан зайг багасгахыг зөвшөөрнө.

Огтлолцож буй хэсэгт шугам хоолойнууд нэг тийшээ налуутай байж хамгаалалтын бүтээцэд (ган футляр, цутгамал ба угсармал төмөр бетон суваг, коллектор, нэврэх суваг) хийгдсэн байвал зохино. **Тоннель доогуур** хийн хоолой тавихыг хориглоно.

Газар доорхи шугам сүлжээтэй огтлолцож буй хэсэгт хий дамжуулах хоолойг хамгаалалтын гэр хоолойд тавихдаа БНБД 42-01-21 “Хийн хангамж ”-ийн зүйл 5.5.1-ийн шаардлагыг удирдлага болговол зохино.

Метрополитены байгууламжийн доторлогооны гадна гадаргуунаас цэвэр усны хоолой, ахуйн ба борооны усны ариутгах татуургын инженерийн сүлжээний хамгаалалтын бүтээц хүртэлх зайг хүснэгт 12.5-ын 5-р тайлбарын шаардлагатай уялдуулан цутгамал төмөрбетон буюу ган бүтээцэн хамгаалалт (хоолой хоорондын орон зайг элс-цементэн зуурмагаар дүүргэнэ) хийсэн тохиолдолд 50% хүртэл багасгахыг зөвшөөрнө .

12.2.18 Инженерийн шугам сүлжээ метрополитены газар дээрхи шугамын доогуур гарах бол метрополитеныг төлөвлөх норм,дүрмийн шаардлагатай уялдуулна .Ингэхдээ инженерийн шугам сүлжээг метрополитены газар дээрх байгууламжийн хашлаганаас 3 метрээс багагүй зайд гаргасан байна.

Тайлбар: 1. Газраас 20.0м болон түүнээс доош гүнд метрополитены байгууламж байрласан газар (бүтээцээс газрын гадаргуу хүртэл), түүнчлэн метрополитены байгууламж болон инженерийн сүлжээний хамгаалалтын бүтээц хоёрын хооронд 6.0м зузаан шаварны

оршоос, хагаралгүй хад эсвэл хадархуу хөрс байвал метрополитены байгууламж ба инженерийн сүлжээ хоорондын огтлолцолд дээрх шаардлагыг тавихгүй, хамгаалалтын

бүтээц шаардаггүй. 2. Метрополитенын байгууламжтай огтлолцох үед даралттай хоолойг ган хоолойгоор хийж хоёр талд нь зохих хаалт,арматур бүхий ус нэвтрүүлэх худаг хийнэ .

12.2.19 Газар доорх инженерийн шугам сүлжээ явган хүний гарцтай огтлолцох үед хоолойнуудыг хонгилын системд төлөвлөх ба хүчний болон холбооны кабель шугамыг хонгилын дээр байрлуулбал зохино .

12.2.20 Суурьшлын болон Орон сууцны ба хотын нийтлэг үйлчилгээ, нөхөн сэргээх амрах зориулалтын амралт, зугаалгын бүсэд үйлдвэр объектууд, агуулахын барилга, байгууламжийг хангах зорилгоор амархан гал авалцах ба шатамхай шингэнтэй мөн шингэрүүлсэн хийтэй хоолойг **тавихыг** зөвшөөрөхгүй. Магистральнай ба арилжааны дамжуулах хоолойг суурьшлын бүсийн гадна **БНБД 34-01-22** “Төв дамжуулах хоолой (Магистраль)” СП284.1325800-н шаардлагатай **уялдуулж төлөвлөнө. —тавибал зөхино.** Нефтийн бүтээгдэхүүн дамжуулах хоолойг суурьшлийн бүсэд тавих бол СП125.13330-ыг удирдлага болгоно. **Хүн ам оршин суудаг газрын** хилд ордог **одоо байгаа гол хоолойн** сэргээн шинэчлэх ажлыг гүйцэтгэхдээ СП 36.13330-н шаардлагыг мөрдөнө. **удирдлага болговол зохино.**

12.2.21 Барилга, байгууламжийн суурин доор, мөн **метрополитены**³⁸ тоннелийн доор хий дамжуулах **хоолойг тавихыг** зөвшөөрөхгүй. Хий дамжуулах хоолойг “Хийн хангамж” /БНБД 42-01-21/-ийн шаардлагын дагуу төлөвлөнө. **тавина.**

12.2.22 **Хавтгай объектын** доор (автомашини ил зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, амрах, салхилах талбай, хатуу хог хаягдлын чингэлэгийн талбай г.м) **шинээр ба ажиллаж** байгаа инженерийн шугам сүлжээг шинэчлэн тавихдаа шугам хоолойг **дээрээс ирэх ачааллаас хамгаалсан арга хэмжээг** (бат бэхийн тооцоон дээр үндэсэлсэн) урьдчилан төлөвлөх ба тухайн **хавтгай объектын** (авто зогсоолоос бусад) **хилийн** гадна хяналтын **засвар үйлчилгээний** худаг, камер **байрлуулна.**

Шинээр ба ажиллаж байгаа дулаан, хийн хангамжийн шугам сүлжээг шинэчлэн тавихдаа тэдгээрийг хүүхдийн тоглоомын талбай, спортын талбай, амрах, салхилах талбайн гадна төлөвлөнө. **тавина .**

12.3 Мэдээлэл, харилцаа холбоо³⁹

Хот, суурины мэдээлэл, харилцаа холбооны төлөвлөлтөнд дараахи эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэл болгоно. Үүнд:

- Монгол улсын Харилцаа холбооны тухай хууль Радио долгионы тухай хууль;
- Шуудангийн тухай хууль ;
- Монгол улсын мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын үзэл баримтлал;
- “Мэдээлэл холбооны суурин сүлжээнд шилэн кабелийн бичил хоолойн сувагчлал суурилуулах ерөнхий шаардлага” MNS 6589:2016;
- “Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц” MNS6528:2015;
- “Авто зам, төмөр зам, хөндлөн гарах болон гүүрэн байгууламжид холбооны кабель шугамыг суурилуулах ерөнхий шаардлага MNS 6597:2016;
- “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага” MNS 6423:2013;
- “Харилцаа холбооны цамхаг байгуулахад тавих ерөнхий шаардлага” MNS 5884:2016;
- “Барилгын зураг. Мэдээлэл, холбоо-дохиоллын тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ” MNS 5532:2016;
-

³⁸

Харилцаа холбооны тухай хууль

³⁹ 3.1.10.”харилцаа холбоо” гэж цахилгаан холбоо, радио телевиз, шуудан, мэдээллийн технологийн бүх төрийг;

- Мэдээлэл холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ” MNS 4908:2017 стандартууд, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний төлөвлөлттэй холбогдол бүхий бусад дүрэм, журам, заавар.

13.4.1 Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний төлөвлөлтөнд цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн технологийн төлөвлөлтийг хамруулна.

13.4.2 Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг зориулалтаар нь нийтийн үйлчилгээний болон дотоодын⁴⁰, тусгай хэрэглээний сүлжээ гэж гэж ангилж төлөвлөнө.

13.4.3 Цахилгаан холбооны үндсэн сүлжээ⁴¹ нь нийтийн үйлчилгээнд зориулсан улс, хот, суурин хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бүрдэнэ.

13.4.4 Тусгай хэрэглээний сүлжээнд Монгол Улсын батлан хамгаалах, Иргэний нисэх, төмөр зам, аюулгүй байдлыг хангах, иргэний хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээний холбооны сүлжээ хамаарна.

13.4.5 Дотоодын хэрэглээний сүлжээнд аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын хэрэглээний холбооны сүлжээ хамаарна.

13.4.6 Мэдээлэл, харилцаа холбооны төлөвлөлтөнд радио, телевизийн нэвтрүүлэх станцын болон долгион үүсгэх тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааруулан тогтоосон эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг мөрдөнө. Үүнд:

- агаарын баганат шугамаас тал бүртээ 10 метр;
- кабелийн шугамаас тал бүртээ 5 метр;
- радио релейн шугамын станц хоорондын буюу сансрын холбооны хиймэл

дагуулын газрын нэвтрүүлэх станцын долгион цацалтын орон зай, тухайн станцаас тал бүртээ 300 метр байхаар тооцож тус тус төлөвлөнө

⁴⁰ **21 дүгээр зүйл.Дотоодын хэрэглээний холбооны сүлжээ**

21.1.Аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо ашиглах зориулалтаар дотоодын хэрэглээний холбооны сүлжээ байгуулан ажиллуулж болно.

⁴¹ 17.2.Улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бүрдсэн, нийтийн үйлчилгээнд зориулсан сүлжээг цахилгаан холбооны үндсэн сүлжээ гэнэ.

13. ХАВСРАЛТ

Хавсралт А (Заавал мөрдөх)

Эрх зүйн баримт бичгүүд

- Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хууль 1993 он;
- Хот байгуулалтын тухай хууль 2008 он;
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль 2006 он;
- Барилгын тухай хууль 2016 он;
- Монгол улсын Газрын тухай хууль 2002 он;
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 2002 он;
- Хот суурины газрыг дахин хөгжүүлэх тухай хууль 2015 он;
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 он;
- Харилцаа холбооны тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Усны тухай хууль;
- Автозамын тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- СП 42.13330.2016 Градостроительство. Планировка и застройка городских и сельских поселений;
- БНБД II-60-79 Планировка и застройка городов и поселков;
- БНБД-30-01-04 Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- БД 30-103-21 Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар;
- “Методы расчёта прогнозной численности населения в градостроительном проектировании” Главный инженер проекта, инженер-экономист Т.А.Колянцева, Государственный Строительный Комитет МНР, Государственный Головной Проектный Институт, 1987г.
- “Экономика градостроительства” А.П.Борисов, Э.Я.Бубес, Н.Г.Ревунова. 1981г.
- УББ 30-201-03 Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар;
- БНБД-32-01-04 Хот, суурины гудамж, зам төлөвлөлт;
- БД 30-101-05 Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт;
- БНБД 30-02-07 Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө;
- БНБД-23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын /эзвэрлэлтийн/ хангамж
- БНБД 31-01-10 Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт
- СП 240.1311500.2015 Шингэрүүлсэн байгалийн хийн бага хүчин чадлын үйлдвэрлэл болон хийн ашиглалт. Галын аюулгүй шаардлага;
- СП 326.1311500. 2017 Шингэрүүлсэн байгалийн хийн агуулах. Галын аюулгүй шаардлага;
- Гэрэлтүүлгийн систем Монгол улсын стандарт MNS 4996:2000;
- ИНД-139, ИНД-139.21/ 2008 он Иргэний нисэхийн багц дүрмийн Зөвлөмжийн цуврал, Саадын хяналт;
- ЗЗБНБД 22-004-2016 Автозам төсөллөх Монгол улсын зам, замын байгууламжийн норм ба дүрэм;
- “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар” /Барилга, хот байгуулалтын сайдын тушаал 2001 он, 2008 оны 157;

Хавсралт Б (Заавал мөрдөх)

Нэр томъёоны тодорхойлолт

“хот орчмын нутаг дэвсгэр”- хот, суурины ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон барилгажилтыг хязгаарлах нутаг дэвсгэр;

“хот, суурины эдэлбэр газар” - хот, суурины ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон хотжилтыг дэмжих орон зай, нутаг дэвсгэр;

“гудамж, замын улаан шугам”- хот, суурины ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон гудамж, зам, замын байгууламж болон хот, суурины инженерийн дэд бүтцийн гол сүлжээ бүхий нийтийн хэрэгцээний зориулалтын газрын хязгаар;

“барилгажилтын улаан шугам”- гудамж, замын улаан шугамаас хот, суурины нутаг дэвсгэрийн барилгажилт хүртэлх орон зайн хязгаар;

“орон сууцны хороолол” – Хот, суурины суурьшлын бүсийн **250** хүртэл га талбай бүхий төлөвлөлтийн нэгж;

“гэр сууцны хороолол” – эдэлбэр газартай үндэсний гэр сууц болон нам давхар орон сууц бүхий суурьшлын бүсийн төлөвлөлтийн нэгж;

“орон сууцны бичил хороолол”- орон сууцны хорооллын 60 хүртэлх га талбай бүхий төлөвлөлтийн нэгж;

“орон сууцны бүлэглэл”- орон сууцны бичил хорооллын **5.0** га талбай бүхий төлөвлөлтийн нэгж;

”орон сууц”- хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууц, гэр сууц;

“нийгмийн нөхөн сэргээлт”- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар хот, суурины хүн амын явган аялал, дугуйн аялал, зугаалга болон хүүхэд, залуучууд, насанд хүрэгсэдийн амралт, рашаан сувилал зэрэг байгалийн амралт, сувилал хөгжүүлэх боломжит орон зай, нутаг дэвсгэрийг;

“цэцэрлэгт хүрээлэн, парк”- хотын оршин суугчидад үйлчлэх нөхөн сэргээх зориулалтын соёл үйлчилгээ, биеийн тамир, соёл урлагийн болон бүх төрлийн тоглоом наадгай, үзвэр, үйлчилгээ бүхий цогцолбор, хүний гараар бүтээсэн ногоон орон зай;

“хорооллын цэцэрлэг”- Хорооллын оршин суугчидад үйлчлэх зориулалтын амрах, аялах, тоглох иж бүрэн тохижилт бүхий чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх ногоон оро зай;

“цэцэрлэгт талбай” /сквер/- оршин суугчдын түр амарч, алжаал тайлах зориулалттай 0.15-2.0 га талбай бүхий бичил хорооллын ногоон байгууламж, тохижилт бүхий задгай орон зай;

“цэцэрлэгт гудамж, модот гудамж” /аллей/ - иргэд, оршин суугчид амрах, аялах, алхах зориулалтын зам, талбай, ногоон байгууламж бүхий иж бүрэн тохижуулсан явган хүний хөдөлгөөний зохицуулалттай гудамж;

“явган хүний зам”-Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн 1.2.55-дзааснаар явган зорчигчийн хөдөлгөөнд зориулсан замын хэсгийг. Явган хүний зам нь зорчих хэсэг, унадаг дугуйн замаас хайс, хашлага, хөвөөгөөр тусгаарлагдсан, эсхүл унадаг дугуйн замаас тэмдэглэлээр зааглагдсан байна.

“мопед”- 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй болон 0.25 кВт-аас 4.0 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй **цагт 50 км-ээс ихгүй** техникийн дээд хурдтай хоёр буюу гурван дугуйт тээврийн хэрэгсэл

Хавсралт Д (Зөвлөмжийн)**Д.1 Соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн нормчлол**

Хотын хэмжээний соёл, ахуйн үйлчилгээний нормыг (Н) тодорхойлох үзүүлэлт:

-тухайн үйлчилгээний 1000 хүнд оногдох нэгж хүчин чадлын нэг жил (эсвэл сүүлийн 3-5 жилийн арифметик дундаж)-ийн үзүүлэлтийн тоон мэдээлэл (ΣO);

-харгалзах хүчин чадлын нэгжид үндэслэн тухайн үйлчилгээг үзүүлэх боломж (P).

Тооцооллын томъёолол:

$$H = \Sigma O / P \quad (6)$$

ΣO үзүүлэлт нь физиологийн хэрэгцээний нормын тогтмол тоон утгаас, эсвэл социологийн судалгааны үндсэн дээр тогтоосон тоон хэмжээнээс хамаарна. P үзүүлэлтийн утга нь соёл, ахуйн үйлчилгээний ажиллах горим болон ашиглалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагааны боломжоос хамаарна.

Жишээ нь, Томъёо (6)-д тусгагдсан 1000 хүнд оногдох кинотеатрын суудлын тоо (N_k)-г дараахи байдлаар илэрхийлнэ:

$$N_k = (1000BAП) / (Dnm) \quad (7)$$

Үүнд: B -хүн амын насны ангиллын коэффициент, нэгжээр;

A -кинотеатрт очих хүн амын идэвхийг илэрхийлэх коэффициент, нэгжээр;

P -идэвхитэй нэг хүн жилийн туршид кинотеатрт үзвэр үзэх давтамж, тоогоор;

D -кинотеатруудын нэг жилд ажиллах өдрийн тоо, тоогоор;

n -кинотеатруудын ажиллах ээлжийг илэрхийлэх коэффициент, кино гаралтын тоогоор;

m -кинотеатруудын нэг удаагийн үзвэрийн ачааллын дундаж коэффициент (суудлын дүүргэлт), нэгжээр.

Насны ангиллын коэффициент (B) нь кинотеатраар үйлчлүүлэх боломжит хүн амын тоогоор илэрхийлэгдэнэ. Насны ангиллын коэффициентийг хүн амын насны бүтцийн статистик мэдээлэл эсвэл кинотеатруудын судалгаагаар тодорхойлно.

Үйл ажиллагааны коэффициент (A) нь тухайн насны бүлгийн хүн амын кино театрын үйлчилгээнд хамрагдах түвшинг илэрхийлэх бөгөөд хүн амын санал асуулгын судалгаанд үндэслэн тодорхойлно.

Үйлчилгээний давтамжийн үзүүлэлт (P)-ийг жилийн турш кинотеатрын идэвхтэй үзэгчийн эрчмээр тодорхойлно. Тухайн үзүүлэлтийг өрхийн төсвийн бүтэц, чөлөөт цагийн байдалд дүн шинжилгээ хийх замаар тогтооно.

Томъёо (7)-ийн хуваарьт өгөгдсөн үзүүлэлтүүдийн утгыг кинотеатр, соёлын байгуулагуудын ажиллах горим, журмын талаар гаргасан орон нутгийн шийдвэр, эрхзүйн баримт бичигт заасан хэмжээгээр тодорхойлно.

Энэхүү үзүүлэлтийн тоон утгын үндсэн дээр эхний ээлжийн барилгажилт дуусахад ~~БНБД II-60-75~~-д нормчлогдсон кинотеатрын үзэгчийн суудлын хэрэгцээний нормыг дараах байдлаар тооцоолно:

$$N_k = \frac{1000 \text{ хүн} * 0.9 * 0.85 * 46 \text{ удаагийн үзэлт/жил}}{340 \text{ өдөр} * 6 \text{ удаагийн гаралт} * 0.7} = 25 \text{ суудал/1000 хүн}$$

Соёл, ахуйн үйлчилгээний олон төрлийн барилга байгууламжийн хэрэгцээний тооцоог хүн амын эрэлтэнд үндэслэн үүрэг зориулалт, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр ангилан тодорхойлж, тооцоолно. Эрэлт, хэрэгцээг хүн амын олонхийн оролцоонд түшиглэн олон талт нийгмийн судалгааны үндсэн дээр тодорхойлно. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлыг үүрэг зориулалтаар нь ангилан, эдийн засгийн өгөөжтэй байхаар тогтооно.

Соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн хүчин чадлыг тодорхойлохдоо эдийн засгийн хувьд үр ашигтай, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадварыг харгалзан үзвэл зохино.

Тухайлсан соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн (O) нийт хэрэгцээг тухайн хот, сууринд төрөл бүрээр нь дараахь томъёогоор тодорхойлно:

$$O = N_m * C_m + N_c * C_c + N_v * C_v \quad (8)$$

Үүнд: C_m -хотын нийт хүн амын тоо, мянган хүн;

C_c -соёл ахуйн үйлчилгээний тухайн төрөлд хамаарах хүн амын тоо, мянган хүн;

C_v -түр оршин суугч хүн амын тоо, мянган хүн;

N_m , N_c и N_v -хотын нийт хүн ам, соёл ахуйн үйлчилгээний тухайн төрөлд хамаарах хүн ам, түр оршин суух хүн амд харгалзах соёл ахуйн үйлчилгээний тухайлсан төрлийн хүчин чадлын норм, тоо/1000хүн.

Түр оршин суугчдад зориулсан соёл, ахуйн үйлчилгээний барилга, байгууламжийн хэрэгцээг Монгол улсад тухайн хот суурин орших бүс нутаг, аймаг, орон нутгийн төвүүдэд хамааруулан тооцно.

Олон нийтийн барилгын⁴² тооцооны норм, эдэлбэр газрын хэмжээ⁴³

Хүснэгт Д.2

№	Барилга байгууламжийн нэр	Хэмж нэгж	Ангилал	Нормативт хэмжээ (мянган хүнд)	Эдэлбэр газрын хэмжээ	Тайлбар
0	1	2	3	4	5	6
Нэг. Боловсролын байгууллага						
1.	Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага	Хүүхэд	Хангамжийн түвшин - 88% Үүнд: - ерөнхий -70% - тусгай -3% - эрүүлжүүлэх чиглэл -12% (0-7насны хүүхэд хамрагдана.)	Хотод -100; Орон нутгийн хотод -90; Нэг барилгын хүчин чадлыг: -Олон давхар сууцны хороололд 140-өөс багагүй; - Нам давхар сууц, гэр сууцны хороололд 90-ээс багагүй байхаар тооцно. - Үйлчлэх хүрээ 500м хүртэл	90 хүүхдийн хүчин чадалтай барилгад нэг хүүхдэд -40м2; -140-320 хүүхдэд -35м2; - 560-640хүүхдэд -30м2 байхаар тус тус сонгоно.	1-3 насны хүүхдэд зориулсан барилга байгууламжийн 1 хүүхдэд ногдох табайг 7.5м2- аар авч төлөвлөнө. - Сургуулийн өмнөх насны хүүхдийн тоглоомын талбайг суурьшлын талбайд төлөвлөж болно.
2.	Ерөнхий боловсролын сургууль	Сурагч, ээлж	Бүрэн бус дунд боловсрол (I-IX анги)-д 100% хамруулахаар; Дунд боловсрол (X-XI анги)-д 75%-г хамруулах-аар төлөвлөнө. I-IX ангид 6-15 хүртэл насны; X-XI ангид 16-17 насныхан хамрагдана.	- Хотод - 200 - Орон нутгийн хотод -210 - Үйлчлэх хүрээ 750 м хүртэл	Нэг сурагчид ногдох талбай, м2 -120 сурагч хүртэл - 50; -120-500 хүртэл -60; -500-800 хүртэл - 40; -800-1100 хүртэл -35; -1100-1600 хүртэл -25; -1600-2000 хүртэл -20; -2000-аас дээш -18	- Дотуур байртай сургууль төлөвлөвөл дотуур байранд ногдох хэмжээгээр эдэлбэр газрыг нэмэгдүүлэх ба 0.2га-аас ихгүй байна. - Сургуулийн болон орон сууцны хорооллын биеийн тамир, спортын цогцолборыг нэгтгэл байдлаар төлөвлөж болно.
3.	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр	Ор	Хангамжийн түвшин, хөдөөгийн буюу үйлчлэх хүрээний 1000 хүн тутамд нормоор тогтооно.	- Хотод - 3 - Орон нутгийн хотод - 5	Нэг ор тутамд (оронд) ногдох талбай, м2 -200-500 ор - 65; -500 ба дээш - 45;	-Сургуулийн сургалт үйлдвэрлэлийн бааз, автодром, хот орчмын бүсэд төлөвлөнө.
	Ерөнхий боловсролын сургуулийн олон нийтийн байгууллага		Нийт сурагчдын 10-аас доошгүй хувь хамрагдана. Үүнд: -Хүүхдийн ордон -3.3%; -Залуу техникчдийн ордон -0,9%;			

⁴² Олон нийт, иргэний барилга БНБД 31-03-03/*11; Хавсралт 1

- А. Сургалт хүмүүжил
- Б. Шинжлэх ухаан, олон нийт, аж ахуйн барилга
- В. Эмнэлэг, амралт сувилал, спортын барилга
- Г. Худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний барилга
- Д. Тээвэр, холбооны барилга
- Е. Олон зориулалттай барилга, өрөө тасалгаа

⁴³ БД 30-101-05 Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт, Хавсралт 3

4.		Хүүхэд	-Залуу байгальчдын ордон -0,4%; -Хүүхэд-залуучуудын биеийн тамирын сургууль - 2,3%; -Хүүхдийн урлагийн эсвэл хөгжмийн сургууль, бүжгийн сургууль -2.7%	Зураг төслийн даалгавараар	Зураг төслийн даалгавараар	Орон нутгийн хотуудад сургуулийн барилгын цогцолбороор төлөвлөхийг зөвшөөрнө.
5.	Мэргэжлийн сургалтын төв	Суралцагч	Зураг төслийн даалгаврын дагуу	-Хотод -18 -Орон нутгийн хотод - 9	Нэг суралцагчид ногдох талбай, м2 300 хүртэл - 75м2 300-900 хүртэл - 55 900-1600 хүртэл- 40 1600 ба дээш - 30	-Эдэлбэр газрын хэмжээг сургалтын ангиллаас хамааруулан нийгмийн ухааны сургуульд гучин хувь хүртэл багасгах ба хөдөө аж ахуйн сургуульд 10-15 хувь хүртэл нэмэгдүүлж болно. Гэхдээ ХАА-н чиглэлийн сургуулийн сургалт, үйлдвэрлэлийн баазыг хот орчмын бүсэд төлөвлөхийг зөвшөөрнө.
6.	Их, дээд сургууль	Оюутан	Сургалтын бүх чиглэлээр тухайн орон нутгийн онцлогт тохируулан сонгоно.	- Хотод -12 - Орон нутгийн хотод - 6	Мянган оюутанд ногдох сургалтын бүс, га: - 0.5 хүртэл - 4.0; - 0.5-1.0 - 3.5; - 1.0-2.0 - 3.2; -2.0 ба дээш - 3.0;	Сургалтын бүсийн эдгээр талбайг: - Техникийн 4 – 7; - Хөдөө аж ахуйн 5 – 7; - Анагаах ухаан, эм зүй 3 – 5; - Эдийн засаг, сурган хүмүүжүүлэх, соёл урлаг, архитектурын 2– 4; - Мэргэжил дэвшүүлэх ба энэ дээд сургуулийн эдэлбэр газрыг 0.5 итгэлцүүрээр үржүүлэх ба спортын бүсийг 1-2, оюуны нийтийн байрыг 1.5-3 гэсэн итгэлцүүрээр үржүүлж тооцож төлөвлөнө.
Хоёр. Эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага						
7.	Эмнэлэг (хэвтэж эмчлүүлэх)	Ор	Нэгдсэн эмнэлэг, Халдвартын эмнэлэг, Төрөх эмнэлэг Хүүхдийн эмнэлэг г.м Эмнэлэг-эмчилгээний байгууллагын багтаамж, бүтцийг эрүүл мэндийн байгууллагаас тогтоож, түүнийг нь зураг төсөл боловсруулах даалгаварт тусгана	Хотод -9; Орон нутгийн хотод -8; Үйлчлэх хүрээ 2 км	Нэг оронд ногдох талбай; м2 - 50 ор хүртэл - 300; - 50-100 ор 300-200; - 100-200 ор 200-140; - 200-400 ор 140-100; - 400-800 ор 100- 80; - 800 дээш ор 60. Хэвтэн эмчлүүлэх асрамж сувилалын хүчин чадал нь ор: 50 хүртэл бол 1 оронд 210 м2; 50-100 бол 210-160; 100-200 бол 260-110; 200-300 110-80; 300- 500 80-60; >> 500 бол 60>>	- Бүх эмнэлэгт хүүхдийн орны нормыг 1.5 итгэлцүүрээр үржүүлж төлөвлөнө. - Хоёроос дээш эмнэлэгийг нэг эдэлбэр газарт байршуулахдаа нийлбэр нормыг хэрэглэнэ. - Хотын төвд байрлах эмнэлгийн хувьд эдэлбэр газрын хэмжээг 25% хүртэл бууруулж төлөвлөхийг зөвшөөрнө. - Хот орчмын бүсэд байршуулбал эмчилгээний чиглэлээс хамааруулан эмнэлгийн эдэлбэр газрын хэмжээг нэмэгдүүлнэ. Үүнд: - Халдварт -15% - Хавдар судлал -15% - Сүрьеэ (туберкулез) -25% - Сэтгэл судлал -25% - Насанд хүрэгсдийн нөхөн сэргээх

Хот, суурины төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /30-01-24/

2024 он

						эмчилгээ -20% - Хүүхдийн нөхөн сэргээх эмнэлэг -40% Төрөх эмнэлэгийн эдэлбэр газрын хэмжээг 0.7 коэф-оор нэмэгдүүлж төлөвлөнө.
8.	Өрхийн эмнэлэг (амбулатори, поликлиник)	Үзлэг /өдөр	-Дотрын (общий) -Шүдний -Гэмтлийн эмнэлэг г.м Үйлчлэх хүрээ 500-750м	-Хотод -35; -Орон нутгийн хотод -26	100 хүн үзэгдэрт 0.1га байх ба 0.3 га-аас ихгүй байна.	-Нэгдсэн эмнэлэгт болон орон сууцны байрны нэгдүгээр давхарт үйлчил-гээний хэлбэрээр байршуулж болно.
9.	Эмнэлэгийн түргэн тусламжийн станц	автомашин	Үйлчлэх хүрээ: -Тусгай зориулалтын автомашинаар 15 минутад хүрэх зайд	10 мянган хүнд -1 автомашин	Нэг автомашинд 0.05 га гэхдээ 0.1 га-аас бага байж болохгүй.	
10.	Эмнэлэгийн түргэн тусламжийн явуулын цэг		- Тусгай зориулалтын автомашинаар 30 минутад хүрэх зайд	5 мянган хүнд -1 автомашин	Нэг автомашинд 0.05 га гэхдээ 0.1 га-аас бага байж болохгүй.	Хоторхуу суурины хүн амд үйлчлэнэ.
11.	Мал эмнэлэг, эмчилгээний төв	-	Зураг төсөл боловсруулах даалгавараар		0.2 га	
12.	Эмийн сан	Объект	I-II III-V VI-VIII бүлэг	Зураг төслийн даалгавраар	I-II - 0.3 га III-V - 0.25 га VI-VIII - 0.2 га	- Эмнэлэгийн барилгад нэг дээвэр дор болон үйлчилгээний барилга (худалдаа, зочид буудал)-тай хамт 1 давхарт төлөвлөхийг зөвшөөрнө.
13.	Хүүхдийн сүүний газар	Порц /хоног хүүхэд	- бэлтгэх газар - түгээх цэг	4	1000 порц тутамд 0.015 га байх ба 0.15 га-аас бага байж болохгүй	Түгээх цэг үйлчилгээтэй хамт байж болно. 1 порц нь 250 гр сүү, тараг, хүүхдийн тэжээлийн бэлдмэл байна
14.	Сувилал, амралтын газар	Ор	- сувилал (сүрьеэгийн өвчтөнгүй)	-	125-150 м ² 1 оронд	
			Хүүхэдтэй гэр бүлд зориулсан сувилал	-	145-170 >>>>	(сүрьеэгийн өвчтөнгүй)
			Хүүхдийн амралт - сувилалын газар	-	200 >>>>	
			Амралтын газар (пансионаты)	-	120-130 >>>>	
			Хүүхэдтэй гэр бүлд зориулсан амралтын газар (пансионаты)	-	140-150 >>>>	
			Албан байгууллагын болон залуучуудын амралтын газар	-	140-160 >>>>	
			Амралт, зочид буудал	-	1 оронд 65-75 м ²	
			Хүүхдийн зуслан	-	150-200 >>>>	
			Ахлах ангийн сурагчдын эрүүл мэнд бялдаржуулах амралтын газар	-	175-200 >>>>	
15.	Жуулчны бааз	Ор	Сургуулийн өмнөх насны хүүхдийн амралтын газар	-	120-140 >>>>	
			Жуулчдад зориулсан зочид буудал	-	65-80 >>>>	
			Гэр бүлийн жуулчны зочид буудал	-	50-75 >>>>	Хотын олон нийтийн төвүүд дэх жуулчдад зориулсан зочид буудлын газрын хэмжээг нийтийн зочид буудлын нормоор тогтоож болно.
			Явуулын дэн буудал, гэр буудал	-	95-120 >>>>	
			Кемпинг	-	75-100 >>>>	
					135-150 >>>>	

Хот, суурины төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /30-01-24/

2024 он

	Асрамжийн газар	Ор	- Өндөр настны - Ахмад дайчид, алдартан, гавьяатнуудын (60 нас) - Насанд хүрэгсэдийн - Хүүхдийн (4-17 нас) - Сэтгэл мэдрэлийн (18 наснаас)	Тэтгэврийн насны 1000 хүнд -28; Насанд хүрсэн 1000 хүнд -3; 4-17 хүртэлх насны 1000 хүнд - 3	Нэг оронд ногдох талбай; м2 - 200 хүртэл -125 - 200-400 хүртэл -100 - 400 дээш - 80	
16.	Биеийн тамир спортын барилга байгууламж	м ² шалны талбай	Цогцолбор Үйлчлэх хүрээ: Хотын чанартай биеийн тамир, спортын танхимд хүрэх зам тээврийн боломж 30 минутаас хэтрэхгүй байна.	-бичил хороололд 70-80; -Нийтийн зориулалттай биеийн тамирын заал 60-80; 200 (талбай 540м2-аас хэтрэхгүй) Хот маягийн сууринд 175; Хоторхуу сууринд 150;	1000 хүнд 0.7-0.9 га	-Ерөнхий боловсролын сургууль, соёл амралтын байгууллагын спорт, биеийн тамирын танхимтай нэгтгэж болно.
17.	Бассейн	м ² усан толь	Хотод	1 мянган хүнд: 20-25	Зураг төслийн даалгавраар	Спорт заал, бассейныг нэг дор төлөвлөхийг зөвшөөрнө. 2- 5 мянга хүртэл хүн амтай сууринд 540 м ² талбайтай спорт заал байхаар тооцно
			Сууринд	Биеийн тамирын заал	Бассейн	
			100-аас дээш	120	50	
			" 50 до 100	130	55	
			" 25 " 50	150	65	
			" 12 " 25	175	80	
" 5 " 12	200	100				
Гурав. Соёл, урлагийн газар						
18.	Олон нийтийн байгууллага	м2 шалны талбай		50-60	0.6 га хүртэл (1 объект)	- Соёл олон нийтийн цогцолбор- ыг 500м-ийн үйлчлэх радиуст төлөвлөнө.
19.	Чөлөөт цагийн клуб	м2 бүжгийн талбай		50-60	-	
20.	Клуб	Суудал/ мян.хүн	Хотод	80	-	Сурагчид болон нийт оршин суугчдын явганаар зорчих зай500м байхаар (нормативын дундажаар) цогцолбор барилга барихыг зөвшөөрнө. Бүжгийн танхим, кинотеатр, клуб болон соёлын байгууллагын эзлэхүүнийг 40-50% байхаар тооцно. Цирк, концертын заал, театр ба одон орон судлалын төвийг 250 000-аас дээш хүн амтай хот, сууринд, кинотетрыг 10 000 гаруй хүн амтай сууринд төлөвлөнө. Хиймэл мөсөн талбайтай спорт-үзвэрийн өвөрмөц дэглэлттэй заалыг 100000-аас дээш хүн амтай хот-төвүүдэд төлөвлөнө.
			Сууринд:		-	
			0,2-оос дээш 1 хүртэл	500-300	-	
			" 1 " 2	300-230	-	
			" 2 " 5	230-190	-	
21.	Кинотеатр	суудал	-	25-35	-	
22.	Театр	суудал	-	5-8	-	
23.	Концертын танхим	суудал	-	3.5-5	-	
24.	Цирк	суудал	-	3.5-5	-	
25.	Лекцийн танхим	суудал	-	3	-	
26.	Музей, үзэсгэлэн	үзвэрийн талбай	-	20	0.1-0.2 га объект	
27.	Автомат тоглоомын газар (Компьютер тоглоом)	м2 шалны талбай	-	3	-	
28.	Өвөрмөц үзвэрийн заал, мөсөн талбайтай	м2 шалны талбай	-	1 мянган хүнд 6-9	Зураг төслийн даалгавараар	
29.	Номын сан	Мян. хадгалалтын нэгж /суудал/	-	4/2 4-4.5/2-3	-	-

Дөрөв. Худалдаа нийтийн хоол, ахуй үйлчилгээний газар						
30.	Дэлгүүр худалдааны байгууллага, 1 мянган хүн	м2 худалдааны талбай	Хот		Суурин	
			Орон нутгийн чанартай худалдааны төв		280 (100)*	300
	- Хүнсний дэлгүүр		100 (70)*(6)		100	
	- Аж үйлдвэрийн барааны 200 дэлгүүр		180 (30)*(6)		200	
31.					Орон нутгийн чанартай худалдааны төв үйлчлүүлэгчдийн тоо, мянган хүн, 1 объектод: 4.0-6.0 мян.хүнд -0.4-0.6 га; 6.0-10.0 бол -0.6-0.8 га; 10.0-15.0 бол -0.8-1.1 га; 15.0-20.0 бол -1.1-1.3 га; - Сууринд 1 объектод: 1.0 хүртэл -0.1-0.2 га; 1.0-3.0 бол -0.2-0.4 га; 3.0-4.0 бол -0.4-0.6 га; 5.0-6.0 бол -0.6- 1.0 га; 7-10 бол -1.0-1.2 га; - Худалдааны төвийн хүчин чадлаас хамааран 100м ² худалдааны тал- бай тутамд: 250 м2 хүртэл 0.08 га; 250-650 м2 -0.08-0.06 га; 650-1500м2 -0.06-0.04 га; 1500-3500 м2 -0.04-2.0га; 3500 м2 дээш -0.02 га	Захиалгат барааны дэлгүүр, хоршооллын дэлгүүрт тогтоосон нормоос гадна 1000 хүн тутамд ойролцоогоор 5-10м2 худалдааны талбайгаар нэмэгдүүлж зураг төслийн даалгаварт тооцно. -Газар тариалан, ногооны аж ахуйн сууринд хүнсний дэлгүүрийг 1000 хүнд 80 м2 худалдааны талбайгаар нэмэгдүүлж тооцно. Нормд аж ахуйн барааны дэлгүүрийн тооцоонд комиссын барааны дэлгүүрийн худалдааны тооцоог 1 мянган хүнд 10м2 байхаар тооцно.
32.	Худалдааны захын цогцолбор	м2 худалдааны талбай, мянган хүн	Зөвхөн хот, суурин газарт	24-40	7-14 м ² багтаамжтай байгаагаас хамааран м ² худалдааны талбайд: 14 м2 бол 600 м ² ; 7 м2 дээш бол 3000 м ²	- Худалдааны захын цогцолборт нэгж худалдааны байрыг 6 м2 худалдааны талбайгаар тооцно.
33.	Нийтийн хоолны газар	1 мян.хүн суудал	Зөвхөн хот, суурин газарт	40	Хүчин чадлаас хамааран 100 суудал тутамд: 50 хүртэл бол -0.20-0.25 га; 50-150 хүртэл -0.2-0.15 га; 150 ба дээш -0.1 га	-Рашаан сувилал, аялал жуулчлалын хотуудад рашаан сувилалыг (1 мянган хүн) -90 хүртэл суудал байхаар төлөвлөнө.
34.	Хагас бэлэн бүтээгдэхүүний худалдаа	м2 худалдааны талбай	Зөвхөн хот, суурин газарт	6		-Нэг дээвэр дор үйлчилгээ худалдаатай хамт төлөвлөхийг зөвшөөрнө.
35.	Ахуйн үйлчилгээний төв	Ажлын байр 1 мян.хүнд	Хот, сууринд	9 5 4	7 4 3	-Худалдаа үйлчилгээний төвийн барилгад төлөвлөнө. -Томоохон үйлдвэрлэлд ажлын байрыг 5-10% нэмэгдүүлж болно.
36.	Угаалга, хими цэвэрлэгээ	кг хувцас цагаан хэрэглэл/ ээлж	Зөвхөн хот сууринд	120	60	1 объектод 0.1-0.2 га Хөдөөгийн тосгонд зочид буудалтай нэг дор байж болно
37.	Халуун ус	Шүршүүр	Хот, сууринд	5	7	1 объектод 0.2-0.4 га Хөдөөд улирлын чанартай ажиллана.
Тав. Удирдлага, бизнес үйлчилгээний байгууллага						
